Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Барилга, хот байгуулалтын яам

2021 оны жилийн эцэс

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | |
| 1 | 1 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2011-02-02 Дугаар 2011.02.02 | 19.1.9. Төрийн захиргааны төв байгууллага жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг Жендэрийн үндэсний хороонд дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх. | БХБЯ, ГЗБГЗЗГ-ын албан хаагчдын 2020 оны хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, БХБЯ-ны дэргэдэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Жендерийн үндэсний хороонд 2021 оны 01 дүгээр сарын 07-нд хүргүүлсэн. | 100% |
| 2 | 2 | Хөрөнгө оруулалтын тухай 2013-10-03 Дугаар 2013.11.01 | 11.2.1. Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих;<br>(11.2.Доор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:) | Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг сайжруулахад шаардагдах зээл олгох хүсэлтийг тус яамнаас Хөгжлийн банкинд уламжилсан. Хөгжлийн банкнаас судалж байна гэсэн хариу өгсөн. Цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх бодлогыг хэрэгжүүлэхийн тулд эдгээр чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч 3 компанийг сонгон, цементийн чиглэлээр “Вестерн холд” ХХК, арматурын чиглэлээр “Бэрэн металл” ХХК, шилний чиглэлээр “Эрдэс плазм” ХХК-иудын төслийг хамгийн хэрэгжих боломжтой төсөл гэж үзэж, салбарын яамнаас бүх талаар дэмжин ажиллаж байна. Мөн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй цемент, арматурын үйлдвэрүүдийн гадаад ажиллах хүчний асуудлыг ХНХЯ-нд уламжилж, БНХАУ-аас мэргэжилтнүүд ирж ажиллан үйл ажиллагааг жигд явуулсан.<br>Тээвэрлэлтийн асуудлыг УОК, ЗТХЯ, ГХЯ-нд хүсэлт хүргүүлж, хөл хорионы үеэр тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг зөвшөөрүүлсэн. Мөн импортын тоног төхөөрөмж, түүхий эдийг хилээр нааш нь татахад дэмжлэг үзүүлсэн гэх мэт бүх талаар дэмжин ажилласнаар бүх үйлдвэр ажиллаж, цементийн үнийг тогтвортой барьсан. 2020 онд 4 цементийн үйлдвэр ажиллаж, 1182.247 тонн цемент үйлдвэрлэсэн бол 2021 онд 5 цементийн үйлдвэр ажиллаж, 1253.3 мянган тонн цемент, 2020 онд 15.3 мянган тонн ган бэлдэц, 16 мянган тн ган цувимал үйлдвэрлэсэн бол 2021 онд 33.5 мян.тн ган бэлдэц, 33,04 мянган тонн ган цувимал үйлдвэрлэсэн. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийн барилгын ажлыг дуусгасан. | 100% |
| | 3 | | 11.2.2. Нано, био болон инновацийн технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих;<br>(11.2.Доор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:) | - Барилгын материалын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн, түүхий эд, тоног төхөөрөмжийг саадгүй тээвэрлэх талаар санал боловсруулан УОК-д 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 1/612 тоот албан бичгээр, БМҮ-ийн ханган нийлүүлэлт, ажиллах хүчний талаар, хамтран шуурхай ажиллах саналыг НОК-ийн дарга УБ хотын захирагч Д.Сумъяабазарт, 2021 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 1/1349 тоотоор, компаниудын хүсэлтийг 2021 оны 3 дугаар сарын 1-ний 3/732 тоот, 3 дугаар сарын 18-ны 3/967 тоотуудаар хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>- Импортын барилгын материалын талаар ЗТХ-ийн сайд Л.Халтарт 2021 оны 3 дугаар сарын 17-ны 1/949 тоотоор, Монгол-Оросын ХНН, УБ төмөр зам”-ын дарга Д.Жигжиднямаад 3 дугаар сарын 17-ны 1/950 тоотоор тус тус саналыг хүргүүлсэн.<br>Мөн Гаалийн Ерөнхий газарт барилгын материалын үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг хилээр шуурхай нэвтрүүлэх тухай хүсэлтийг 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 3/1451 тоотоор хүргүүлсэн.<br>- Импортын барилгын материал, түүхий эдийн тээвэрлэлтийг хурдасгах, боомтоор түргэн шуурхай нэвтрүүлэх талаарх хүсэлтийг Дорноговь аймгийн Замын-Үүд сумын гаалийн газарт болон Боомтын зөвлөлд 2021 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 3/3570 тоотоор хүргүүлсэн.<br>Хилээр яаралтай нэвтрүүлэх шаардлагатай барилгын материал, сэлбэг хэрэгсэлийн жагсаалтыг БТКУС-ийн кодоор гаргаж, Гадаад харилцааны дэд сайд Б.Мөнхжинд 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 2/4467 тоотоор хүргүүлсэн.<br>Ингэснээр барилгын материалын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн, түүхий эд, тоног төхөөрөмжийг хилээр төмөр зам болон авто тээврийн хэрэгслээр тээвэрлэх асуудлыг шийдвэрлээд байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | 4 | Соёлын өвийг хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ 2014-05-15 Дугаар 2014.05.15 | 47.2. Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | -Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай хамтран Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төслийн төгсгөлийн тайланг хүлээн авсан. Уг тайланд Улсын хамгаалалтад байх 185, БСШУС-ын сайдын 2020 оны А/161 тоот тушаалаар баталсан аймаг, нийслэлийн хамгаалалтад байх 607, сум, дүүргийн хамгаалалтад байх 3739 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад дүн шинжилгээ хийхэд тэдгээрээс нийт 354 дурсгал нь барилга, архитектурын дурсгал байна.<br>- Нийслэлийн хэмжээнд 2012-2020 оны хугацаанд нийт 725 барилга байгууламжийг паспортжуулаад байна. Үүнээс нийт паспортжуулалт хийсэн барилга байгууламжаас хүчитгэх шаардлагатай 120 барилга байгууламж байна. Үүнээс орон сууцны 80, олон нийтийн 40 барилга байгууламж байна.<br>Олон нийтийн 40 барилгаас түүх соёлын дурсгалт 4 барилга байгууламж байна. /Богд хааны ордон музей, Чойжин дагнины ордон музей, Улсын драмын эрдмийн театр, Дуурь бжгийн эрдмийн театр/.<br>Түүнчлэн төслийн үр дүнд барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр дараах дүрэм журмыг боловсруулж Барилга, хот байгуулалтын сайд болон Соёлын сайдаар хамтарсан тушаалаар батлуулах тухай 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 1/5105 тоот албан бичгийг Соёлын сайдад хүргүүлсэн. Үүнд:<br>- Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журам;<br>- Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ;<br>- Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар, үйл ажиллагааны журам.<br>БХБ-ын яамнаас шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. | 100% |
| | 5 | Барилгын тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-02-05 Дугаар 2016.02.05 | 14.9. Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг тогтоох дүрмийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | "Барилгын бүтээц ба буурийн найдваршил. Ерөнхий шаардлага" стандартыг боловсруулах ажлын техникийн даалгаврыг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 26/2018 дугаараар баталсан.<br>-"Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг тогтоох дүрэм"-ийн төслийг ГОСТ 27751-2014 "Надежность строительных конструкций и оснований. Основные положения"-ийг суурь материал болон "Барилгын бүтээц ба суурийн найдваршил, Ерөнхий шаардлага" MNS 2111:1982 болон Барилга, хот байгуулалтын сайдын 2020.12.10-ны өдрийн 231 дүгээр тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний засвар ашиглалтын хугацааны жишиг норм" /БД 13-104-20/-ийг тус тус үндэслэн боловсруулсан. Төслийг яамны цахим хуудаст байршуулж, олон нийтээс санал авч байна. | 70% |
| | 6 | | 42.4. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журмыг Засгийн газар батална. | “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам”-ыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 343 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. | 100% |
| | 7 | | 24.6. Барилгын үнэ бүрдлийн дүрэм, төсөв зохиох аргачлалыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНбД 81-94-12/-ийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалаар баталсан.<br>Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолоор "Барилга байгууламжийн норм нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо" шинэчлэн батлагдсан. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 58 дугаар тушаал "Барилгын бүтээц ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах, хэрэглэх дүрэм" /БНбД 81-10-18/, 2020 оны 30 дугаар тушаалаар "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНбД 81-95-12*2020/ тус тус шинэчлэн батлагдсан.<br>"Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНбД 81-94-12/-ийг шинэчлэх ажлыг Барилга байгууламжийн норм нормативын сангийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, барилгын эдийн засаг, төсөв, үнэ бүрдлийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар техникийн даалгаварыг хэлэлцүүлэн дэмжигдсэн. Зөвлөлийн гишүүдээс ирсэн санал, зөвлөмжийг тусган Барилгын хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 1/3384 тоот албан бичгээр ирүүлсэнийг хянан, батлуулахаар ажиллаж байна. | 100% |
| | 8 | | 32.1.6. Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийг батлах;<br>(32.1.Засгийн газар барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор "Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм"-ийг баталсан. | 100% |
| | 9 | | 32.1.7. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийг батлах;<br>(32.1.Засгийн газар барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг шинэчлэн баталсан. | 100% |
| | 10 | | 32.1.8. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийг батлах;<br>(32.1.Засгийн газар барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг шинэчлэн баталсан. | 100% |
| | 11 | | 32.1.9. Барилгын ажлын захиалагчийн дүрмийг батлах;<br>(32.1.Засгийн газар барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийг баталсан. Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 12 | 32.1.10. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийг батлах;<br>(32.1.Засгийн газар барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм"-ийг шинэчлэн баталсан. | 100% |
| | 13 | 33.1.2. Энэ хуулийн 5.1.1, 5.1.2-т заасан барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)<br>(5.1.1.барилгын норм, дүрэм; 5.1.2.барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал;) | Барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа барилгын норм ба дүрэм-184, барилгын дүрэм-129, техникийн дүрэм-16, заавар-6, цомог-5 тус тус байна. | 100% |
| | 14 | 33.1.3. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 213 дугаар тушаалаар " Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам"-ыг шинэчилэн баталсан. | 100% |
| | 15 | 33.1.5. Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн журам батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 65 дугаар тушаалаар "Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн журам"-ыг баталсан. | 100% |
| | 16 | 33.1.7. Барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн бодлогыг боловсруулж батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор "Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого"-ыг баталсан. Тус бодлогын баримт бичигт барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн бодлогыг тусгасан. Бодлогын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж тайлагнаж байна. | 100% |
| | 17 | 33.1.8. Барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн ажиллах журам батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | БХБС-ын 2016 оны 42 дугаар тушаалаар "Барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн ажиллах журам"-ыг баталсан.<br>"Барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн ажиллах журам"-ын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2021.04.12-ны өдрийн 84 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс журмын шинэчилсэн төслийг боловсруулж ШУТТЗХ-аар 2021.11.09-ний өдөр хэлэлцүүлж гишүүдийн өгсөн санал, зөвлөмжийг тусган Сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. | 100% |
| | 18 | 33.1.9. Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм"-ийг баталсан. | 100% |
| 4 | 19 | 33.1.10. Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, үнийн индекс барилгын ажилтны тарифт цалинг батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 203 дугаар тушаалаар баталсан "Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ"-г шинэчлэн боловсруулахаар техникийн даалгаварыг батлуулан БХТ-д хүргүүлсэн. Зөвлөх сонгон шалгаруулах тендер зарласан.<br>Барилга байгууламжийн жил бүрийн үнийн индексийн Сангийн яамтай зөвшилцөн баталдаг ба 2021 оны үнийн индексийг боловсруулан, яамны дэргэдэх ШУТТЗ-ын 2021 оны 12 дугаар сарын 28-ны хурлаар хэлэлцэж дэмжсэн. БХБ-ын яамнаас Сангийн яаманд албан бичиг хүргүүлсэн.<br>Барилгын ажилтны тарифт цалингийн жишгийг 2019 оны 2017 дугаар тушаалаар шинэчлэн баталж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. | 100% |
| | 20 | 33.1.11. Туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрмийг батлан, удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны А/193 дугаар тушаалаар "Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрэм"-ийг баталсан. | 100% |
| | 21 | 33.1.12. Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | БХБС-ын 2016 оны 160 дугаар тушаалаар "Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ыг баталсан.<br>"Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2021.04.12-ны өдрийн 84 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс журмын шинэчилсэн төслийг боловсруулж ШУТТЗХ-аар 2021.11.09-ний өдөр хэлэлцүүлж гишүүдийн өгсөн санал, зөвлөмжийг тусган Сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | 33.1.13. Барилга байгууламжийн цахим тооцооллын программ хангамжийг баталгаажуулж, хэрэглэх журмыг батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 268 дугаар тушаалаар "Барилга байгууламжийн цахим тооцооллын программ хангамжийг баталгаажуулж, хэрэглэх журам"ыг баталсан. | 100% |
| 23 | 33.1.14. Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах журам батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | БХБ-ын сайдын 2021.06.15-ны өдрийн 139 дүгээр тушаалаар “Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах журам”-ыг шинэчлэн баталсан. | 100% |
| 24 | 33.1.15. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 147 дугаар тушаалаар "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам"-ыг шинэчлэн баталсан. | 100% |
| 25 | 33.1.16. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олголт, барилга байгууламжийн чанар, паспортжуулалт, ашиглалт, бүртгэлийн асуудлаар аймаг, нийслэлийн Засаг даргын тайланг хэлэлцэх;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилга, хот байгуулалтын сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2021 оны гэрээний хэрэгжилтэд БХБ-ын яамны ХШҮДАГ-аас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж гаргаж аймаг тус бүрт хүргүүлсэн. | 100% |
| 26 | 33.1.17. Улсын хэмжээнд барилгын талаар нэгтгэж гаргах салбарын бүртгэл, мэдээллийн маягтыг Бүртгэл, статистикийн үндэсний хороотой хамтран батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | “Салбарын бүртгэл, мэдээллийн маягт, нөхөх заавар”-ыг Барилга, хот байгуулалтын сайд болон Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 206, А/184 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>“Салбарын бүртгэл, мэдээллийн маягт, нөхөх заавар”-ын З-БА-1, З-БА-2, З-ЗТ-1, З-ӨБ-1, З-ИГ-1, З-НАА-1, З-НАА-2, З-БМ-1, З-БМ-2 нийт есөн маягтыг барилгын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйл ажиллагааны тайлан, мэдээг цахимаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн. | 100% |
| 27 | 33.1.18. Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмыг батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Барилга байгууламжийн хувийн хэрэг”-ийг тус тус баталсан. | 100% |
| 28 | 33.1.19. Экспорт, импортын барилгын материал, тоног төхөөрөмж, машин механизм, түүхий эдийн бүртгэлийн “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийг жил бүр холбогдох байгууллагатай хамтран өргөтгөн боловсронгуй болгох;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилгын материал, түүхий эдийн импортын нөхцөл байдалд хяналт тавьж, бодлого боловсруулахад ашиглах зорилгоор Гаалийн ерөнхий газраас экспорт, импортын мэдээг тогтмол авч ажиллаж байна. Импортын барилгын материалын чанарт хяналт тавих зорилгоор “Тохирлын гэрчилгээ” авах жагсаалтад хамрагдсан 160 нэрийн барилгын материалын үйлдвэрлэл, импортын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх шаардлагатай болсон тул Гаалийн ерөнхий газарт 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 3/1761 тоотоор хүсэлт хүргүүлэн холбогдох мэдээллийг авч, дотоодын үйлдвэрийн түүхий эдүүдийг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн дагуу ангилан судалгаа гаргасан. | 100% |
| 29 | 33.1.20. Барилгын үйл ажиллагаанд мөрдөх гэрээний загвар батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилгын үйл ажиллагаанд мөрдөх гэрээний загварыг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Пи Си Ди Пи” ХХК шалгарсан. Тус компаниас гэрээний төслийг боловсруулж дуусган яаманд ирүүлсэн. Тус төслийг Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 30 | | 33.1.21. Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм"-ийг баталсан. | 100% |
| | 31 | | 33.1.22. Барилгын үйл ажиллагаанд холбогдсон зөвшөөрөл олгох хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх болон барилгын салбарт нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх нийтлэг журам батлах;<br>(33.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага барилгын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 147 дугаар тушаалаар "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээр хяналт тавих журам"-ыг баталсан. Тус журамд барилгын үйл ажиллагаанд холбогдсон зөвшөөрөл олгох хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх, хүсэлтийг шийдвэрлэх, цахим системд оруулах мэдээлэлд тавих шаардлагыг тусгасан. | 100% |
| 5 | 32 | Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-05-12 Дугаар 2017.05.12 | 8.2.1. 8.2.Хог хаягдлын талаар зам тээвэр, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.2.1. Тээврийн хэрэгслийн болон барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих; | Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 48 дугаар тушаалаар “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг баталсан. ХЗДХЯ-нд 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 03/742 тоотоор хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4731 дугаарт бүртгүүлсэн | 100% |
| 6 | 33 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 61.2. Энэ хуулийн 61.1.5-д заасан баталгааг эдлүүлэхтэй холбогдсон журмыг Засгийн газар тогтооно.<br>(61.1.5.орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх;) | Засгийн газрын 2020 оны 185 дугаар тогтоолоор “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд албан үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагчдад зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг тогтоолын хүрээнд 2020 онд “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн охин компани болох “НОСК НЭГ ТЗК” ХХК-иар дамжуулан 34.5 тэрбум төгрөг түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 420 орон сууцыг худалдан авч 420 албан хаагчийг орон сууцжуулаад байна.<br>2021 онд “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн охин компани болох “НОСК ХОЁР ТЗК” ХХК-иар дамжуулан 39.6 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 447 айлын орон сууцыг худалдан авч 447 албан хаагч, “НОСК ГУРАВ ТЗК” ХХК-иар дамжуулан 26 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 310 айлын орон сууцыг худалдан авч 310 албан хаагч, 50.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүрээнд түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган 757 албан хаагчийг орон сууцжуулаад байна. Нийт 2020 болон 2021 онуудад нийт 1177 төрийн албан хаагчийг 99.9 тэрбум ₮-ийн үнийн дүн бүхий орон сууцанд хамруулаад байна. Үүнээс 1025 нь нийслэлд 152 нь орон нутагт байна. | 100% |
| | 34 | | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3-д заасны дагуу "Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/70 дугаар тушаалаар баталсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. | 100% |
| 7 | 35 | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай 2018-05-10 Дугаар 2019.01.01 | 2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан барааны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.<br>(1 дүгээр зүйл.Импортоор оруулж байгаа гуалингаас бусад бүх төрлийн түлшний зориулалтын мод, тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийг гаалийн албан татвараас 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд тус тус чөлөөлсүгэй.) | "Засгийн газрын 2019 оны 101 дүгээр тогтоолоор гаалийн албан татвараас “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу дараах мод, модон материалыг чөлөөлсөн. Үүнд:<br>• 4401.11.00 Шилмүүст төрлийн, урт хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 6см<; урт 2.20м)<br>• 4401.11.00 Шилмүүст төрлийн, хэрчим, цуулж хагалсан хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 15см-ээс дээш, урт 0.25м; 0.3м; 0.5м; 0.75м)<br>• 4401.12.00 Навчит төрлийн, урт хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 6см<; урт 2.20м)<br>• 4401.12.00 Навчит төрлийн, хэрчим, цуулж хагалсан хэлбэрийн түлшний мод; (нарийн үзүүрийн голч 15см-ээс дээш, урт 0.25м; 0.3м; 0.5м; 0.75м)<br>• 4410.12.00 Тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан; (OSB)<br>• 9406.10.30 Стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийц.<br>2019 онд 43,504.80 мянган ам.доллар, 2020 онд 43,384.80 мянган ам.доллар, 2021 оны эхний 4 сарын байдлаар 11,502.88 мянган ам.долларын мод, модон материал импортлогдож татварын хөнгөлөлтөд хамрагдсан байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | 36 | Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29 | 7.1.3. Эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчид зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй ипотекийн зээлийн тусгай бүтээгдэхүүний хүүгийн татаасаар Төв банканд дэмжлэг үзүүлэх;<br>(7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:) | Засгийн газрын 2020 оны 185 дугаар тогтоолоор "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд албан үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагчдад зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг тогтоолын хүрээнд 2020 онд "Нийслэлийн орон сууцны корпораци" ХК-ийн охин компани болох "НОСК НЭГ ТЗК" ХХК-иар дамжуулан 34.5 тэрбум төгрөг түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 420 орон сууцыг худалдан авч 420 албан хаагчийг орон сууцжуулаад байна.<br>2021 онд "Нийслэлийн орон сууцны корпораци" ХК-ийн охин компани болох "НОСК ХОЁР ТЗК" ХХК-иар дамжуулан 39.6 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 447 айлын орон сууцыг худалдан авч 447 албан хаагч, "НОСК ГУРАВ ТЗК" ХХК-иар дамжуулан 26 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 310 айлын орон сууцыг худалдан авч 310 албан хаагч, 50.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүрээнд түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган 757 албан хаагчийг орон сууцжуулаад байна. Нийт 2020 болон 2021 онуудад нийт 1177 төрийн албан хаагчийг 99.9 тэрбум ₮-ийн үнийн дүн бүхий орон сууцанд хамруулаад байна. Үүнээс 1025 нь нийслэлд 152 нь орон нутагт байна. | 100% |
| | 37 | | 10.7. Ипотекийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр нийт 6 хүртэлх сараар хугацааг сунгах асуудлыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлнэ. | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн Газрын 183 дугаар тогтоол, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-428 дугаар тушаалаар ипотекийн хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтийг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулсан.<br>Дээрх шийдвэрийн дагуу банкууд иргэдийн хүсэлтийг цахим хэлбэрээр 2021 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хүлээн авч, шийдвэрлэж ажилласан. Үр дүнд нь 55,661 зээлдэгчийн 2.9 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй ипотекийн зээл буюу нийт ипотекийн зээлийн багцын 80 хувьд эргэн төлөлт хойшлуулах арга хэмжээг авсан.<br>"Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Монголбанкны ерөнхийлөгчийн 2021 оны А-166 дугаар тушаалаар дээрх хугацааг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасан. Үр дүнд 58.2 мянган зээлдэгчийн 3.2 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн үлдэгдлийг хойшуулаад байна. | 100% |
| 9 | 38 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01 | 13.3. Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ. | Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн төслийг боловсруулах салбар дундын Ажлын хэсгүүдэд тус яамны төлөөллүүд орж ажиллаж байна. Ажлын хэсгүүдээс өгсөн чиглэл, зааврын дагуу салбарын нөхцөл байдлын шинжилгээг хийж, яамны 2021.10.25-ны өдрийн 1/4207 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хөтөлбөрүүд хараахан батлагдаагүй байна. Хөтөлбөрүүд батлагдмагц хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах болно. | 100% |
| | 39 | | 21.5. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-т Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хийж гүйцэтгэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг 2021 оны 08 дугаар сард ҮХГазарт хүргүүлсэн.<br>"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 206 дугаар тогтоолын дагуу 2022.02.01-ний дотор Үндэсний хөгжлийн газарт хүргүүлэхээр бэлтгэж байна.<br>"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд 2021 оны эхний хагас жилийн байдлаар хяналт -шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Сайдын зөвлөлийн хуралдаанаар 2021.06.29-ний өдөр хэлэлцүүлэн, ЗГХЭГ-т 2021.06.29-ний өдрийн 01/26363 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /new.unelgee.gov.mn/-д байршуулан, баталгаажуулсан. | 100% |
| УИХ-ын тогтоол | | | | | |
| 10 | 40 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2013-02-07 Дугаар 2013 №20 | 1.2. Барилгын ажил эрхлэх аливаа зөвшөөрөл /техникийн нөхцөл, дүгнэлт зэрэг/, тусгай зөвшөөрөл олгосон байдал, түүнчлэн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, нэгдсэн эмнэлгийн эдэлбэр газарт барилга байгууламж барих зөвшөөрөл олгосон асуудлыг хууль, хяналтын байгууллагын оролцоотой ажлын хэсэг байгуулан шалгаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах; | "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм"-ийг боловсруулж Засгийн газрын 2017 оны 68 дугаар тогтоолоор батлуулсан. Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6-д зааснаар барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг Аймаг, нийслэлийн Засаг дарга олгодог. Мөн барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлгүй барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа зөрчлийг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар мэргэжлийн хяналтын байгууллага шалгадаг. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | 41 | Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай 2013-02-08 Дугаар 2013 №23 | 2.5. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг мөрдөн ажиллаж, биелэлтийг хоёр жил тутам гаргаж Улсын Их Хуралд танилцуулж байх. | Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын 2020.07.30-ны өдрийн 141/А/1015 тоот хамтарсан тушаал, захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 05 дугаар хурлыг 2021.12.07-ны өдөр зохион байгуулж, "Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" боловсруулах ажлын эцсийн шатны тайлан, УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төслийг хэлэлцсэн.<br>БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн хурлаар 2021.12.10-ны өдрийн хурлаар, БХБ-ын сайдын зөвлөлийн 2021.12.15-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлж дэмжигдсэн.<br>"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг"-ийн хэрэгжилтийн тайлан, "Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний хамт УИХ-д 2022 оны 1 дүгээр улиралд багтаан өргөн мэдүүлэхээр УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төслийг тус тус боловсруулж байна. | 70% |
| 12 | 42 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2014-04-17 Дугаар 2014 №30 | 1.6/. Төсөвт өртгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэхэд нөлөөлсөн Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 18, 181 дүгээр тушаалыг хүчингүй болгох арга хэмжээ авах, барилгын норм, нормативын баримт бичгийг батлахтай холбоотой Барилгын тухай хуулийн холбогдох заалтыг өөрчлөх талаар хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх, | УИХ-аас Барилгын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр баталсан. Мөн Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалыг хүчингүйд тооцож, БХБ-ын Сайдын 2020 оны 30 дугаар тушаалаар “Барилгын төсөв зохиох дүрэм” /БНбД 81-95-12*2020/-ийг шинэчлэн баталсан. | 100% |
| | 43 | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34 | 3. газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах; | • “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| | 44 | | 6. барилга байгууламжийн хийц, бүтээц, эдлэхүүн, материал, түүхий эдийн бат бэх чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох, техник технологийг туршин шалгаж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий нэгдсэн лабораторийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажиллуулж, орон нутагт сүлжээ бий болгон өргөжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах; | МУ-ын 21 аймгийн лабораторийн тоног төхөөрөмжүүдийг үе шаттай сайжруулахаар бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Монгол Улсын Засгийн газраас баталсан “Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр”-н хүрээнд 21 аймагт керамик эдлэхүүний лаборатори, бетон дүүргэгч материалын лабораториуд, БХБЯ-аас БМСШЛабораторид Метал хийц эдлэхүүний, Холбогч материалын, Бетон дүүргэгч материалийн гэсэн 3 лабораторийн хүчин чадлыг 28 иж бүрдэл дэвшилтэд техник тоног төхөөрөмжөөр өргөтгөн сорилт шинжилгээний тоо хэмжээг нэмэгдүүлснээр 2021 оны байдлаар 48 нэр төрлийн 13014 ширхэг дээж хүлээн авч сорилт шинжилгээ хийж үр дүнг гаргасан.<br>2021 онд 25 нэр төрлийн 106 ширхэг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хүчин чадлаа сайжруулахаар Төрийн өмчийн хороогоор батлуулан тендер нь зарлагдахаар бэлтгэл ажил нь хангагдсан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | 45 | | 1.2/. Монгол орны болон Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн идэвхжилт, цаашдын төлөв байдал, аюулын үнэлгээний судалгаа болон мониторингийн ажлыг өргөжүүлж эрчимжүүлэх, томоохон хот, суурин газрын газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг хийж гүйцэтгэх; | Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил”-ын хүрээнд Одон орон, геофизикийн хүрээлэнтэй 2018 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 2018/175 дугаартай зөвлөх гэрээг байгуулсан ажиллаж байгаа ба 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл”-ийн хуралд дээрх ажлын санхүүжилтийг яаралтай шийдвэрлэх саналыг танилцуулсан. Үүний дагуу Шадар сайдаас Сангийн яаманд санхүүжилтийг шийдвэрлэх талаар үүрэг даалгавруг өгч эхний ээлжинд Хөвсгөл, Өмнөговь, Увс аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалын судалгааг хийхийг даалгасан.<br>Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилтийг 2021 оны төсвийн төсөлд тусгах саналаа 2020 оны 08 дугаар сарын 14-ний 01/2671 тоот, 2022 оны төсвийн төсөлд тусгах саналаа 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 тоот албан бичгээр Сангийн яаманд тухай бүрт хүргүүлсэн боловч одоог хүртэл ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх санхүүжилт шийдэгдээгүйн улмаас зөвлөх үйлчилгээний гэрээт ажил зогсоод байна. Уг асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргад 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр танилцуулсан. Мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 9 аймгийн газар хөдлөлийн бичил мужлалын зургийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлэхэд дэмжлэг хүсэх тухай 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 1/4889 тоот албан бичгийг хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Үүний дагуу Засгийн газрын 2021 оны 58 дугаар тэмдэглэлийн 7-т “дээрх 9 аймгийн төвүүдийн нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг зохиох арга хэмжээ авахыг Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Д.Рэгдэлд” даалгасан.<br><br>Хавсралт : 1 файл | 70% |
| | 46 | | 1.4/. Энэ тогтоолын 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн ордонд байрладаг байгууллагуудыг шилжүүлэн байрлуулах саналыг боловсруулж 2016 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах; | “Төрийн ордны барилгын чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж холбогдох баримт бичгийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд 2018 онд УИХ-д танилцуулсан. Мөн “Төрийн ордны барилгын чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хамт төрийн ордны барилгыг шинээр барих болон хуучин барилгыг хүчитгэхэд шаардлагатай судлагаа, тооцоо, түүнчлэн Төрийн ордонд байрладаг байгууллагуудыг шилжүүлэх саналыг дахин боловсруулж шаардлагатай санхүүжилтийн тооцооны хамт Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 21-ний хурлаар хэлэлцүүлсэн. Тус яамны зүгээс холбогдох арга хэмжээг авч ажилласан. | 100% |
| | 47 | | 1.5/. Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах; | -Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинэчлэн боловсруулахаар аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авч журмын төслийг боловсруулан, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн хурлаар төслийг хэлэлцүүлж, Шадар сайдын 2021 оны 2 дугаар тушаалаар Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинэчлэн баталсан. -Монгол Улсын 2021 оны төсөвт паспортжуулалтын ажлын 70 сая төгрөг тусгагдсаны дагуу нийслэлийн хэмжээнд нийт 89 барилга байгууламжийн суурь судалгаа, байгууламжид биет үзлэгийн судалгааг үе шаттайгаар хийж паспортжуулаад байна.<br>-Нийслэлд 2021 оны байдлаар орон сууцны 617, төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт олон нийтийн 163, нийт-780 барилгад буюу 42.5 хувьд нь хэмжилт, судалгаа хийж, дүгнэлт гаргаж, паспортжуулсан. Барилга байгууламжид хэмжилт, судалгаа хийх, паспортжуулах ажил болон багаж, тоног төхөөрөмжөөр хангах ажилд нийт 2.3 тэрбум төгрөг зарцуулсан. Уг тулгамдаад буй асуудлыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Барилга байгууламжийг паспортжуулах ажилд шаардлагатай санхүүжилтийг 2021 оны Улсын төсөвт тусгах саналаа 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2671 тоот албан бичиг, 2022 оны Улсын төсөвт тусгах саналаа 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 тоот албан бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй. 2022 оны Нийслэлийн төсөвт барилга байгууламжийг паспортжуулах ажилд 560 сая төгрөг туссан байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | 48 | Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай<br>2016-09-09<br>Дугаар 2016 №47 | 1.д/. Газрын төлбөрийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, газрын үнэлгээ, татварын механизмыг сайжруулах ажлыг судалж, эхлүүлэх.<br>(1/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:) | Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2019.11.13-ны өдрийн хуулиар газрын төлбөрийн бааз суурийг өргөтгөх, татварын болон газрын төлбөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын мэдээлэл солилцох нөхцлийг бүрдүүлэх асуудлыг хуульчилсан.<br>Газрын суурь үнэлгээ, үнэлгээний тойргийг зах зээлийн өнөөгийн байдалд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоож, Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж, Засгийн газрын 2018 оны 181 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>Дээрх хууль, тогтоолд нийцүүлэн нийслэл, аймаг, сум, дүүрэг тус бүр газрын үнэлгээний бүсээ шинэчлэн тогтоож, газрын төлбөрийг ногдуулан, мэдээллийн санд бүртгэж байна. Ингэснээр газрын төлбөрийн орлогоос улсын төсөвт орох орлогын хэмжээ өсч газрын үнэлгээний эрх зүйн орчин сайжирсан. Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор баталсан газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээний дагуу 2019-2020 онд газрын төлбөрийн орлогоос нийт 195 тэрбум 420 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.<br>Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хийж дууссан. Газрын багц хуулийн төслийг өргөн мэдүүлэх зөвшөөрөл авахаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдад 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1/5096 тоот бичгээр хүргүүлсэн. | 100% |
| 15 | 49 | Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай<br>2018-01-05<br>Дугаар 2018 №02 | 1.3/. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор нийслэлээс орон нутаг руу ажиллаж амьдрах иргэдийн санал санаачилгыг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх, аян өрнүүлэх, дагуул хотуудыг бий болгож шинжлэх ухаан, технологи, инноваци, аялал жуулчлал, аж үйлдвэр, худалдааны чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх, төрийн зарим байгууллага болон төрийн өмчит их, дээд сургуулийг хотоос гаргах, тэдгээрийг холбосон хурдны зам, метро байгуулах урьдчилсан тооцоо судалгаа хийж, нийслэл хотын зарим чиг үүргийг аймгийн зэрэглэлтэй болон дагуул хот руу шилжүүлэх зэрэг асуудлыг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан судалж, холбогдох шийдвэрийг гаргах; | • “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АНЗ авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аеротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| | 50 | | 1.5/. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэх, гэр хорооллын дэд бүтцийг бий болгож, төвлөрсөн дулаан хангамжид холбох, аймгийн төвүүд болон Улаанбаатар хотод баригдаж бэлэн болсон, зах зээл дээр борлогдоогүй байгаа орон сууцны тооцоолол судалгааг нарийвчлан гаргаж, тэдгээрт гэр хорооллын иргэдийг оруулах талаар арилжааны банкууд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран судалж, 2018 оны эхний хагас жилд багтаан холбогдох шийдвэрийг гаргах; | УБ хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд БХБС-ын 2020 оны 74 дүгээр тушаалаар “Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах журам”, 75 дугаар тушаалаар “Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах журам”-ыг тус тус батлаад байна.<br>2021 оны эхний хагас жилийн байдлаар гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 10,287 айлын орон сууц ашиглалтад ороод байна. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны төслийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын хэмжээнд 2020 онд ашиглалтад орсон болон 2023 он хүртэл баригдах орон сууцны төслүүдийн нарийвчилсан судалгааг /өрөөний тоо, гүйцэтгэлийн хувь, нэгж м.кв-ын үнэ, байршил/ “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-тай хамтран 2021 оны 03 дугаар сард хийсэн. Судалгааны агуулга, мэдээллийн үнэн, зөв байдлыг сайжруулан цаашид тогтмол хийх, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллах хүрээнд 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 03/1374 дугаар албан бичгээр холбогдох чиглэлийг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т хүргүүлсэн. Үүнтэй холбогдуулан өмнө нь хийсэн судалгааны үр дүнг сайжруулах, мэдээллийн санг баяжуулах хүрээнд орон сууцны зах зээлийн судалгааг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ болон Барилга.мн хамтран 2021 оны 08 дугаар сард шинэчлэн гаргасан.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 16 | 51 | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай<br>2018-02-01<br>Дугаар 2018 №15 | 2. Газар ашиглуулах гэрээг хуульд заасан журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгохыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т зөвшөөрсүгэй. | Монгол Улсын Их Хурлын 2018 оны 15 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Дорноговь аймгийн Замын-Үүд суманд суугаа Ерөнхий консулын газарт олгосон 19983.89 м.кв газрыг гадаад улсын дипломат төлөөлөгчийн зориулалтаар авсан. Холбогдох журмын дагуу газар ашиглах гурвалсан гэрээний төслийг боловсруулан санал авахаар ГХЯ, Дорноговь аймгийн Засаг даргад ГЗБГЗЗГ-аас 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 1/696 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Гэрээний төсөлд ГХЯ-наас 2021 оны 11 сарын 11-ний өдөр, Дорноговь аймгийн Засаг даргаас 2021 оны 12 сарын 3-ний өдөр саналаа ирүүлсэн. Ирүүлсэн саналыг нэгтгэж, гурвалсан гэрээний төслийг боловсруулж, батлуулах шатанд хэрэгжиж байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 17 | 52 | Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2018-06-21 Дугаар 2018 №54 | 1.1/. Иргэний хуулийн суурь зохицуулалт, үзэл баримтлалд нийцүүлэн Газрын тухай болон Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн төслийг 2019 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж дууссан. Хууль зүй дотоод хэргийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд хамтран 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хуулийн төслийн үзэл баримтлалыг баталсан. Төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл авахаар Хууль зүй, дотоор хэргийн сайд, Сангийн сайдад 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1/5096 тоот бичгээр хүргүүлсэн. Үүнд:<br>1. Газрын ерөнхий хуулийн төсөл;<br>2. Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн төсөл;<br>3. Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>4. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>5. Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх хуулийн төсөл тус тус байна. | 100% |
| 18 | 53 | Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2018-11-02 Дугаар 2018 №80 | 1.2/. Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн дутагдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх; | Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн дутагдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, 2018-2020 онд нийт 21,8 тэрбум төгрөгийг үнэрт бодисын ялгарал, тархалтын судалгаа, лагийг цэвэрлэж үнэргүйжүүлэх, бордоо болгох, хар шороон хөрс болгох, лаг усгүйжүүлэх байгууламж барих ажилд тус тус зарцуулсан. Үүний үр дүнд цэвэрлэх байгууламжийн орчноос үнэртэх үнэрийн тархалт 54,12%-иар буурсан. | 100% |
| 19 | 54 | Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай 2018-11-15 Дугаар 2018 №84 | 2.8/. Ипотекийн зээлийг эдийн засгийн төлөв, санхүүгийн чадавхтай уялдуулж урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх; | Монголбанк, Засгийн газар хамтран 2013 оны 6 дугаар сараас “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд давхардсан тоогоор нийт 100 орчим мянган өрх хамрагдсан бөгөөд нийт 5.5 их наяд төгрөгийн санхүүжилтийг хөтөлбөрт зориулсан байна. Үүнээс 2021 оны жилийн эцсийн байдлаар 79.9 мянган өрх нийт 4.2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд гэр хороолold амьдарч байсан нийт 25 мянга орчим өрх ипотекийн зээлээр орон сууц худалдан авч, орон нутагт 15 мянган өрх орон сууцанд орж, 11 мянган өрхийн зээлийн хүүгийн төлбөр буурсан бөгөөд дунджаар сарын төлбөр 290 мянган төгрөгөөр багассан.<br>Монгол банкны Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А-392 дугаар тушаалаар тус өдрөөс эхлэн шинээр олгох орон сууцны ипотекийн зээлийн хүүг жилийн 8 хувь байсныг 6 хувь болгож бууруулсан.<br>2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар арилжааны банкуудад нийт 2.1 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн хүсэлт ирснээс 964.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 12,709 зээлдэгчид олгоод байна. Үүнээс 81.9 хувь буюу 789.4 тэрбум төгрөгийн 9,550 зээлийг Улаанбаатар хотод олгосон бол 18.1 хувь буюу 174.6 тэрбум төгрөгийн 3,159 зээлийг орон нутагт олгосон байна.<br>Мөн тус хугацаанд гарсан 964.0 тэрбум төгрөгийн зээлийн 600.7 тэрбум төгрөг нь Монголбанкны эх үүсвэрээс, 363.3 тэрбум төгрөг нь арилжааны банкуудын өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна. Энэ нь 2020 оны мөн үетэй харьцуулахад даруй 2.5 дахин өндөр үзүүлэлт байна. Энэ хэмжээгээр 2021 оны эцэс гэхэд нийт 1.0 их наяд орчим тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 13.0 мянга орчим зээлдэгчид олгох тооцоолол гарч байна.<br>Ипотекийн зээлийн хөтөлбөрийг 2022 онд тогтвортой хэрэгжүүлэхэд шаардагдах нийт 200.0 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийн эх үүсвэрт тусган шийдвэрлүүлэх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн. | 100% |
| | 55 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62 | 1.3/а/. 3/Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар:<br>а/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, агаар, ус, хөрсний бохирдлыг арилгах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, дэд бүтцийн чиглэлээр баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээг авах; | "Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д 2020.01.22-ны өргөн барьж, УИХ-ын ЭЗБХ-ны хурлаар 2020.11.04-ний өдөр, УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар 2020.11.06-ны өдөр тус тус хэлэлцүүлж, цаашид хэлэлцүүлэхээр болсон. Шинэчилсэн найруулгын хуулийн төслийн зорилт нь хүн амын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлсэн бүс нутаг, хот, суурин газрыг төлөвлөх, байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байгаа бөгөөд шинээр “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд хүн амын эрүүл, аюулгүй байдал, байгаль экологи, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах” зарчим тусгагдсан болно.<br>Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 249 дугаар тушаалаар ""Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"" баталсан. Уг журамд ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцыг буулган шинээр барих төсөл хэрэгжүүлэгч шалгарахгүй тохиолдолд төр хариуцан гүйцэтгэх зохицуулалтыг нэмж тусгаж өгсөн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 20 | 56 | | 1.3/г/. цэвэр усны түгээлт, хэрэглээнд хэмнэлтийн горимыг баримтлах, үйлдвэрлэлийн хэрэгцээнд саарал ус ашиглах дэвшилтэт технологийг нэвтрүүлэх асуудлыг зохицуулсан бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх; | 1.Нэг хүний хоногийн ус хэрэглээг тооцох судалгааны ажлыг "Икон консалтинг" ХХК нь 2019-2020 онуудад гүйцэтгэж, улмаар Барилга доторхи ус хангамж, ариутгах татуурга БНБД 40-05-16 д өөрчлөлт оруулж, БХБСайдын 2020 оны 97 дугаар тушаалаар баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020.06.08-ны өдөр бүртгүүлсэн.<br>2.Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдээд гарсан усыг ногоон байгууламжийн усалгаанд ашиглах техникийн шийдлийг Увс, Завхан, Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр аймгуудад шинээр баригдах цэвэрлэх байгууламжийн зураг төслийн ажлын даалгаварт тусгаж зураг төсөл боловсруулах ажлыг БХБЯ-ны ТНБД-р батлуулан хэрэгжүүлж байна.<br>3. Засгийн газрын “Төлөвлөгөө батлах тухай” 2021 оны 53 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-г баталсан. МСК-ийн санхүүжилтээр хэрэгжих “Хаягдал усыг дахин боловсруулах” төсөл нь шинэ ТЦБ-аас цэвэрлэн гарах хаягдал усыг дахин боловсруулж, Дулааны 3 болон 4 дүгээр цахилгаан станцын техникийн усны зориулалтаар (голчлон хөргөлтөд) эргүүлэн ашиглах зорилготой юм. ДЦС-3 болон ДЦС-4 жилд 21.0 сая м3 (57500 м3/хоног) орчим усыг газрын доорх эх үүсвэрээс авч ашигладаг бөгөөд үүнээс 15.0 сая м3 усыг (нийт хэрэглээний 70% орчим) хөргөлт, угаалга цэвэрлэгээ, үнс зайлуулахад ашигладаг. Цаашид ДЦС-уудын хөргөлт, угаалга цэвэрлэгээ, үнс зайлуулахад дахин боловсруулсан усыг хэрэглэж эхэлснээр техникийн зориулалтаар ашиглаж буй газрын доорх усны эрэлтийг бууруулж, улмаар чөлөөлөгдсөн эх үүсвэрийг Улаанбаатар хотын унд, ахуйн ус хангамжийг нэмэгдүүлэхэд ашиглах боломжтой болгох юм. | 100% |
| | 57 | | 1.3/е/. газар чөлөөлж, үл хөдлөх эд хөрөнгийг буулгахад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хохирлыг төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага бүрэн хариуцдаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох; | БХБ-ын Сайд, Сангийн Сайдын хамтарсан 2020 оны 202/196 дугаар тушаалаар “Газар, үл хөдлөх хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлал”-ыг баталсан. Тус тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 4910 дугаарт бүртгэсэн. | 100% |
| 21 | 58 | Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2019-11-13 Дугаар 2019 №89 | 1.3/. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг гадаадын зээл, тусламж болон дотоодын банк, санхүүгийн байгууллагаас бүрдүүлэн, эх үүсвэрийн хэмжээг 2020 оны эхний хагас жилд багтаан 2018 оны түвшинд хүргэх; | 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар арилжааны банкуудад нийт 2.1 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн хүсэлт ирснээс 964.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 12,709 зээлдэгчид олгоод байна. Үүнээс 81.9 хувь буюу 789.4 тэрбум төгрөгийн 9,550 зээлийг Улаанбаатар хотод олгосон бол 18.1 хувь буюу 174.6 тэрбум төгрөгийн 3,159 зээлийг орон нутагт олгосон байна.<br>Мөн тус хугацаанд гарсан 964.0 тэрбум төгрөгийн зээлийн 600.7 тэрбум төгрөг нь Монголбанкны эх үүсвэрээс, 363.3 тэрбум төгрөг нь арилжааны банкуудын өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна. Энэ нь 2020 оны мөн үетэй харьцуулахад даруй 2.5 дахин өндөр үзүүлэлт байна. Энэ хэмжээгээр 2021 оны эцэс гэхэд нийт 1.0 их наяд орчим тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 13.0 мянга орчим зээлдэгчид олгох тооцоолол гарч байна.<br>Ипотекийн зээлийн хөтөлбөрийг 2022 онд тогтвортой хэрэгжүүлэхэд шаардагдах нийт 200.0 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийн эх үүсвэрт тусган шийдвэрлүүлэх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн. | 100% |
| | 59 | | 1.4/. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэртэй холбоотой мэдээллийг бүрэн бүртгэж, бүртгэлийг цахимжуулах, хуулийн дагуу газрын төлбөр ногдуулж, хураах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллах. | Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор Газар зохион байгуулалт, газрын мониторинг, газрын биржийн болон газрын үнэлгээ, төлбөр, татвар, хураамж, газрын кадастрын бүртгэлийн цахим систем бүхий газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэр, холбогдох мэдээллийг газрын кадастрын улсын мэдээллийн санд тухай бүрт нь бүртгэж, төлбөрийн мэдээллийг дундын мэдээллийн санд бүртгэх ажлыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан гүйцэтгэж байна.<br>Мөн Газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.22 дахь хэсгийг тус тус үндэслэн “Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам”-ыг Барилга, хот байгуулалтын сайд, Сангийн сайдын хамтарсан 2020.09.11-ний өдрийн 173/178 дугаар тушаалаар батлуулсан. Газрын төлбөрийн тухай хуульд 2019.11.13-ны өдөр орсон өөрчлөлтөөр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаа газрын төлбөрийн ногдуулалтыг хийж, нэхэмжлэх үүсгэн, “Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам”-ын дагуу нэхэмжлэхийг дундын мэдээллийн сангаар дамжуулан татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүрт нь хүргүүлж, төлбөрийг барагдуулах ажлыг шуурхай зохион байгуулах нөхцөл бүрдсэн. 2019-2020 онд газрын төлбөрийн орлогоос нийт 195 тэрбум 420 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 22 | 60 | Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай 2019-12-05 Дугаар 2019 №98 | 2.7/. Ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх; | 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар арилжааны банкуудад нийт 2.1 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн хүсэлт ирснээс 964.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 12,709 зээлдэгчид олгоод байна. Үүнээс 81.9 хувь буюу 789.4 тэрбум төгрөгийн 9,550 зээлийг Улаанбаатар хотод олгосон бол 18.1 хувь буюу 174.6 тэрбум төгрөгийн 3,159 зээлийг орон нутагт олгосон байна.<br>Мөн тус хугацаанд гарсан 964.0 тэрбум төгрөгийн зээлийн 600.7 тэрбум төгрөг нь Монголбанкны эх үүсвэрээс, 363.3 тэрбум төгрөг нь арилжааны банкуудын өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна. Энэ нь 2020 оны мөн үетэй харьцуулахад даруй 2.5 дахин өндөр үзүүлэлт байна. Энэ хэмжээгээр 2021 оны эцэс гэхэд нийт 1.0 их наяд орчим тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 13.0 мянга орчим зээлдэгчид олгох тооцоолол гарч байна.<br>Ипотекийн зээлийн хөтөлбөрийг 2022 онд тогтвортой хэрэгжүүлэхэд шаардагдах нийт 200.0 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийн эх үүсвэрт тусган шийдвэрлүүлэх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн.<br>Барилга, хот байгуулалтын яам, Дэлхийн банк хоорондын албан уулзалтыг 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Иргэдийг төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах санхүүгийн механизмыг боловсронгуй болгох, олон улсын туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр техник туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр тохиролцсон. Төслийн ажлын даалгаварт төрөөс хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга, хэмжээтэй холбогдуулан салбарын бодлого, төлөвлөлтийг сайжруулах хүрээнд холбогдох саналыг тусган 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 4/1877 дугаар албан бичгээр Дэлхийн банкинд хүргүүлж, төслийн хэрэгжилтийг албан ёсоор эхлүүлсэн. Төслийн бүрэлдэхүүн хэсэг 1 болон 2-ын хүрээнд одоо хэрэгжиж байгаа ипотекийн зээлийн хөтөлбөрт үнэлгээ хийх буюу цаашид тогтвортой хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулна. | 100% |
| 23 | 61 | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай 2019-12-06 Дугаар 2019 №100 | 2. Газар ашиглуулах гэрээг холбогдох хуульд заасан журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгохыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т зөвшөөрсүгэй.<br>(1.Арабын Нэгдсэн Эмират Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд олгосон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших газрын хилийн зааг, эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг хавсралтаар баталж, гадаад улсын дипломат төлөөлөгчийн газрын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсугай.) | Арабын Нэгдсэн Эмират Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд олгосон газарт гэрчилгээ олгож газар ашиглах 2020/235 тоот гурвалсан гэрээг байгуулсан. | 100% |
| 24 | 62 | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай 2020-04-29 Дугаар 2020 №32 | 2.6/. төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчдад зориулсан ипотекийн зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргах хүрээнд түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны тусгай хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх, орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх; | Засгийн газрын 2020 оны 185 дугаар тогтоолоор “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд албан үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагчдад зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг тогтоолын хүрээнд 2020 онд “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн охин компани болох “НОСК НЭГ ТЗК” ХХК-иар дамжуулан 34.5 тэрбум төгрөг түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 420 орон сууцыг худалдан авч 420 албан хаагчийг орон сууцжуулаад байна.<br>2021 онд “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн охин компани болох “НОСК ХОЁР ТЗК” ХХК-иар дамжуулан 39.6 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 447 айлын орон сууцыг худалдан авч 447 албан хаагч, “НОСК ГУРАВ ТЗК” ХХК-иар дамжуулан 26 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган зах зээл дээр бэлэн байгаа 310 айлын орон сууцыг худалдан авч 310 албан хаагч, 50.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүрээнд түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган 757 албан хаагчийг орон сууцжуулаад байна. Нийт 2020 болон 2021 онуудад нийт 1177 төрийн албан хаагчийг 99.9 тэрбум ₮-ийн үнийн дүн бүхий орон сууцанд хамруулаад байна. Үүнээс 1025 нь нийслэлд, 152 нь орон нутагт байна. | 100% |
| 25 | 63 | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, тусгай хэрэгцээнээс гаргах тухай 2020-05-14 Дугаар 2020 №53 | 3. Гадаад улсын дипломат болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газартай харилцан адил байх зарчмыг баримтлан Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай газар ашиглуулах гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т зөвшөөрсүгэй. | АНУ-ын Элчин сайдын яаманд олгосон газарт газар ашиглах гурвалсан гэрээг байгуулж, гэрчилгээ олгосон. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 26 | 64 | Хот байгуулах тухай 2020-05-14 Дугаар 2020 №55 | 2. “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг байгуулахдаа Төв аймгийн Зуунмод, Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай. | • “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| 27 | 65 | Хот байгуулах тухай 2020-05-14 Дугаар 2020 №55 | 2. “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг байгуулахдаа Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Төв аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.<br>/Энэ заалтыг Монгол Улсын Их Хурлын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 68 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./ | • “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| 28 | 66 | Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай 2020-11-05 Дугаар 2020 №32 | 2.6/. Олон улсын шилдэг туршлагад үндэслэн орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх; | Барилга, хот байгуулалтын яам, Дэлхийн банк хоорондын албан уулзалтыг 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Иргэдийг төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах санхүүгийн механизмыг боловсронгуй болгох, олон улсын туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр техник туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр тохиролцсон. Төслийн ажлын даалгаварт төрөөс хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга, хэмжээтэй холбогдуулан салбарын бодлого, төлөвлөлтийг сайжруулах хүрээнд холбогдох саналыг тусган 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 4/1877 дугаар албан бичгээр Дэлхийн банкинд хүргүүлж, төслийн хэрэгжилтийг албан ёсоор эхлүүлсэн. Төслийн бүрэлдэхүүн хэсэг 1 болон 2-ын хүрээнд одоо хэрэгжиж байгаа ипотекийн зээлийн хөтөлбөрт үнэлгээ хийх буюу цаашид тогтвортой хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулна. Техник туслалцааны төсөл нь нийт 2 үе шаттайгаар хэрэгжих бөгөөд эхний үе шат нь 2021 оны 05 дугаар сараас 2022 оны 06 дугаар сар хүртэл хэрэгжинэ.<br>2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар арилжааны банкуудад нийт 2.1 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн хүсэлт ирснээс 964.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 12,709 зээлдэгчид олгоод байна. Үүнээс 81.9 хувь буюу 789.4 тэрбум төгрөгийн 9,550 зээлийг Улаанбаатар хотод олгосон бол 18.1 хувь буюу 174.6 тэрбум төгрөгийн 3,159 зээлийг орон нутагт олгосон байна.<br>Мөн тус хугацаанд гарсан 964.0 тэрбум төгрөгийн зээлийн 600.7 тэрбум төгрөг нь Монголбанкны эх үүсвэрээс, 363.3 тэрбум төгрөг нь арилжааны банкуудын өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна. Энэ нь 2020 оны мөн үетэй харьцуулахад даруй 2.5 дахин өндөр үзүүлэлт байна. Энэ хэмжээгээр 2021 оны эцэс гэхэд нийт 1.0 их наяд орчим тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 13.0 мянга орчим зээлдэгчид олгох тооцоолол гарч байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 29 | 67 | Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-12-04 Дугаар 2020 №39 | 1.1/. 1.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:<br>1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсвийн орлого нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, бүх салбарын төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх; | Төсвийн орлого нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах, төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг хүргүүлж Сангийн яамтай тухай бүр хамтран ажиллаж байна.<br>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хүрээнд газрын дуудлага худалдааны орлогыг газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг ашиглан дуудлага худалдааг цахимаар зохион байгуулсанаар газрын дуудлага худалдаанаас улсын төсөвт орох орлогын хэмжээ 2.3 хувиар нэмэгдэж 2021 оны байдлаар 10.6 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлээд байна. Мөн Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хүрээнд Татварын албатай хамтран дундын мэдээллийн сан байгуулсаны үр дүнд 2019 онд 1 жилийн газрын төлбөрийн орлого 76 тэрбум төгрөг байснаас 88 тэрбум төгрөг болж өссөн бол 2021 онд 126.5 тэрбум төгрөгийн ногдуулалт үүсгэж жилийн эцсийн байдлаар 96.7 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрөөд байна. | 100% |
| | 68 | | 1.2/. Төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гарган, хэрэгжилтийг хангаж ажиллах; | Барилга, хот байгуулалтын сайдын багцын 2020 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн хүрээнд өгөгдсөн аудитын зөвлөмж, шаардлагын биелэлтийг хангаж, цаашид өгөгдсөн зөвлөмжийн хүрээнд гаргасан алдааг дахин гаргахгүй, мөн төсвийн сахилга батыг чанд сахин биелэлтийг ханган ажиллаж байна. | 100% |
| | 69 | | 1.4/. Монгол Улсын 2021 оны төсвийн төслөөс хасагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцон эрэмбэлж, төсвийн тухай хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн дараа оны төсвийн төсөлд тусгах асуудлыг шийдвэрлэх; | Монгол Улсын 2020 оны төсвийн тодотголоор хасагдсан болон 2020 онд санхүүжилтээ төсөвт буцаан татуулсан нийт 57 төсөл, арга хэмжээний 34.1 тэрбум төгрөгийг 2022 оны Төсвийн тухай хуулиар батлуулан шийдвэрлүүлсэн. | 100% |
| 30 | 70 | Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай 2021-01-29 Дугаар 2021 №23 | 4. Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус үүрэг болгосугай. | УИХ-ын 56 дугаар тогтоолоор баталсан "Улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөө"-нд салбарын бодлогыг тусгуулсан. | 100% |
| 31 | 71 | Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай 2021-07-08 Дугаар 2021 №75 | 4. Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус үүрэг болгосугай. | Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж дууссан. Төслийг өргөн мэдүүлэх зөвшөөрөл авахаар Хууль зүй, дотоор хэргийн сайд, Сангийн сайдад 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1/5096 тоот бичгээр хүргүүлсэн. Үүнд:<br>1. Газрын ерөнхий хуулийн төсөл;<br>2. Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн төсөл;<br>3. Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>4. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>5. Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх хуулийн төсөл тус тус байна.<br>Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулсан. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл болон холбогдох материалыг боловсруулсан, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл хүлээж байна. | 100% |

| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 32 | 72 | Хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг арилгах асуудлаар чиглэл өгөх тухай 2010-01-27 Дугаар 2 | 4. Шинээр баригдаж буй хороолол, барилга, байгууламжуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд инженерийн бэлтгэл арга хэмжээг зайлшгүй тусгаж хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, мэргэжлийн комисс цогцоор нь хүлээж авч байх журам тогтоох | Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг баталсан. Тус дүрмийн 3.2-т "Аймаг, нийслэлийн Засаг дарга захиалагчийн хүсэлт, газар өмчлөх, эзэмших, ашиглах шийдвэрт үндэслэн хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн хангамжийн боломж, эрүүл ахуй, галын аюулгүйн нөхцөл, шаардлагад нийцүүлэн тухайн барилга байгууламжийн байршлыг тогтоож баталгаажуулна.", 3.3-т "Энэ дүрмийн 3.2-т заасан шийдвэрийг гаргахад аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалт, газрын харилцааны асуудал хариуцсан нэгж нь дараахь асуудлыг тусгасан архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулна", 3.3.1. "барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал, барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй нийцэж байгаа эсэхийг дүгнэсэн талаар", 3.4-т "Архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймаг, нийслэлийн ерөнхий архитектор батална." гэж тус тус заасны дагуу инженерийн бэлтгэл арга хэмжээг зайлшгүй тусгаж хэрэгжүүлэх талаар тусгасан.<br>Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг баталсан. Тус дүрмийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын чиг үүргийн 5.1.5-д "барилга байгууламжид суурилагдсан өргөх байгууламж болон тоног төхөөрөмж, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээнд туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдлыг шалгаж, ашиглах боломжтой эсэхийг дүгнэх", техникийн комиссын чиг үүргийн 6.1.1-д "барилгын ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай инженерийн хангамжийн шугам сүлжээний туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдлыг дүгнэх", 6.1.2-т "барилгын инженерийн хангамжийн эх үүсвэр, түүний дагалдах сүлжээ, туслах барилга байгууламжийн найдвартай байдлыг дүгнэх" гэж тус тус заасан. | 100% |
| 33 | 73 | Байгаль орчны төлөв байдлын 2013-2014 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2015-05-06 Дугаар 2015 №05 БОХХААБХ | 1.5/. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх; | “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн барилга байгууламжийн зураг төслийг Шанхай хотын зураг төслийн хүрээлэн боловсруулсан. Нийт 38 объектийн зураг төсөл хийгдэхээс 11 барилга нь магадлалаар хянагдсан. Бусад нь хянагдаж байна. 98%-ийн гүйцэтгэлтэй.<br>Цахилгааны 35/10кВ-ын дэд станц, ЦДАШ, дулаан хангамж, цэвэр, бохир усны шугамын зураг төслийг боловсруулж, батлуулсан. БУА: 25%-ийн гүйцэтгэлтэй. Элс баригч, 1-р 2-р тунгаагуур, хойд биореактор, захиргааны барилга, лаг өтгөрүүлэгч, лаг өтгөрүүлэгч, метантенк зэрэг 12 барилгын БУА хийгдэж байна.<br>Тоног төхөөрөмж татан авалт: Нийт 17 гэрээг үйлдвэрлэгч нартай байгуулсан.<br>Ажиллах хүчин: 2021.06.19-ний өдөр 35 ИТА-г оруулж ирсэн. Дотоодын туслан гүйцэтгэгч 13 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажиллуулсан. Сургалтууд зохиогдсон. КОВИД –ын үед ажиллах түр журам, төлөвлөгөөг батлуулж, ажилласан. Цар тахлаас шалтгаалан Хятадын талын ажиллах хүчин, зарим бараа материал орж ирээгүй.<br>Төслийн хэрэгжилт 2020 онд 15% байсан бол 2021 онд 35%-д хүрсэн нь төслийн нэгжийн төлөвлөлт, менежментээс шалтгаалсан гэж дүгнэж байна. Мөн туслан гүйцэтгэгчдийг дотоодоосоо /Монгол Улс/ авч ажиллуулсан нь төслийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлсэн. | 100% |
| | 74 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017-01-03 Дугаар 2017_01 | 14. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийг батлах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дагуул хот, шинэ суурьшлын бүсийг бий болгох | - УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан.<br>-“Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>- “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг"-ийн хэрэгжилтийн тайлан, "Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний хамт УИХ-д 2022 оны 1 дүгээр улиралд багтаан өргөн мэдүүлэхээр УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төслийг тус тус боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 34 | 75 | | 15. Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх, барилгажуулах, хувийн тохилог сууцтай болгох асуудалд анхаарах | • Монголбанк, Засгийн газар хамтран 2013 оны 6 дугаар сараас “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд давхардсан тоогоор нийт 100 орчим мянган өрх хамрагдсан бөгөөд нийт 5.4 их наяд төгрөгийн санхүүжилтийг хөтөлбөрт зориулан гаргасан байна. Үүнээс 2021 оны эцсийн байдлаар 76.2 мянган өрх нийт 3.8 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.<br>• Хөтөлбөр хэрэгжих хугацаанд гэр хороололд амьдарч байсан нийт 25 мянга орчим өрх ипотекийн зээлээр орон сууц худалдан авч, орон нутагт 15 мянган өрх орон сууцанд орж, 11 мянган өрхийн зээлийн хүүгийн төлбөр буурсан ба дунджаар сарын төлбөр 290 мянган төгрөгөөр багассан.<br>• Монгол банкны Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А-392 дугаар тушаалаар тус өдрөөс эхлэн шинээр олгох орон сууцны ипотекийн зээлийн хүүг жилийн 8 хувь байсныг жилийн 6 хувь болгож бууруулсан явдал юм. Тус арга хэмжээний үр дүнд зээлдэгчийн сарын эргэн төлөлтийн хэмжээ болон орлогын доод хэмжээ тус тус 18.3 хувиар буурж, ипотекийн зээлийн шалгуурт тавигддаг өрхийн орлогын хэмжээ нийслэлийн өрхийн дундаж орлогын түвшинөөс бага түвшинд очсоноор ипотекийн зээлд орлого багатай өрхийн хамрагдах боломж нэмэгдэх, цар тахлын эрсдэл өндөр үед зээлийн дарамтыг буурах, өрхийн амьжиргаа нэмэгдэх, зээлийн эрсдэл буурах зэрэг эерэг нөхцөл бүрдсэн.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| | 76 | | 16. Гэр хорооллыг дахин төлөвлөх, барилгажуулах, хувийн тохилог сууцтай болгох асуудалд анхаарах | УБ хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд БХБС-ын 2020 оны 74 дүгээр тушаалаар “Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах журам”, 75 дугаар тушаалаар “Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах журам”-ыг тус тус батлаад байна.<br>2021 оны эхний хагас жилийн байдлаар гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 10,287 айлын орон сууц ашиглалтад ороод байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 35 | 77 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай<br>2018-01-31<br>Дугаар 2018 №02<br>ХЗБХ | 3.20. Уул уурхай, барилга, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээнд “Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. | Тус ажлын хүрээнд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулдаг гэрээнд “Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 107 дугаар тушаалаар баталсан насанд хүрээгүй хүн ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг мөрдөж ажиллах, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг таслан зогсоох” гэсэн заалтыг тусгасан. | 100% |
| 36 | 78 | Чиглэл өгөх тухай<br>2018-04-25<br>Дугаар 2018 №08<br>ЭЗБХ | 2.2/. Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах; | “Барилгын салбарын статистикийн чиглэлээр 2021-2022 онд хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Барилга, хот байгуулалтын сайд болон Үндэсний статистикийн хорооны даргаар 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлуулсан.<br>Дэлхийн банкны Ухаалаг засаг төслийн хүрээнд “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (www.opendata.gov.mn)”-ыг ашиглалтад оруулсан.<br>“Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (www.opendata.gov.mn)”-д барилга, газар, орон зайн өгөгдөл гэсэн 3 бүлгийг үүсгэн нээлттэй өгөгдөл, мэдээллийг тогтмол байршуулж байна. Барилга, газар бүлгүүдэд салбарын судалгаа, статистикийн тоон мэдээллүүд, орон зайн өгөгдөл бүлэгт газрын гадарга дээрх, доорх ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байршил, хэмжээ, шинж чанарыг тодорхойлж буй 60 өгөгдөл, мэдээллийг байршуулаад байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 37 | 79 | Төрийн албаны зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлд үүрэг өгсөн хуралдааны тэмдэглэл 2018-05-01 Дугаар 2018 №07 ТББХ | 5. Олон удаагийн шүүхийн шийдвэртэй яамдууд хүний нөөцийн бодлого алдагдсан асуудлыг засаж, сайжруулах арга хэмжээг нэн даруй авах; | 2017 оноос хойш тус яамнаас албан хаагчдыг хууль бусаар халсан асуудал байхгүй.<br>Хүний нөөцийн бодлогын ил тод, нээлттэй байдлыг хангах, салбар зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд дараах мэдээ танилцуулгыг яамны цахим хуудас www.mcud.gov.mn веб сайтад байршуулсан.Үүнд:<br>1. Салбар зөвлөлийн ажиллах журам<br>2. Салбар зөвлөлийн хуралдааны дэг<br>3. Салбар зөвлөлийн төлөвлөгөө<br>4. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний хаяг, утасны жагсаал<br>5. Эрх зүйн баримт бичиг<br>6. Албан тушаалын сул орон тооны зар | 100% |
| 38 | 80 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018-05-09 Дугаар 2018 №05/13 АБГББХ/ЭЗБХ | 1.1/. Монгол Улсын Засгийн газраас “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, үр дүн, цаашид авах арга хэмжээний саналыг авч хэлэлцээд, Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т дараах асуудлыг чиглэл болгосугай:<br>“Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын биелэлт хангагдаагүй арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх; | “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын биелэлт хангагдаагүй арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх хүрээнд 1 дэх хэсгийн 5 заалтаар, “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын, Эдийн засгийн байнгын хорооны байнгын хороодын хамтарсан 2018 оны 05/13 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 2 дахь заалтаар, “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тухай” Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 17/12 дугаар зөвлөмжийн 2.2-т тус тус заасан Засгийн газарт өгсөн үүрэг даалгаврын дагуу “Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулгаж шинээр барих төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж Засгийн газрын 2018 оны н/206 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Үүний хүрээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар 22 цэцэрлэг, 38 сургууль, 17 эмнэлэгийн барилга байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулсан байна.<br>Цаашид уг үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанд танилцуулсаны дагуу 58 дугаар хурлын тэмдэглэлээр албажуулж холбогдох сайд дарга нарт үүрэг болгуулсан.<br>Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох тэмдэглэл, шийдвэрийн хамт 2021.03.31-ний өдрийн 01/1142 тоотоор болон цахимаар ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /new.unelgee.gov.mn/-д байршуулан, баталгаажуулсан. | 100% |
| | 81 | | 1.3/. Барилга байгууламжийн хийц, бүтээцийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг тогтоох, турших, дүгнэлт өгөх, барилгын төлөвлөлт, угсралт, ашиглалтын үе шатны чанар, аюулгүй байдлыг хянах чиглэлээр нэгдсэн лабораторийн сүлжээг нийслэл хот, аймаг бүрд бий болгон ажиллуулах, тэдгээрийг боловсон хүчин, багаж, техник, тоног төхөөрөмжөөр хангах, барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторийн бүтэц, орон тоог баталж, цалин хөлс, холбогдох зардлыг 2019 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээг авах; | Улсын хэмжээнд нийслэл болон 21 аймагт барилгын материалын сорил, шинжилгээний лаборатори ажиллаж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар 48 нэр төрлийн 13014 ширхэг дээж хүлээн авч сорилт шинжилгээ хийж үр дүнг гаргасан байна.<br>Барилгын материалын лабораторийн барилга болон түүнд шаардлагатай тоног төхөөрөмжийн асуудлыг бүрэн шийдвэрлэх хүрээнд Замын-Үүд болон 21 аймгийн "Барилгын материалын сорил, шинжилгээний лабораторийг шинэчлэх төсөл"-ийн техник туслалцааны 1.0 сая ам долларын буцалтгүй тусламжийг 2022 онд, 95.0 сая ам долларыг 2023 онд тус тус санхүүжүүлэхээр шийдвэрлүүлэв. | 100% |
| | | | | Ерөнхийлөгчийн зарлиг | |
| 39 | 82 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 152 дугаар тушаалаар байгуулсан. Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан.<br>Хаягийн мэдээллийн санд нийт 1,081186 нэгж талбар, 689895 барилга байгууламж, 49826 гудамжны өгөгдлийг оруулсан. Эдгээр өгөгдөлд автоматаар хаяг олгох боломжтой “Хаягийн мэдээллийн систем”-ийг хөгжүүлж, улсын хэмжээнд хот суурин газрын 650489 нэгж талбар, 283995 барилгыг хаягжуулаад байна. Мөн нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт 10071 гэр хорооллын гудамж, 280332 хашаа, 89188 байшинг Хаягжуулалтын тухай хууль, журмын дагуу дугаарлаж, хаяг нэр өгч, хаягийн зураг зохион, мэдээллийн санг үүсгэсэн. Мөн Монгол Улсын 1:100000 масштабтай газар усны нэрийн тоон зургийн 258650 газар, усны нэрийн өгөгдлийг хаягийн мэдээллийн санд бүртгэж, малчдын өвөлжөө, хаваржаа, газар тариалангийн зориулалтаар ашиглаж байгаа нийт 20651 нэгж талбарт газар усны нэрийн дагуу шинээр хаяг олгоод байна. | 70% |

| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 40 | 83 | Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09 | 1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх, | Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2014-2019 онд гарсан шийдвэрүүдээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон газар хөдлөлтөд тэсвэргүй нийтийн орон сууцны зориулалттай 344 барилгын ашиглалтыг хориглосон.<br>Дээрх 344 барилгаас 170 барилгын иргэдийн санал асуулгаар дахин төлөвлөлтөд хамрагдахыг дэмжсэн тул Нийслэлийн Засаг даргын 16 удаагийн захирамж гарч буулган, дахин төлөвлөн барилгажуулахаар шийдвэрлэсэн. Эдгээр 170 барилгын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг 2015-2021 онд удаа дараа зарласнаар 97 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагааны дагуу 892 айлын 48 орон сууцыг буулган, 2478 айлын 15 орон сууц ашиглалтад орсон. | 100% |
| | 84 | | 2. Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн эрсдэлийн бодит байдлыг нийтэд таниулах, нийслэлийн орчмын бүс нутагт өндөр хурдны зам, эрчим хүчний шугам тавих замаар үйдвэр, үйлчилгээ, хүн амын суурышлын шинэ төвүүдийг бий болгох, их, дээд сургуулийн хотхон байгуулах зэргээр төвлөрлийг задлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, | “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-ыг даган бий болох шинэ хот (Аэросити), “Майдар” хотыг хөгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| 41 | 85 | Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай 2014-10-20 Дугаар 2014_52/30 | 2.2. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөх, барилгажуулах ажлыг хур тундасны усыг хуримтлуулан усан сан байгуулах замаар тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах | “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулах ажлыг БХБЯ болон НЗДТГ хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд зөвлөх “Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 21 чиглэлээр судалгаа, үнэлгээний ажил болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дуусган, ИД- 2025/2021 тоот экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулан, БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2021.12.10-ны өдрийн хурлаар, БХБ-ын сайдын зөвлөлийн 2021.12.15-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлээд байна. Тус баримт бичигт Улаанбаатар хотын хүн ам, барилгажилтын хэт төвлөрлийг задалж соёл боловсрол, банк, санхүү, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий “Яармаг” шинэ хотын төв, “Баянхошуу”, “Сэлбэ”, “Шинэ төв”, “Сонсголон”, “Амгалан” дэд төв болон гэр хорооллын бүсэд 26 олон нийтийн дэд төвийг шинээр байгуулахаар тусгасан. Дэд төвүүдэд тус бүр 850 хүний суудалтай 7 соёлын ордон, 33000 м2 талбай бүхий 6 музей, 3200 ортой 10 эрүүл мэндийн байгууллага байхаар төлөвлөсөн.одоогийн байдлаар 57.9% хангамжтай байгаа цэцэрлэг, 84.4% хангамжтай байгаа сургуулийг 2040 он гэхэд бүрэн хангамжтай болгож 451 байршилд цэцэрлэг, 126 байршилд сургуулийг шинээр төлөвлөсөн.<br>Тайлан файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 70% |
| 42 | 86 | Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай 2017-07-19 Дугаар 2017_19/5 | 1. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, тероризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг тус тус үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.<br>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 19/15 дугаар зөвлөмжийг яамны холбогдох газар, хэлтэст хүргүүлж, байгууллагын удирдлагын цахим санд байршуулсан. Зөвлөмжийг хууль хяналтын байгууллага, банк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн чиг үүргийн байгууллагууд хэрэгжүүлж ажиллахаар байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 43 | 87 | Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40 | 2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх | 1.УБ хотын төв цэвэрлэх байгууламжийн төслийн хэрэгжилт 35%-тай.<br>2. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Өмнөговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулсан. Дорноговийн Сайншанд 92,5%, Өвөрхангайн Хужирт 85%, Өвөрхангайн Хужирт сумын цэвэр усны шугамын ажил 50%, Дундговийн Эрдэнэдалай сумын цэвэр усны эх үүсвэрийн ажил 85%, Сүхбаатар аймгийн төвд ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлын зураг төсөл 100%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.<br>2. "МОН-3713" төслийн хүрээнд Архангай, Булган, Өвөрхангай аймгуудын гэр хороололд нийтдээ 610 сайжруулсан нүхэн жорлонг барьж ашиглалтанд оруулсан байна.<br>3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар УБ хотод дараахь 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн 2924 айлыг сайжруулсан, био жорлонтой болгох ажлыг эхлүүлж 2030 айлд суурьлуулаад байна. Үүнд: ЧД-ийн “Эко хороо” төслийн хүрээнд нийт 110 айлаас 73 айлд био жорлон суурилуулсан. Ажлын гүйцэтгэл 70%. ЧД-ийн 7, 8, 9, 10, 11-р хороонд хэрэгжиж буй “Шинэ хороо" төслийн 114 айлд суурьлуулахаас 57 айлд био жорлон суурилуулсан. Ажлын гүйцэтгэл 50%. ХУД-ийн “Гэр хорооллын нүхэн жорлон шинэчлэх ажил”-ын хүрээнд 1050 айлд суурилуулахаас 700 айлд суурилуулсан. Ажлын гүйцэтгэл 70%. БЗД-ийн 20-р хороонд 1050 айлд хөрсөнд нэвчдэггүй жорлон суурилуулахаас 600 айлд суурилуулсан. Ажлын гүйцэтгэл 72 %. СХД-ийн 23, 39-р хорооны 40 айл “Шинэ хороо” төсөлд хамрагдсан. Ажлын гүйцэтгэл 65%. БЗД-ийн 9, 17, 24, 22-р хороонд 250, 19-р хороонд 350 сайжруулсан ариун цэврийн байгууламжийг суурилуулж дууссан. | 100% |
| | 88 | | 2.11. Хо, суурин газрын үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах системийн найдвартай ажиллагааг хангах | - 2018-2020 онд Нийслэлийн 4 дүүрэгт 5 байршилд 5 төсөл арга хэмээ хэрэгжиж, 9,9 км үерийн далан хийгдэхээс 7,7 км үерийн хамгаалалтын барилга байгууламж хийгдсэн.<br>- 21 аймагт 2018-2020 онд 15.9 тэрбум төгрөгөөр 36 км үерийн хамгаалалтын барилга байгууламж баригдсан.<br>-Хэнтий аймгийн Хэрлэн сум, Баянхонгор аймгийн Баянхонгор сумдад 2021 онд 4,6 км үерийн хамгаалалтын далан суваг шинээр ашиглалтад орсон.<br>- УБ хотын Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн өндөржилтийн нэгдсэн зураг төслийг “Престиж инженеринг” ХХК боловсруулахаар гэрээ байгуулсан.<br>- УБ хотын Сүхбаатар дүүргийн 13, 14-р хороо, Баянзүрх дүүргийн 21, 27-р хороонд үерийн далан, Чингэлтэй дүүрэг, 13-р хороо, Хайлаастын автозамын ус зайлуулах сувгийг шинээр барих ажлууд хэрэгжиж байна.<br>- Баян-Өлгий, Хэнтий, Баянхонгор, Булган аймгийн 4 суманд үерийн хамгаалалтын барилга угсралтын ажлууд үргэлжлэн хэрэгжиж байна. | 100% |
| ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл | | | | | |
| 44 | 89 | Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03 | 1. 1. Орон нутагт ажиллаж буй газар хөдлөлт бүртгэх станц, боловсон хүчний<br>чадавхийг дээшлүүлж, үйл ажиллагааг нь олон улсын түвшинд хүргэхэд гадаадын<br>мэргэжлийн тэргүүлэх байгууллагуудтай хамтарч ажиллах, газар хөдлөлтийн<br>бичил мужлалын зураг зохиох, төв суурин газруудын газар хөдлөлтийн<br>үйлчлэлтэй нутаг дэвсгэрт барилгажуулах боломжтой газрыг тодорхойлох арга<br>хэмжээ авах, (Аймаг, нийслэлийн Засаг дарга, ШУА-ийн Одон орон,<br>геофизикийн судалгааны төв) | Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил”-ын хүрээнд Одон орон, геофизикийн хүрээлэнтэй 2018 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 2018/175 дугаартай зөвлөх гэрээг байгуулсан ажиллаж байгаа ба 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл”-ийн хуралд дээрх ажлын санхүүжилтийг яаралтай шийдвэрлэх саналыг танилцуулсан. Үүний дагуу Шадар сайдаас Сангийн яаманд санхүүжилтийг шийдвэрлэх талаар үүрэг даалгавры өгч эхний ээлжинд Хөвсгөл, Өмнөговь, Увс аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалын судалгааг хийхийг даалгасан.<br>Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилтийг 2021 оны төсвийн төсөлд тусгах саналаа 2020 оны 08 дугаар сарын 14-ний 01/2671 тоот, 2022 оны төсвийн төсөлд тусгах саналаа 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 тоот албан бичгээр Сангийн яаманд тухай бүрт хүргүүлсэн боловч одоог хүртэл ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх санхүүжилт шийдэгдээгүйн улмаас зөвлөх үйлчилгээний гэрээт ажил зогсоод байна. Уг асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргад 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр танилцуулсан. Мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 9 аймгийн газар хөдлөлийн бичил мужлалын зургийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлэхэд дэмжлэг хүсэх тухай 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 1/4889 тоот албан бичгийг хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Үүний дагуу Засгийн газрын 2021 оны 58 дугаар тэмдэглэлийн 7-т “дээрх 9 аймгийн төвүүдийн нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг зохиох арга хэмжээ авахыг Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Д.Рэгдэлд” даалгасан. | 70% |
| | 90 | | 4. Газар хөдлөл судлал, барилга байгууламжийн хийц, бүтээцийн сорил<br>шинжилгээний лаборатори, барилгын зураг төсөл, эрдэм шинжилгээ, судалгааны<br>төв байгуулах арга хэмжээг авах, (Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам,<br>нийслэлийн Засаг дарга) | Улсын хэмжээнд нийслэл болон 21 аймагт барилгын материалын сорил, шинжилгээний лаборатори ажиллаж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар 48 нэр төрлийн 13014 ширхэг дээж хүлээн авч сорилт шинжилгээ хийж үр дүнг гаргасан байна.<br>Барилгын материалын лабораторийн барилга болон түүнд шаардлагатай тоног төхөөрөмжийн асуудлыг бүрэн шийдвэрлэх хүрээнд Замын-Үүд болон 21 аймгийн "Барилгын материалын сорил, шинжилгээний лабораторийг шинэчлэх төсөл"-ийн техник туслалцааны 1.0 сая ам долларын буцалтгүй тусламжийг 2022 онд, 95.0 сая ам долларыг 2023 онд тус тус санхүүжүүлэхээр шийдвэрлүүлэв. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 91 | | 7. Гамшгийн үед онцгой горимоор ажиллах шаардлагатай дулааны цахилгаан станц, цахилгаан, дулааны эрчим хүч дамжуулах, түгээх байгууламж, тээвэр, ачаа, зорчигчийн терминал, харилцаа холбоо, телевиз, радио зэрэг дэд бүтцийн объектууд, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, химийн болон бусад хорт бодис, нян өсгөвөр бүхий газруудын аюулгүй ажиллагааны журам, зааврыг боловсруулж хэрэгжүүлэх, (Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга) | БХБ-ын сайдын 2007 оны 35 дугаар тушаалаар "Барилгын материалын үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн дүрэм", БХБ-ын сайдын 2014 оны 109 дүгээр тушаалаар "Бетон зуурмагийн шахуургын аюулгүй ажиллагааны дүрэм", БНААХДТ-ийн 2005 оны 23 дугаар тушаалаар "Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар", БХБААГ-ын даргын 2004 оны а/112 дугаар тушаалаар "Барилгын инженер-геологи, геотехникийн ажилд мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг тус тус баталсан. | 100% |
| | 92 | | 12. Аймаг, нийслэлийн газар хөдлөлтийн үйлчлэлтэй нутаг дэвсгэрт барих барилгын давхрын тохиромжтой тоог тогтоосон "Өндөр барилга, байгууламжийг төлөвлөх норм" боловсруулан, мөрдүүлэх, (Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам) | Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 429 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Барилгын зураг төсөл боловсруулах барилгын норм ба дүрэм "Өндөр барилгын төлөвлөлт" /БНбД 31-17-10/-ийг баталсан. | 100% |
| | 93 | Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах, усны нөөцийг зүй зохистой хэрэглээнд шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2014-12-30 Дугаар 2014_70/31 | 4. Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн дээд эх үүсвэрийн тэжээгдлийн муж, хамгаалалтын бүсэд баригдсан аялал жуулчлал, амралтын газруудыг бохир ус цэвэрлэх байгууламжтай болгож, хог хаягдал, бохирын усыг хатуу хянах. | - "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулах ажлыг БХБЯ болон НЗДТГ хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд зөвлөх "Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 21 чиглэлээр судалгаа, үнэлгээний ажил болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дуусган, ИД- 2025/2021 тоот экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулан, БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2021.12.10-ны өдрийн хурлаар, БХБ-ын сайдын зөвлөлийн 2021.12.15-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлээд байна. Тус баримт бичигт Улаанбаатар хотын хүн ам, барилгажилтын хэт төвлөрлийг задалж соёл боловсрол, банк, санхүү, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий "Яармаг" шинэ хотын төв, "Баянхошуу", "Сэлбэ", "Шинэ төв", "Сонсголон", "Амгалан" дэд төв болон гэр хорооллын бүсэд 26 олон нийтийн дэд төвийг шинээр байгуулахаар тусгасан. Дэд төвүүдэд тус бүр 850 хүний суудалтай 7 соёлын ордон, 33000 м2 талбай бүхий 6 музей, 3200 ортой 10 эрүүл мэндийн байгууллага байхаар төлөвлөсөн.одоогийн байдлаар 57.9% хангамжтай байгаа цэцэрлэг, 84.4% хангамжтай байгаа сургуулийг 2040 он гэхэд бүрэн хангамжтай болгож 451 байршилд цэцэрлэг, 126 байршилд сургуулийг шинээр төлөвлөсөн.<br>- Улаанбаатар хотын бохир усны Туул 1 коллекторын хамгаалалтын зурвас газрын кадастрыг хийж, улсын бүртгэлд бүртгэх, шаардлагатай газар чөлөөлөлтийн талаар судалгаа, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор 2021.01.07-ны өдөр шугамын трассын дагуу газар дээр нь танилцсан. Ажлын хэсгээс шугамын трассын дагуу байр зүйн зургийн тодотголыг 22 байршилд хийх шаардлагатай гэж үзэж, холбогдох зардлын тооцоог гаргасан. 2021.04.05-ны 21/07 дугаар бүхий байр зүйн зураг боловсруулах ажлын даалгавар батлагдаж, гүйцэтгэгчийг 2021.05.31-нд шалгаруулсан. | 70% |
| 45 | 94 | | 6. Туул, Сэлбэ, Дунд голын бохирдлыг бууруулсны үндсэн дээр голуудын дагуух эргийн тохижилт, үйлчилгээний ажлыг гүйцэтгэж, иргэдийн амралт, чөлөөт цагийг аятухтай өнгөрүүлэх, аялах нөхцлийг бүрдүүлэх. | - "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулах ажлыг БХБЯ болон НЗДТГ хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд зөвлөх "Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 21 чиглэлээр судалгаа, үнэлгээний ажил болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дуусган, ИД- 2025/2021 тоот экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулан, БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2021.12.10-ны өдрийн хурлаар, БХБ-ын сайдын зөвлөлийн 2021.12.15-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлээд байна. Тус баримт бичигт Улаанбаатар хотын хүн ам, барилгажилтын хэт төвлөрлийг задалж соёл боловсрол, банк, санхүү, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий "Яармаг" шинэ хотын төв, "Баянхошуу", "Сэлбэ", "Шинэ төв", "Сонсголон", "Амгалан" дэд төв болон гэр хорооллын бүсэд 26 олон нийтийн дэд төвийг шинээр байгуулахаар тусгасан. Дэд төвүүдэд тус бүр 850 хүний суудалтай 7 соёлын ордон, 33000 м2 талбай бүхий 6 музей, 3200 ортой 10 эрүүл мэндийн байгууллага байхаар төлөвлөсөн.одоогийн байдлаар 57.9% хангамжтай байгаа цэцэрлэг, 84.4% хангамжтай байгаа сургуулийг 2040 он гэхэд бүрэн хангамжтай болгож 451 байршилд цэцэрлэг, 126 байршилд сургуулийг шинээр төлөвлөсөн.<br>- АНУ-ын МСС-ийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийн төсөл болон "Дэд бүтцийн хөгжил" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 95 | | 7. Иргэн, аж ахуйн нэгж, зуслангийн айл өрхийн ус хангамжид ашиглаж байгаа төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийг цэгцэлж, төвлөрсөн шугаманд шат дараалан холбох. | - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2021.07.05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.<br>- СБД-ийн 18-р хорооны “Бичил дэд төв” төслийн 1-р /эхний/ үе шатыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж барилга угсралтын ажлын гүйцэтгэл 95%-тай хэрэгжсэн ба “Ковид” цар тахлын нөлөөгөөр бараа материал хил гааль дээр гацсан тул гүйцэтгэгч, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгчийн төлөөллийг байлцуулан 2021.12.06-ны өдөр хуралдаж төслийн ажлын гэрээг сунгах, 2022 оны эхний хагас жилд инженерийн шугам сүлжээг ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн.<br>Бичил дэд төвийн барилга угсралтын ажил-100%, гадна ус хангамжийн ажил-95%, ф 300 мм голчтой 300 м, салбар ф150 мм голчтой 250 м гадна ариутгах татуургын ажил-95%, цахилгаан, холбоо дохиолол-90% дулаан механик-07-1 ш 035 зуух 2 ш, 1200 квт ялтсан дулааны узел 100%. Төслийн ажлын нийт гүйцэтгэл 95%-тай. | 100% |
| | 96 | | 9. Шинээр барьж буй суурьшлийн бүсүүдэд цэвэрлэх байгууламжийг төлөвлөж орчин үеийн бохир ус цэвэрлэх, эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлэх | 1.УБ хотын төв цэвэрлэх байгууламжийн төслийн хэрэгжилт 30%-тай.<br>2. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Өмнөговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулсан. Дорноговийн Сайншанд 92,5%, Өвөрхангайн Хужирт 85%, Өвөрхангайн Хужирт сумын цэвэр усны шугамын ажил 50%, Дундговийн Эрдэнэдалай сумын цэвэр усны эх үүсвэрийн ажил 85%, Сүхбаатар аймгийн төвд ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлын зураг төсөл 100%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.<br>3.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улс (БНПУ)-ын Засгийн газар хооронд 2017 оны 5 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл /Баян-Өлгий, Увс, Завхан, Дорнод, Говьсүмбэр/”-ийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.<br>Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих 4 багцад буюу Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр аймгуудын төвийн Цэвэрлэх байгууламж барихаар БНПУлсын “Эй Би Индастри” ХХК (түншлэлийн толгой компани), “Смарт Уэйст Технологи” ХХК (түншлэлийн гишүүн), Дорнод аймгийн төвийн Цэвэрлэх байгууламж барихаар БНПУлсын “Мелиорекс” ХХК тус тус шалгарч яамтай 2021.07.15-ны өдөр гэрээ байгуулаад байна.<br>БНПУ-ын гүйцэтгэгчийн зураг төсөл боловсруулах багийн төлөөлөл төслийн ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргах зорилгоор 2021.12.14-ний өдөр Улаанбаатар хотод ажиллан ажлын тоо хэмжээнд тулгалт хийсэн. ТЭЗҮ боловсруулах, судалгааны ажлууд хийгдэж байна.<br>4. Говь-Алтай, Баянхонгор аймгийн төв, Улаанбаатар хотын Багануур дүүргийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг гүйцэтгэхээр хөрөнгийн эх үүсвэрийг 2022 оны Улсын төсөвт 40,0 тэрбум төгрөг тусгуулахаар саналаа хүргүүлсэн. | 100% |
| ЗГ-ын тогтоол | | | | | |
| 46 | 97 | “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах тухай 2017-01-04 Дугаар 2017_5 | 2. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулж, Үндэсний хороогоор хэлэлцүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаярт даалгасугай. | 1.“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” /ХАНСХЕТ/ боловсруулах арга зүйг боловсруулж, ХАНСХЕТ-ний ажлын явцын танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2021.03.15-ны өдөр 1/917 тоот албан бичгээр хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 2021.03.17-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 18 дугаар хуралдааны тэмдэглэл гарсан. Тус хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ХБТТУТ хууль болон Хот байгуулалтын тухай хуулиудын хэрэгжилтийн уялдааг хангах, ”Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” болон “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын баримт бичгүүдийг боловсруулах үйл ажиллагааг харилцан уялдуулж, зохицуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон удирдамжийг боловсруулан БХБС-ын 2021.06.02-ны өдрийн 126 дугаар тушаалаар баталж, ҮХГ-т 2021.06.02-ны өдрийн 3/2068 тоот албан бичгээр хүргүүлсэн. ҮХГ-тай хамтарсан уулзалтыг 2021.10.20, 11.1-2-ний өдрүүдэд 3 удаа зохион байгуулж, эдийн засгийн бүс, бүлэг суурингийн тогтолцоо, хүн амын хэтийн тооцоо зэрэг асуудлуудыг харилцан уялдаатай төлөвлөсөн.<br>2.“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг батлах тухай” УИХ-ын тогтоол, үзэл баримтлалын төслийг боловсруулж, Зөвлөх баг болон Барилгын хөгжлийн төвд цахимаар хүргүүлж, холбогдох саналыг авсан.<br>3. ХАНСХЕТ-ийг боловсруулах 2018/199, 2020/249 дугаартай гэрээнүүдэд эхлэлийн, дундын, эцсийн нийт 7 тайлан ирүүлэхээр тусгаснаас эхлэлийн 2, дунд шатны 2, “Хүн амын өсөлт, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн дэд бүтэц”, “Аж үйлдвэр дэд бүтэц”, “Хүн амын нутагшилт, суурьшил” зэрэг 3 боть ХАНСХЕТ-ийн эцсийн тайланг боловсруулж дуусаад байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 47 | 98 | Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-02-06 Дугаар 2018_43 | 1.2. гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулахад шаардлагатай нийгмийн болон инженерийн дэд бүтэц, шугам сүлжээг бий болгож, барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх, инженерийн хангамжийн “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламж болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарыг татан оролцуулах замаар нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт; | Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний баримт бичиг боловсруулах ажлыг “Инженер геодези” ХХК 2020/69 тоот гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа бөгөөд тус компаниас эхлэлийн болон дундын шатны тайланг боловсруулж захиалагчийн хяналт хийгдсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 137 дугаар тушаалаар тус ажилд магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах орон тооны бус экспертүүдийг томилж, магадлалын нэгдсэн дүгнэлт 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр 709/2021 дугаартай гарсан. ГЗБГЗЗГ-аас 2021.11.24-ний өдрийн 2/2285 тоот албан бичгээр эцсийн шатны тайланд захиалагчийн хяналт хийсэн ЗХТ/ТХТ-3 дугаартай дүгнэлтийг ирүүлсэн. МАЭ-ийн даргадэх “Архитектр, хот төлөвлөлтийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021.04,15-ны өдөр хэлэлцүүлсэн, БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗХ-аар 2021.12.21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн.<br>СБД-ийн 18-р хорооны “Бичил дэд төв” төслийн 1-р /эхний/ үе шатыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж барилга угсралтын ажлын гүйцэтгэл 95%-тай хэрэгжсэн ба “Ковид” цар тахлын нөлөөгөөр бараа материал хил гааль дээр гацсан тул гүйцэтгэгч, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгчийн төлөөллийг байлцуулан 2021.12.06-ны өдөр хуралдаж төслийн ажлын гэрээг сунгах, 2022 оны эхний хагас жилд инженерийн шугам сүлжээг ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн.<br>Бичил дэд төвийн барилга угсралтын ажил-100%, гадна ус хангамжийн ажил-95%, ф 300 мм голчтой 300 м, салбар ф150 мм голчтой 250 м гадна ариутгах татуургын ажил-95%, цахилгаан, холбоо дохиолол-90% дулаан механик-07-1 ш 035 зуух 2 ш, 1200 квт ялтсан дулааны узел 100%. Төслийн ажлын нийт гүйцэтгэл 95%-тай.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| | 99 | | 1.10. Улаанбаатар хотын дагуул хот, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах талаар дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт, дагуул хот, дэд төв, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт; | -Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ хотыг байгуулах, үндэсний хэмжээний томоохон дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт 4,103.5 сая төгрөгийн санхүүжилтээр бүсийн хөгжлийн төсөл, шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, шинэ суурьшлын бүс, логистикийн төвийн судалгаа, ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлууд хийгдэж байна.<br>-Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг АХБ-ны 2021-2024 оны стратегийн түншлэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх саналаа Сангийн яаманд 2021.01.08-ны өдрийн 1/68 тоот албан бичгээр хүргүүлсэн. Цэвэрлэх байгууламж, гадна шугам сүлжээний төсвийг шинэчилсэн. АХБ, Европын сэргээн босголтын хөгжлийн банкны санхүүжилтээс 5,0 сая долларыг зарцуулахаар төлөвлөж байна. Мөн паркийн дулааны станцын төсвийг шинэчлэн боловсруулсан.<br>“Дархан үйлдвэрлэл, технологийн парк байгуулах” төслийн хүрээнд нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа арьс, шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийг шилжүүлэх хүртэлх хугацаанд "Харгиа" урьдчилан цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжийн засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлтэд зориулж БХБ-ын Сайдын багцаас зураг төсөлд 350.0 сая төгрөг, барилга угсралтын ажилд 1650.0 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдэж худалдан авах ажиллагааг УСУГ-т шилжүүлсэн.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| | 100 | | 1.11. гэр хорооллын суурьшлын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийн дэд төвүүд барьж байгуулахтай холбогдуулан стандарт боловсруулж батлуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт; | СБД-ийн 18-р хорооны “Бичил дэд төв” төслийн 1-р /эхний/ үе шатыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж барилга угсралтын ажлын гүйцэтгэл 95%-тай хэрэгжсэн ба “Ковид” цар тахлын нөлөөгөөр бараа материал хил гааль дээр гацсан тул гүйцэтгэгч, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгчийн төлөөллийг байлцуулан 2021.12.06-ны өдөр хуралдаж төслийн ажлын гэрээг сунгах, 2022 оны эхний хагас жилд инженерийн шугам сүлжээг ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн.<br>Бичил дэд төвийн барилга угсралтын ажил-100%, гадна ус хангамжийн ажил-95%, ф 300 мм голчтой 300 м, салбар ф150 мм голчтой 250 м гадна ариутгах татуургын ажил-95%, цахилгаан, холбоо дохиолол-90% дулаан механик-07-1 ш 035 зуух 2 ш, 1200 квт ялтсан дулааны узел 100%. Төслийн ажлын нийт гүйцэтгэл 95%-тай. | 100% |
| 48 | 101 | “Майдар хот төсөл”-ийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2019-01-16 Дугаар 2019_32 | 1. “Майдар хот төсөл”-ийг “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын хүрээнд судалж, эрх бүхий этгээдээр хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийлгэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад тус тус даалгасугай. | Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний баримт бичиг боловсруулах ажлыг “Инженер геодези” ХХК 2020/69 тоот гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа бөгөөд тус компаниас эхлэлийн болон дундын шатны тайланг боловсруулж захиалагчийн хяналт хийгдсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 137 дугаар тушаалаар тус ажилд магадлалын нэгдсэн дүгнэлт гаргах орон тооны бус экспертүүдийг томилж, магадлалын нэгдсэн дүгнэлт 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр 709/2021 дугаартай гарсан. ГЗБГЗЗГ-аас 2021.11.24-ний өдрийн 2/2285 тоот албан бичгээр эцсийн шатны тайланд захиалагчийн хяналт хийсэн ЗХТ/ТХТ-3 дугаартай дүгнэлтийг ирүүлсэн. МАЭ-ийн даргадэх “Архитектр, хот төлөвлөлтийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021.04,15-ны өдөр хэлэлцүүлсэн, БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗХ-аар 2021.12.21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 49 | 102 | Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо батлах тухай<br>2019-03-21<br>Дугаар 2019_106 | 2. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо батлагдсантай холбогдуулан барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг шинэчлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэгдсэн барилгын салбарын техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд даалгасугай. | "Барилга, байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт", "Барилгын материал бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн зохицуулалт", "Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын техникийн даалгаврыг батлуулсан.<br>Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн ба ажлын дундаж гүйцэтгэл 78,3 хувьтай байна. Үүнд:<br>1. "Барилга, байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын баримт бичгийн боловсруулалт-85 хувьтай.<br>2. "Барилгын материал бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын баримт бичгийн боловсруулалт-55 хувьтай.<br>3. " Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын баримт бичгийн боловсруулалт-95 хувьтай. | 70% |
| 50 | 103 | Нийтийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2019-12-25<br>Дугаар 2019_474 | 2. Хот, суурин газарт ус хангамж, ариутгах татуурга, ариун цэврийн байгууламж болон цэвэрлэх байгууламж, төвлөрсөн дулаан хангамжийн систем, нийтийн халуун усны төв бий болгох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэж, тэдгээрийг орон сууц, нийтийн аж ахуйн мэргэжлийн байгууллагад хариуцуулан зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Эрчим хүчний зохицуулах хороо (А.Тлейхан), Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (Ж.Батсуурь) нарт үүрэг болгосугай. | 1.УБ хотын төв цэвэрлэх байгууламжийн төслийн хэрэгжилт 30%-тай.<br>2. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Өмнөговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулсан. Дорноговийн Сайншанд 92,5%, Өвөрхангайн Хужирт 85%, Өвөрхангайн Хужирт сумын цэвэр усны шугамын ажил 50%, Дундговийн Эрдэнэдалай сумын цэвэр усны эх үүсвэрийн ажил 85%, Сүхбаатар аймгийн төвд ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлын зураг төсөл 100%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.<br>3.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улс (БНПУ)-ын Засгийн газар хооронд 2017 оны 5 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл /Баян-Өлгий, Увс, Завхан, Дорнод, Говьсүмбэр/”-ийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.<br>Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих 4 багцад буюу Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр аймгуудын төвийн Цэвэрлэх байгууламж барихаар БНПУлсын “Эй Би Индастри” ХХК (түншлэлийн толгой компани), “Смарт Уэйст Технологи” ХХК (түншлэлийн гишүүн), Дорнод аймгийн төвийн Цэвэрлэх байгууламж барихаар БНПУлсын “Мелиорекс” ХХК тус тус шалгарч яамтай 2021.07.15-ны өдөр гэрээ байгуулаад байна.<br>4. Сумын хөгжил төслийн хүрээнд сумдад нийтийн халуун усны болон ахуйн үйлчилгээний төв бий болгох ажлын хүрээнд Булган, аймгийн 2 сум, Увс аймгийн 2 сум, Хөвсгөл аймгийн 3 сум, нийт 8 ажлыг эхлүүлж, 2 ажил дууссан байна.<br>-.Хөвсгөл, Тариалан сумын нийтийн халуун усны барилгын ажлын зураг төслийг боловсруулан, ажлыг гүйцэтгэж 2021.12.06-нд ашиглалтад оруулсан. Ажлын гүйцэтгэл 100%,<br>-Увс, Бөхмөрөн сумын халуун усны барилгын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, 2021.07.30-нд байнгын ашиглалтад оруулсан. Ажлын гүйцэтгэл 100%.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| | 104 | | 3. Хот, суурин газрын нүхэн жорлонгийн тоог цөөрүүлэх, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ил задгай бие засах байдлыг зогсоох талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, хандлагыг нь өөрчлөх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (Ж.Батсуурь) нарт даалгасугай. | 1. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Өмнөговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулсан. Дорноговийн Сайншанд 92,5%, Өвөрхангайн Хужирт 85%, Өвөрхангайн Хужирт сумын цэвэр усны шугамын ажил 50%, Дундговийн Эрдэнэдалай сумын цэвэр усны эх үүсвэрийн ажил 85%, Сүхбаатар аймгийн төвд ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлын зураг төсөл 100%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.<br>2. "МОН-3713" төслийн хүрээнд Архангай, Булган, Өвөрхангай аймгуудын гэр хороололд нийтдээ 610 сайжруулсан нүхэн жорлонг барьж ашиглалтанд оруулсан байна.<br>3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар УБ хотод дараахь 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн 2924 айлыг сайжруулсан, био жорлонтой болгох ажлыг эхлүүлж 2030 айлд суурьлуулаад байна. Үүнд: ЧД-ийн “Эко хороо” төслийн хүрээнд нийт 110 айлаас 73 айлд био жорлон суурилуулсан. Ажлын гүйцэтгэл 70%. ЧД-ийн 7, 8, 9, 10, 11-р хороонд хэрэгжиж буй “Шинэ хороо" төслийн 114 айлд суурьлуулахаас 57 айлд био жорлон суурилуулсан. Ажлын гүйцэтгэл 50%. ХУД-ийн “Гэр хорооллын нүхэн жорлон шинэчлэх ажил”-ын хүрээнд 1050 айлд суурилуулахаас 700 айлд суурилуулсан. Ажлын гүйцэтгэл 70%. БЗД-ийн 20-р хороонд 1050 айлд хөрсөнд нэвчдэггүй жорлон суурилуулахаас 600 айлд суурилуулсан. Ажлын гүйцэтгэл 72 %. СХД-ийн 23, 39-р хорооны 40 айл “Шинэ хороо” төсөлд хамрагдсан. Ажлын гүйцэтгэл 65%. БЗД-ийн 9, 17, 24, 22-р хороонд 250, 19-р хороонд 350 сайжруулсан ариун цэврийн байгууламжийг суурилуулж дууссан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 51 | 105 | Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай<br>2020-05-06<br>Дугаар 2020_167 | 1.2. гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх хилийн боомт, цэвэрлэх байгууламж, гэр хорооллын барилгажилт, автозамын зэрэг бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан нарт; | 1.УБ хотын төв цэвэрлэх байгууламжийн төслийн хэрэгжилт 35%-тай.<br>2. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Өмнөговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулсан. Дорноговийн Сайншанд 92,5%, Өвөрхангайн Хужирт 85%, Өвөрхангайн Хужирт сумын цэвэр усны шугамын ажил 50%, Дундговийн Эрдэнэдалай сумын цэвэр усны эх үүсвэрийн ажил 85%, Сүхбаатар аймгийн төвд ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлын зураг төсөл 100%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.<br>3.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улс (БНПУ)-ын Засгийн газар хооронд 2017 оны 5 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл /Баян-Өлгий, Увс, Завхан, Дорнод, Говьсүмбэр/”-ийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.<br>Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих 4 багцад буюу Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр аймгуудын төвийн Цэвэрлэх байгууламж барихаар БНПУлсын “Эй Би Индастри” ХХК (түншлэлийн толгой компани), “Смарт Уэйст Технологи” ХХК (түншлэлийн гишүүн), Дорнод аймгийн төвийн Цэвэрлэх байгууламж барихаар БНПУлсын “Мелиорекс” ХХК тус тус шалгарч яамтай 2021.07.15-ны өдөр гэрээ байгуулаад байна.<br>БНПУ-ын гүйцэтгэгчийн зураг төсөл боловсруулах багийн төлөөлөл төслийн ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргах зорилгоор 2021.12.14-ний өдөр Улаанбаатар хотод ажиллан ажлын тоо хэмжээнд тулгалт хийсэн. ТЭЗҮ боловсруулах, судалгааны ажлууд хийгдэж байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 52 | 106 | Тусгай зөвшөөрөл олгох тухай<br>2020-06-12<br>Дугаар 2020_217 | 4. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад, паркийн дэд бүтцийг барьж байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн нарт тус тус үүрэг болгосугай. | ХХААХҮЯ, НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО) хамтран “Мал төхөөрөх, мах боловсруулах загвар үйлдвэр”-ийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), мастер төлөвлөгөө, “Ховд аймгийн Үйлдвэрлэл, технологийн Парк” (ХҮТП)-ийн урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.<br>"Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн парк"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад 19 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шийдэгдэж, ирэх 2022 оноос бүтээн байгуулалтын ажил эхлэхээр төлөвлөсөн байна. Ингэснээр эрчим хүч, дулаан, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг дэд бүтэц нь шийдэгдсэн, хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлсэн нөхцөлд иргэн, аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэл эрхлэх боломжтой болох юм. | Хугацаа болоогүй |
| | 107 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2020-12-13<br>Дугаар 2020_211 | 1. Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэхийг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай: | Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 242 дугаар тушаалаар “Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журам” болон “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ыг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Төрөөс хариуцах төлбөрт цэвэр, бохир усны төлбөр, усны суурь тариф /хураамж/, гэр хорооллын ус түгээх байрнаас борлуулах болон зөөврөөр хүргэх усны төлбөр, тусгай зөвшөөрөлтэйгээр зориулалтын тээврийн хэрэгслээр бохир ус татан зайлуулах төлбөрүүд багтаж байна.<br>Дээрх тогтоолын хүрээнд 2020 оны 12-р сард 728.1 мянган айл өрх, 24.2 мянган аж ахуйн нэгжийн цэвэр, бохир усны төлбөр 10.9 тэрбум төгрөг,<br>2021 онд нийт 132.9 тэрбум төгрөг цэвэр, бохир усны төлбөрийн хөнгөлөлтөд зарцуулсан байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 53 | 108 | | 3. Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, цэвэр, бохир усны эх үүсвэр болон шугам сүлжээ, түгээлтийн техникийн хүчин чадлын боломжит хэмжээтэй уялдуулан үйлчилгээний төлбөр, хураамжийг төрөөс хариуцан төлөх хэрэглээг өмнөх оны мөн үеийн хэрэглээтэй жишиж, энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг одоо мөрдөгдөж байгаа батлагдсан тарифт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар тус тус тооцож, гүйцэтгэлийг сар бүр хянан баталгаажуулах ажлыг журамлан зохион байгуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Эрчим хүчний зохицуулах хороо (А.Тлейхан), Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (Ж.Батсуурь), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 242 дугаар тушаалаар “Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журам” болон “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ыг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Төрөөс хариуцах төлбөрт цэвэр, бохир усны төлбөр, усны суурь тариф /хураамж/, гэр хорооллын ус түгээх байрнаас борлуулах болон зөөврөөр хүргэх усны төлбөр, тусгай зөвшөөрөлтэйгээр зориулалтын тээврийн хэрэгслээр бохир ус татан зайлуулах төлбөрүүд багтаж байна.<br>Дээрх тогтоолын хүрээнд 2020 оны 12-р сард 728.1 мянган айл өрх, 24.2 мянган аж ахуйн нэгжийн цэвэр, бохир усны төлбөр 10.9 тэрбум төгрөг,<br>2021 онд нийт 132.9 тэрбум төгрөг цэвэр, бохир усны төлбөрийн хөнгөлөлтөд зарцуулсан байна. | 100% |
| | 109 | | 4. Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хэмнэлтийн горимд ажиллуулж, үр ашгийг дээшлүүлэх, халдвар, хамгааллын онцгой дэглэмийг чанд баримтлах, халдвараас хамгаалах, урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Орон сууц, нийтийн аж ахуйн тусгай зөвшөөрөлтэй 83 байгууллагын 741,2 мянган айл өрх, 24,4 мянган аж ахуйн нэгжийн унд, ахуйн усны аюулгүй байдлыг хангаж, хаягдал уснаас халдвар авах эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна. | 100% |
| 54 | 110 | Жагсаалт батлах тухай<br>2021-01-15<br>Дугаар 2021_15 | 3. “Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт, “Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.<br>Энэ тогтоолын 3 дугаар хавсралтад заасан бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах ажиллагааг урьд нь байгуулсан ерөнхий гэрээний хүрээнд зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Уг тогтоолын дагуу яаманд зохион байгуулагдахаар батлагдсан нийт 44, ТХААГ эрх шилжүүлсэн 11, аймаг, нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн 42, нийт 97, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх ТЭЗҮ, зураг төсвийн 104, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих 16, нийт 217 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий 43 үнэлгээний хороо байгуулагдсан ба нийт 214 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдсан байна. | 100% |
| 55 | 111 | Төлөвлөгөө батлах тухай<br>2021-03-03<br>Дугаар 2021_53 | 2. Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт тус тус үүрэг болгосугай. | “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг БХБС-ын 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 161 дүгээр тушаалаар байгуулан хэрэгжилтийг хангаан ажиллаж байна.<br>Энэхүү төслийн зорилго нь шинэ ТЦБ-аас цэвэрлэн гарах хаягдал усыг дахин боловсруулж, Дулааны 3 болон 4 дүгээр цахилгаан станцуудын техникийн усны зориулалтаар (голчлон хөргөлтөд) эргүүлэн ашиглахад оршино. Тус төслийн ТЭЗҮ боловсруулагдаж батлагдсан.<br>Дахин боловсруулсан ус дамжуулах шугам хоолой, ДЦС 3, 4 ТӨХК-ийн техникийн усны схемд модификаци хийх зураг төсөл боловсруулах, байгаль орчны үнэлгээ хийх, шугам хоолойн трассын дагуу нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерт 6 компаниас санал ирүүлснийг хүлээж авч, шалгарсан компанитай цахимаар 2021.08.04-ний өдөр гэрээг үзэглэлээ. Мөн Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Монгол дахь ЖАЙКА-гийн дэд суурин төлөөлөгч Ёшимура Токужи нар "Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн баримт бичигт 2021.12.13-ний өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан. 2021 онд төлөвлөсөн ажлууд хийгдсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 56 | 112 | “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” батлах тухай 2021-03-10 Дугаар 2021_58 | 3. Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай. | Салбарын ажиллах хүчний эрэлтийг тодорхойлох ажлын хүрээнд МБҮА, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хийсэн хуралд оролцож, санал бодлоо, яамнаас баримталж буй чиглэлийг танилцуулсан. БХБЯ-тай МБҮА-ийн байгуулах гэрээнд бригадаар ажиллах хүчний судалгааг гаргах асуудлыг тусгасан.<br>Эрэлтийн судалгааны програм хангамжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс авч ашиглахад бэлэн болсон. Төсөл, томоохон бүтээн байгуулалтад шаардлагатай мэргэжлийн судалгааг гаргахад 2361 ИТА, ГТА-уудын мэргэжлүүд байна.<br>Барилгын салбарын үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (ҮАМАТ)-ын төслийг салбарын оролцогч байгууллагуудаар дахин хэлэлцүүлэхээр холбогдох бүх материалуудыг ХНХЯ-нд хүргүүлсэн ба ХНХ-ын сайдаар батлуулах ажил Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүлээгдэж байна.<br>ШУТИС-ийн Барилга, архитекторын сургуультай удаа дараагийн уулзалтуудыг хийж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд суурилан мэргэжилтэн бэлтгэх нэн шаардлагатай ба ялангуяа ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр мэргэжилтэн, ажиллах хүчний хомсдолыг нөхөх чиглэлд хамтран ажиллахаар тохирсон. Сайдаас 2021.9.29-ны 1/3841 тоот албан бичгээр БСШУ-ны сайдад ус хангамж, ариутгах татуургын мэргэжлээр ШУТИС-д оройн анги нээж, мэргэжилтэн бэлтгүүлэх хүсэлтийг тавьж, шийдвэрлүүлсэн. | 100% |
| 57 | 113 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-03-24 Дугаар 2021_70 | 1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай: | 1.1. Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын хүрээнд нийт 2,497.1 сая төгрөгийн санхүүжилт бүхий 23 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд авсанаас 1,934.5 сая төгрөгийн санхүүжилт бүхий 20 төсөл, арга хэмжээг, 2021 оны 253 дугаар тогтоолоор 2,514.9 сая төгрөгийн санхүүжилт бүхий 16 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд авсанаас 1,741.6 сая төгрөгийн санхүүжилт бүхий 14 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлийг үндэслэн Сангийн яаманд хүргүүлж хянуулан чөлөөлүүлсэн. Үлдсэн ажлуудын барьцаа хөрөнгийн дансанд авсан санхүүжилтийг чөлөөлүүлэхэд хяналт тавин холбогдох арга хэмжээг авч ажиллахыг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй "БХТөв" ТӨААТҮГ-т яамны 2020 оны 3/3524, 2021 оны 6/3329, 3/4069 тоот албан бичгүүдээр мэдэгдсэн.<br><br>1.2. Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож Сангийн яамны PIMIS программаар хөрөнгө оруулалтын санхүүжилтийн шуурхай, нээлттэй, ил тод байдлыг хангаж, төсвийн тухайн жилд багтаан санхүүжүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна.<br><br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 58 | 114 | Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-04-07 Дугаар 2021_89 | 1. Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийн барилга байгууламжийг барьж байгуулах ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан хянан баталгаажуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, барилгын ажлыг 2021 оны II улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ), барьж байгуулах ажиллагаа нь төмөр замын хөдөлгөөний болон техникийн аюулгүй ажиллагаа, барилга байгууламжийн технологийн горим, стандарт, шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт тус тус даалгасугай. | БХБ-ын яамнаас "Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийн барилга байгууламжийг барьж байгуулах ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан хянан баталгаажуулах" ажлын даалгаврын төсөлд санал өгсөн. Ажлын даалгаврыг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга баталсан. Тус арга хэмжээг УУХҮ-ийн яам хариуцан хэрэгжүүлэх ба БХБ-ын яамнаас холбогдох арга хэмжээг авч ажилласан. | 100% |
| 59 | 115 | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Монгол Улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай 2021-04-08 Дугаар 2021_93 | 5. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт тус тус үүрэг болгосугай. | Байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэж болох зардлыг хэмнэн, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 60 | 116 | Боловсролын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээний тухай 2021-05-05 Дугаар 2021_127 | 3. Сонгон шалгарсан гүйцэтгэгчтэй холбогдох гэрээг байгуулан, гүйцэтгэлд нь захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар (Х.Бадамсүрэн) нарт, захиалагчийн хяналт тавихад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт тус тус даалгасугай. | МУ-ын 16 аймгийн 104 сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар шинэчлэхээр 2021.05.10-нд 54 сумын, 2021.06.10-нд 50 сумын ажлын даалгаврыг аймгийн Засаг дарга нараар батлуулж, БШУЯ-д хүргүүлсэн. БШУЯ-наас барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж ажлыг эхлүүлээд байна. БХБЯ-наас холбогдох арга хэмжээг авч ажилласан. | 100% |
| 61 | 117 | Нийслэл Улаанбаатар хотын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-05-19 Дугаар 2021_146 | 6. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дагуул хот, суурьшлын бүсийг үе шаттайгаар байгуулах зорилгоор Богдхан төмөр замыг барьж ашиглалтад оруулах ажлыг эрчимжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд, Богдхан уулын дархан цаазат газрын хилийн заагт өөрчлөлт оруулах асуудлыг судалж, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасанд, Нийслэл Улаанбаатар хот, Төв аймаг хооронд үүссэн хилийн цэсийн маргааныг судалж, хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт тус тус даалгасугай. | - Нийслэл, Төв аймгийн хилийн цэсийг тодотгох, хилийн цэстэй холбоотой маргааныг шийдвэрлэх, газар олголтын нөхцөл байдлын талаар дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг БХБ-ын сайдын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 67 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна. Уг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн талаар Төв аймгийн ИТХ-ын 2021 оны 06 дугаар тогтоол, Нийслэлийн ИТХ-ын 2021 оны 169 дүгээр тогтоол тус тус батлагдан гарсан.<br>Дээрх тогтоолуудыг үндэслэн “Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянчандмань, Баянцогт, Эрдэнэ, Сэргэлэн сумдын хилийн цэсийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалийн төслийг боловсруулан батлуулахад бэлэн болоод байна. | 100% |
| 62 | 118 | “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг батлах тухай 2021-06-01 Дугаар 2021_161 | 2. “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.<br><br>2. Энэ тогтоолын 1-д заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсөв, гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхланд, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт тус тус даалгасугай. | - "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээний хүрээнд тус төсөл арга хэмжээнд хэрэглэгдэх халаалтын зуухны барилга, цэвэр ус хангамжийн гүний худаг, өндрийн усан сан, цэвэр ус хангамжийн даралтат цамхаг, шугамд холбогдсон болон зөөврийн ус хангамжтай ухаалаг ус түгээх байр, нийтийн халуун ус, бохир ус цэвэрлэх байгууламжийн нэг маягийн зураг төслийн сонгон шалгаруулалтад "ББСМО" ХХК шалгарсан ба зураг төслийн боловсруулалт дуусаж, зураг төсөл, төсөвт магадлал хийгдэж байна.<br>- Төв аймгийн Борнуур сумын төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилтын ажлын зураг төслийн сонгон шалгаруулалтад "Алтайн газрын хүч" ХХК шалгарч, зураг төслийн боловсруулалт дуусан магадлал хийлгэхэд бэлэн болоод байна.<br>- Төв аймгийн Баянчандмань, Сэргэлэн, Эрдэнэ сумдын төвийн болон гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, тохижилтийн ажлын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтад "Гидро дизайн инноваци" ХХК шалгарч зураг төслийн боловсруулалт дуусч, магадлал хийлгэхэд бэлэн болсон. | 70% |
| | 119 | | 3. “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд сумдын Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээ нэгдсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай. | “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Төв аймгийн Сэргэлэн, Баянчандмань, Эрдэнэ сумдад БХБЯ-ны НААИДББХЗГ-ын дарга, Төв аймгийн холбогдох байгууллагуудын болон зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгч компанийн төлөөллүүд 2021.08.13-ны өдөр газар дээр очиж, зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан. Сумын төвийн төвлөрсөн инженерийн дэд бүтцийн системийн ашиглалт, үйлчилгээг эрхлэдэг аж ахуйн нэгжүүдийн судалгааны маягтыг боловсруулж, судалгаа ирүүлэх тухай 2021.08.20-ны өдрийн 8/3338 тоот албан бичгийг Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлээд байна.<br>Тус заалтын хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцана. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 63 | 120 | Тусгай зөвшөөрөл олгох тухай 2021-08-04 Дугаар 2021_230 | 2. Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д 5 жилийн хугацаатай олгосугай.<br><br>2. Богдхан төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2021 оны 3 дугаар улиралд багтаан эхлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт тус тус даалгасугай. | МУ-ын ЗГ-ын 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор Богдхан төмөр замын суурь бүтцийн технологийн иж бүрдэл болох инженерийн дэд бүтэц, эрчим хүч, усан хангамж, өртөө, зөрлөгийн болон дохиолол холбоо, мэдээллийн барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулж, магадлал хийлгэх, тэдгээрийг барихад шаардлагатай зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу тухай бүрд нь шуурхай олгож ажиллахыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон. “Богдхан төмөр зам” төслийн нээлт 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдөр болсон.<br>Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр Хөшигийн хөндий, “Олон улсын нисэх онгоцны “Чингис хаан” буудлыг түшиглэн бий болох "Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логистикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн судалгаа, эх үүсвэрийг тодорхойлох үнийн тооцоолол болон зураг төсөл боловсруулах” ажлын гүйцэтгэгчээр нийслэлийн “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ шалгарч зураг төслийн ажил хийгдэж дууссан.<br>Зураг төслийн ажил “Шинэ Зуунмод” хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилтай уялдуулан боловсруулалт хийгдэж байна.<br>БХБ-ын яамнаас холбогдох арга хэмжээг авч ажилласан. | 100% |
| 64 | 121 | Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулах тухай 2021-08-11 Дугаар 2021_234 | 4. Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны үйл ажиллагааг эрхлэх асуудлынхаа хүрээний бодлого, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн төлөвлөгөөтэй харилцан уялдуулж, хяналт тавьж хамтран ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт үүрэг болгосугай. | Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 234 дүгээр тогтоолоор Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааг байгуулсаны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 174 дүгээр тушаалаар тус захиргааны дүрэм, бүтэц, орон тоог баталж, 2021 оны батлагдсан төсвийн багцад зохицуулалт хийх замаар нийт 138.0 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэн үйл ажиллагааг нь эхлүүлж, яамнаас мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.<br>Тус яамнаас Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаатай хамтран “Шинэ Зуунмод” хот болон “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах чиглэлээр гадаад орнуудын туршлагыг судлах, хамтын ажиллагаа тогтоох, холбогдох тооцоо, төлөвлөлтийг боловсруулах ажлыг хийж байна. Энэ ажлын хүрээнд БНСУ-д суугаа Монгол Улсын Элчин сайдын яамтай тогтмол харилцаж, ажлын уулзалтуудыг цахимаар нийт 4 удаа зохион байгуулснаас гадна БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яам, Инчон хотын захиргаа болон Инчоны чөлөөт бүсийн захиргаатай хамтран ажиллах яриа хэлцлийг хийж, албан хүсэлтүүдийг хүргүүлээд байна. | 100% |
| 65 | 122 | Төслийн жагсаалт шинэчлэн батлах тухай 2021-08-31 Дугаар 2021_271 | 2. Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотноо 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр, Монгол Улсын Улаанбаатар хотноо 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд 40.0 сая еврогийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.<br><br>2. Энэ тогтоолын хавсралтад заасан төслийг хэрэгжүүлэх талаар Бүгд Найрамдах Австри Улсын талтай тохиролцож, холбогдох гэрээг байгуулахыг Сангийн сайд Б.Жавхланд, төслийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай. | "МУ-ын ЗГ, БНАУ-ын ЗГ хоорондын 2019 оны Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр"-т заасны дагуу Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу сонгон шалгаруулах ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг Сангийн яамнаас 2021.12.03-ны өдөр тус яаманд ирүүлээд байна.<br>Үүний дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үр дүнг Сангийн яаманд мэдэгдэж, зээлийн тусгайлсан хэлэлцээрийг байгуулна. | 70% |
| 66 | 123 | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай 2021-09-08 Дугаар 2021_280 | 2. “Туул-Сонгино усны нөөцийн цогцолбор” төслийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт 5 байршилд нийт 43.6 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээг хавсралт ёсоор баталсугай.<br><br>2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан газрын мэдээллийг газрын кадастрын улсын мэдээллийн санд бүртгэж, холбогдох журмын дагуу газар ашиглуулах гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (Ц.Ганхүү)-т даалгасугай. | "Туул-Сонгино усны нөөцийн цогцолбор"-ын 43.6 га газрын хил заагийг харуулсан зураг, холбогдох тогтоол шийдвэрийн төсөл, танилцуулга, материалыг бэлтгэж 2021 оны 09 дүгээр 06-ны өдөр БХБЯ-нд хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 280 дугаар тогтоолоор "Туул-Сонгино усны нөөцийн цогцолбор" төслийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт 5 байршилд нийт 43.6 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээг баталсан.<br>Засгийн газрын 2017 оны “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах түүний хэмжээ заагийг тогтоох, ашиглах журам”-ын 3.13.2, 3.13.3-т заасны дагуу гурвалсан гэрээ байгуулж, газар ашиглах гэрчилгээ олгох ажил хийгдэж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 67 | 124 | Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2021-09-29<br>Дугаар 2021_299 | 5. Шинжлэх ухааны Академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшиж байгаа 18 га газрыг зориулалтын дагуу ашиглуулах зорилгоор улсын тусгай хэрэгцээнд авах эсэх асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай. | Боловсрол, шинжлэх ухааны яамнаас газрыг улсын тусгай хэрэгцээнд авах хүсэлтээ ирүүлээгүй.<br>ГЗБГЗЗГ-аас Нийслэлийн Засаг даргад 2017 онд Шинжлэх ухааны Академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшиж байгаа 18 га газрыг тусгай хэрэгцээнд авах талаар санал хүргүүлэхэд бусдын эзэмшил газартай давхцалтай гэсэн шалтгаанаар тусгай хэрэгцээнд авах асуудал шийдвэрлэгдээгүй. | 100% |
| 68 | 125 | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай<br>2021-10-06<br>Дугаар 2021_307 | 2. Энэ тогтоолын 1-д заасан талбайд газарт өмчилж, эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээдийн газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авахад шаардагдах зардлын хэмжээ, чөлөөлөх хугацааг тохиролцох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт даалгасугай. | Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөж буй 19390.4 га газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа нийт 2983 нэгж талбарын 7603.7 га газар давхцаж байна. Давхцалтай 2983 нэгж талбараас газар дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа болон үл хөдлөх хөрөнгөтэй 183 нэгж талбарт Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 202/196 дугаар хамтарсан тушаалаар баталсан аргачлал, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 203 дугаар тушаалын дагуу мэргэжлийн байгууллагаар урьдчилсан үнэлгээ хийлгэхэд 40.532.510.036 төгрөгийн нөхөх олговорын тооцоо гарсан. | 100% |
| | 126 | | 3. Энэ тогтоолын 1-д заасан газрыг газрын кадастрын улсын мэдээллийн санд бүртгэж, газар ашиглуулах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (М.Буяндэлгэр)-т даалгасугай. | Газрыг газрын кадастрын улсын мэдээллийн санд бүртгэж, газар ашиглуулах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт даалгасны дагуу газрын кадастрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэсэн. | 100% |
| 69 | 127 | Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай<br>2021-10-13<br>Дугаар 2021_314 | 2. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор энэ тогтоолын хавсралтад заасан Засгийн газрын тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.<br><br>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан салбар, орон нутгийн түвшинд батлан хэрэгжүүлж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, хуульд нийцүүлэх арга хэмжээг 2021 оны 12 дугаар сард багтаан авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Салбарт мөрдөгдөж байсан Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан "Түрээсийн орон сууц" хөтөлбөр болон Засгийн газрын 2020 оны 94 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого" хүчингүй болсон. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан дунд хугацааны зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах хүрээнд салбарын нөхцөл, байдлын шинжилгээг холбогдох аргачлалын дагуу хийж, 2021.10.25-ны 1/4207 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100% |
| 70 | 128 | Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай<br>2021-10-13<br>Дугаар 2021_315 | 3. Аж ахуйн нэгжийн улсын тооллогод өөрийн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах орон тооны бус ажлын хэсэг байгуулж, тооллогын ажилд татан оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тооллогын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай. | Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу 5 жилд нэг удаа зохион байгуулдаг аж ахуйн нэгж байгууллагын ээлжит тооллого 2021.11.01-ний өдрөөс 2021.12.01-ний өдөр хүртэл цахим хэлбэрээр зохион байгуулагдсан. “Аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны улсын тооллого”-ын хүрээнд Комиссын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдын хариуцах ажлын чиг, үүргийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>1. Барилга, хот байгуулалтын дэд сайдын 2021.11.03-ны өдрийн 2/4342 тоот “Аж ахуйн нэгжийн улсын тооллогод хамруулах тухай” албан бичгийг харьяа байгууллагуудад хүргүүлсэн.<br>2. Цахим системд бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээллийг 2021.11.01-ний өдөр ҮСХ, аж ахуйн нэгжийн ээлжит тооллогын улсын комисст хүргүүлсэн.<br>3. Аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны улсын тооллогын зорилго, ач холбогдлыг тусган, салбарын нийт аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамрагдахыг уриалсан уриалгыг гарган, цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр дамжуулан хүргэж байна. /www.mcis.gov.mn, www.gazar.gov.mn, www.mnca.mn, www.tz.mnca.mn, www.wsrc.mn, www.barilga.gov.mn, www.bmat.mn, www.tosk.gov.mn, яам болон харьяа байгууллагуудын олон нийтийн сүлжээгээр дамжуулан мэдээлсэн/<br>4. Бизнес эрхлэгчдийн байршил, төвлөрөл, үйл ажиллагааны чиглэл, эдийн засаг, нийгмийн оролцоонд үндэслэн бодлого, хөтөлбөр боловсруулах, мэдээллийн эх үүсвэр бүрдүүлэх, судалгаа хөгжүүлэлт, инноваци, бизнесийн төлөв байдлыг тодорхойлох зэрэгт чухал ач холбогдолтой аж ахуйн нэгжийн 2021 оны улсын ээлжит тооллогод барилгын салбар 99 хувьтай хамрагдлаа. Үүнд: Барилга, хот байгуулалтын яам болон харьяа байгууллагууд, барилгын салбарын төрийн бус байгууллагууд, салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 71 | 129 | Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-10-20 Дугаар 2021_321 | 4. “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг орон нутагт хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, сургалтын хөтөлбөрийн давхардлыг арилгах, тухайн орон нутгийн онцлог, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон хот, тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, газар олголт, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Бүсийн төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах арга хэмжээг уялдуулах зорилгоор Төвийн бүсийн тулгуур төв Дархан-Уул хот, Баруун бүсийн тулгуур төв Ховд, Улиастай хотууд, Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотуудын Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнүүдийн мэдээллийг тоон хэлбэрээр 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 3/3756 тоот албан бичгээр БШУЯ-нд хүргүүлсэн.<br>“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний баримт бичигт МУИС, ШУТИС, ХААИС зэрэг их дээд сургуулиудыг Эрдэнэт, Дархан-Уул, Өмнөговь аймгууд руу шилжүүлэхээр тооцон тусгаад байна. Урьдчилсан тооцоогоор Улаанбаатар хотод 157 мянга гаруй оюутан сурагчид суралцаж байгааг үе шаттайгаар 43 мянга буюу хөдөө, орон нутагт 10 мянга, Жаргалант, Налайх, Багахангай, Майдар, Шинэ Зуунмод хот руу 33 мянган оюутан суралцагчийг шилжүүлэхээр тусгаад байна.<br>“Дорнод аймгийн Дорнод их сургуулийн хотхон хэлбэрээр зүүн бүсийн сургалт эрдэм шинжилгээ,үйлдвэрлэл бизнесийн төв болгон хөгжүүлэн шинэчлэн байгуулах хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” зургийн даалгаврыг 2019.6.11-ний өдөр БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг, БХБ-ын сайд Х.Баделхан, Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нар /18/381/008 тоот/ баталсан. “Дорнод их сургуулийн шинэ хотхоны зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах” ажлыг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, “Мон-Энержи консалт” ХХК-тай 2019.08-20-ны өдөр УТХО-12.1.41/2019 тоот гэрээг байгуулан боловсруулж байна.<br>“Дорнод их сургуулийн шинэ хотхоны зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл”-ийг МАЭ-ийн дэргэдэх “Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021 оны 03 сарын 24-ний өдрийн 2-р хурлаар хэлэлцүүлж, БШУЯ-аас санал авч тусган дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. | 100% |
| | 130 | | 5. Энэ тогтоолын 1.1-д заасан төрийн өмчийн их, дээд сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвийн төсөлд тусгахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, 1.2-т заасан Шинжлэх ухаан, технологийн сургуулийн харьяа сургууль байгуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөв болон тухайн орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт, 1.3-т заасан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, Монгол Улсын Их сургуулийн бүрэлдэхүүн “Эрдэнэт” сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх болон нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх зохих арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга С.Батжаргал, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Х.Бадамсүрэн) нарт тус тус даалгасугай. | "Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" /Орхон, Баян-Өндөр сум/, "Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц" /Улсын хэмжээнд/, Хабитат, Мангирт чиглэлийн дулаан хангамжийн 2 дугаар контур /Дархан-Уул, Дархан сум, 15 дугаар баг/, Цэвэр усны шугамын шинэчлэл /Дархан-Уул, Дархан сум/ зэрэг төсөл, арга хэмжээнүүдийг 2022 оны Төсвийн тухай хуулиар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 70% |
| 72 | 131 | Жагсаалт батлах тухай 2021-12-01 Дугаар 2021_359 | 2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг техникийн хяналтын зардлын тооцооны хамт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус шилжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Монгол Улсын 2022 оны төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийн Ерөнхийлөн захирагчдад хуваарилсан жагсаалт батлах тухай Засгийн газрын 359 дүгээр тогтоол гарсан ба уг тогтоолын дагуу Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 267 дугаар тушаал гарсан.<br>Барилга, хот байгуулалтын сайдын багцад 2022 онд шинээр хэрэгжүүлэх нийт 124 төсөл, арга хэмжээ батлагдсан ба үүнээс Засгийн газрын 359 дүгээр тогтоолын дагуу 22 төсөл, арга хэмжээг тус яаманд, 20 төсөл, арга хэмжээг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, 50 төсөл, арга хэмжээг аймаг нийслэлд эрх шилжүүлэн зохион байгуулахаар шийдвэрлэсэний дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулан “tender.gov.mn” цахим системд нийтэлж, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжүүсэн. Мөн нийт төсөл, арга хэмжээнээс зураг төсөв, ажлын даалгавартай ажлуудын жагсаалтыг гарган үнэлгээний хороодыг байгуулан тендер зарлах бэлтгэл хангаад байна. 2022 оны 01 сарын 11-ний өдрийн байдлаар нийт 124 төсөл арга хэмжээнээс 12 төсөл, арга хэмжээний тендер зарлагдаад байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 132 | | 4. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус даалгасугай. | Барилга, хот байгуулалтын сайдын багцад 2022 онд шинээр хэрэгжүүлэх нийт 124 төсөл, арга хэмжээ батлагдсан ба үүнээс Засгийн газрын 359 дүгээр тогтоолын дагуу 22 төсөл, арга хэмжээг тус яаманд, 20 төсөл, арга хэмжээг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, 50 төсөл, арга хэмжээг аймаг нийслэлд эрх шилжүүлэн зохион байгуулахаар шийдвэрлэсэний дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулан "tender.gov.mn" цахим системд нийтэлж, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжүүсэн. Мөн нийт төсөл, арга хэмжээнээс зураг төсөв, ажлын даалгавартай ажлуудын жагсаалтыг гарган үнэлгээний хороодыг байгуулан тендер зарлах бэлтгэл хангаад байна. 2022 оны 01 сарын 11-ний өдрийн байдлаар нийт 124 төсөл арга хэмжээнээс 12 төсөл, арга хэмжээний тендер зарлагдаад байна. | 100% |
| 73 | 133 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2021-12-14<br>Дугаар 2021_397 | 1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.<br>1.1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн өмнөх онд хийсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж санхүүжүүлэх;<br>1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөлөөллөөс үүдэн улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж гэрээ нь байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах;<br>1.3. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөрт багтаан бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.<br>2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | Барилга, хот байгуулалтын сайдын багцын хүрээнд нийт 75 төсөл, арга хэмжээний 39,289.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд авсан байна. | 100% |
| Ерөнхий сайдын захирамж | | | | | |
| 74 | 134 | Ажлын хэсэг байгуулах тухай "Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-нд тодотгол хийх<br>2017-07-03<br>Дугаар 2017_122 | 2. Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хэрэгжилтийг дүгнэн асуудлыг цогцоор нь судалж, саналаа Ерөнхий сайдад тухай бүр танилцуулан чиглэл авч ажиллахыг Ажлын хэсэгт даалгасугай. | • "Шинэ Зуунмод" болон "Майдар" хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• "Шинэ Зуунмод" болон "Майдар" хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий "Шинэ Зуунмод", "Зуунмод", "Майдар", Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. "Богд хан" төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 75 | 135 | Ажлын хэсэг байгуулах тухай “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” 2017-12-06 Дугаар 2017_175 | 2. “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллан ажлын явцыг Монгол Улсын Ерөнхий сайдад тухай бүр танилцуулан чиглэл авч байхыг Ажлын хэсэг (Х.Баделхан)-т үүрэг болгосугай. | “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн барилга байгууламжийн зураг төслийг Шанхай хотын зураг төслийн хүрээлэн боловсруулсан. Нийт 38 объектийн зураг төсөл хийгдэхээс 11 барилга нь магадлалаар хянагдсан. Бусад нь хянагдаж байна. 98%-ийн гүйцэтгэлтэй.<br>Цахилгааны 35/10кВ-ын дэд станц, ЦДАШ, дулаан хангамж, цэвэр, бохир усны шугамын зураг төслийг боловсруулж, батлуулсан. БУА: 25%-ийн гүйцэтгэлтэй. Элс баригч, 1-р 2-р тунгаагуур, хойд биореактор, захиргааны барилга, лаг өтгөрүүлэгч, лаг өтгөрүүлэгч, метантенк зэрэг 12 барилгын БУА хийгдэж байна.<br>Тоног төхөөрөмж татан авалт: Нийт 17 гэрээг үйлдвэрлэгч нартай байгуулсан.<br>Ажиллах хүчин: 2021.06.19-ний өдөр 35 ИТА-г оруулж ирсэн. Дотоодын туслан гүйцэтгэгч 13 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажиллуулсан. Сургалтууд зохиогдсон. КОВИД –ын үед ажиллах түр журам, төлөвлөгөөг батлуулж, ажилласан. Цар тахлаас шалтгаалан Хятадын талын ажиллах хүчин, зарим бараа материал орж ирээгүй.<br>Төслийн хэрэгжилт 2020 онд 15% байсан бол 2021 онд 35%-д хүрсэн нь төслийн нэгжийн төлөвлөлт, менежментээс шалтгаалсан гэж дүгнэж байна. Мөн туслан гүйцэтгэгчдийг дотоодоосоо /Монгол Улс/ авч ажиллуулсан нь төслийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлсэн.<br>Тус төслийг хэрэгжүүлэх арга хэмжээ нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдан хэрэгжилтийг жил бүр тогтмол ЗГХЭГ-т тайлагнаж байна. | 100% |
| 76 | 136 | Ажлын хэсэг байгуулах тухай 2021-03-17 Дугаар 2021_66 | 2. Богдхан уулын дархан цаазат газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хилийн зааг, Нийслэл, Төв аймгийн хилийн цэсийг тодотгож, хилийн цэстэй холбоотой маргааныг шийдвэрлэх арга зам, газар олголтын нөхцөл байдлын талаар дүгнэлт гаргаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн дүгнэлт, саналаа 2021 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Нямдорж)-т даалгасугай. | - БХБ-ын сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 36 тоот тушаалаар дэд ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр БХБЯ-ны хурлын танхимд Барилга хот байгуулалтын сайд, Байгаль орчны сайд болон холбогдох албан тушаалтан Дархан цаазат богдхан уулын улсын тусгай хамгаалалттай газрын хил заагийг тодруулж зурагласан ажлын танилцуулга, ажлын хэсгээс гаргасан Богдхан уулын газрын судалгаатай танилцсан.<br>УИХ-ын Байнгын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулагдсан Дэд ажлын хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр “Богдхан уулын дархан цаазат газар”, “Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар”-ын хил заагийн талаарх мэдээллийг хийсэн.<br>- Нийслэл, Төв аймгийн хилийн цэсийг тодотгох, хилийн цэстэй холбоотой маргааныг шийдвэрлэх, газар олголтын нөхцөл байдлын талаар дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг БХБ-ын сайдын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 67 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна. Уг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн талаар Төв аймгийн ИТХ-ын 2021 оны 06 дугаар тогтоол, Нийслэлийн ИТХ-ын 2021 оны 169 дүгээр тогтоол тус тус батлагдан гарсан.<br>Дээрх тогтоолуудыг үндэслэн “Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянчандмань, Баянцогт, Эрдэнэ, Сэргэлэн сумдын хилийн цэсийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалийн төслийг боловсруулан батлуулахад бэлэн болоод байна. | 100% |
| 77 | 137 | Ажлын хэсэг байгуулах тухай 2021-06-23 Дугаар 2021_111 | 2. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын баримт бичиг, Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус тус тусгагдсан Төв аймгийн Хөшигийн хөндийд байгуулах шинэ дагуул хотуудын нэгдсэн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг 1 дүгээр хавсралт, Ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. Ажлын хэсгийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, удирдамжийн хүрээнд шуурхай зохион байгуулж, ажлын явцыг тухай бүр танилцуулан, чиглэл авч ажиллахыг Ажлын хэсэг (Б.Мөнхбаатар)-т үүрэг болгосугай. | • “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 78 | 138 | 2016 оны 04 дүгээр сарын 4-ний өдөр 20 дугаар тэмдэглэл 2016-04-04 Дугаар 2016_20 | X. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэн дэмжээд уг хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран баталж, хуулийн төслийг боловсруулан зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ, Хууль зүйн сайд Д.Дорлигжав нарт даалгав. | БХБ-ын сайдын 2021 оны 06 дугаар сарын 02-ны 127 дугаар тушаалаар Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан. Ажлын хэсгээс Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төслийг 5 бүлэг, 20 зүйлтэй байхаар боловсруулж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгааны тайлан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийсэн. Олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах ажлын хүрээнд тус яамны Цахим хуудас https://mcud.gov.mn/forum/21 -т уг хуулийн төслийг холбогдох материалуудын хамт 2021 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс байршуулж санал авч, мөн 21 аймгийн ГХБХБГ-аас ирсэн саналуудыг тусган нэгтгэж Засгийн газрын гишүүдээс санал авхаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 70% |
| 79 | 139 | 2017 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр 1 дүгээр тэмдэглэл 2017-01-04 Дугаар 2017_1 | IV.4. Хот, суурин газарт хүн амын хэт төвлөрөл бий болсон шалтгаан, нөхцөлийг тогтоох, түүнийг арилгах чиглэлээр шинэ суурьшил, дэд бүтцийг бий болгох, орон нутагт оруулах хөрөнгө оруулалт болон ажлын байр нэмэгдүүлэх, орон нутагт шилжин суурьших иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулж, дэмжлэг үзүүлэх, урамшуулах асуудлаар хөтөлбөр хэрэгжүүлэх, байгаль экологийн тэнцвэрт байдлыг харгалзан үзэх зэрэг Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг анхаарч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаярт даалгав. | • "Шинэ Зуунмод" болон "Майдар" хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• "Шинэ Зуунмод" болон "Майдар" хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий "Шинэ Зуунмод", "Зуунмод", "Майдар", Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. "Богд хан" төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АНЗ авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br><br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| 80 | 140 | 2019 оны 5 дугаар сарын 29-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2019-05-29 Дугаар 2019_24 | XX.8. Байгалийн түүхийн музейн шинэ барилгын ажлын явцын талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан Байгалийн түүхийн музейн шинэ барилга барих газрын шүүхийн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэх, тус музейн барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан нарт үүрэг болгов. | Байгалийн түүхийн музейн шинэ барилгын зураг төслийн ажил дуусч гүйцэтгэгч байгууллагаас 2020 оын 3-р сард БСШУЯ-нд хүлээлгэн өгсөн байна. Төрийн худалдан авах ажиллагааны газраас Байгалийн түүхийн музейн барилгыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 4 удаа зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй байна. Тус ажлыг Соёлын яам хариуцан ажиллаж байгаа ба БХБ-ын яамнаас шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. | 100% |
| | 141 | 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2019-10-30 Дугаар 2019_47 | YI.2. 2. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот (Аэросити)-ыг хөгжүүлэх, "Майдар хот төсөл"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр хот байгуулах болон холбогдох аймаг, нийслэлийн хилийн цэсэд өөрчлөлт оруулах асуудлыг судалж, зохих шийдвэрийн төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт даалгав. | Төв аймгийн Хөшигийн хөндий дэх шинэ хотуудын нэгдсэн төлөвлөлтийн концепцыг боловсруулж Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанд танилцуулсаны дагуу 38 дугаар тэмдэглэл гарсан. Мөн Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 307 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт 19390.4 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авч, газрын хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг батлуууллаа. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 142 | | ҮI.3. 3. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот (Аэросити)-ыг хөгжүүлэх, “Майдар хот төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох үе шатны ажлын төлөвлөгөө гарган ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт даалгаж, уг ажлыг салбар хоорондын уялдаа, зохицуулалт, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд үүрэг болгов. | • “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 81 | 143 | | ҮI.4. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот (Аэросити)-ыг түшиглэн чөлөөт бүс байгуулах асуудлыг судалж, холбогдох санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нарт даалгав. | “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр, Хөшигийн хөндийд “Чингис хаан” буудлыг даган шинээр байгуулах “Шинэ Зуунмод”, “Майдар” хотууд, Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хот, босоо тэнхлэгийн олон улсын хурдны АН-3 автозам, “Богдхан төмөр зам” тэдгээрийг даган бий болох чөлөөт бүс, тээвэр логистикийн нэгдсэн төв, инженерийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг цогцоор хэрэгжүүлэх орон зайн нэгдсэн төлөвлөлтийн асуудлаар БХБ-ын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанд танилцуулж улмаар ЗГ-ын 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 19 дүгээр тэмдэглэлээр Төв аймгийн нутаг дэвсгэрт шинээр байгуулах “Шинэ Зуунмод”, “Майдар” хотууд, Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хот, “ Богдхан төмөр зам”, босоо тэнхлэгийн олон улсын хурдны АН-3 автозам болон инженерийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг цогцоор хэрэгжүүлэх орон зайн нэгдсэн төлөвлөлтийн концепцийг боловруулж танилцуулахыг БХБ-ын сайд Б.Мөнхбаатарт даалгасан болно.<br>Тус тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 38 дугаар тэмдэглэл гарсан. | 100% |
| | 144 | | ҮI.7. 7. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот (Аэросити)-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн зураг төслийг боловсруулахад шаардагдах 10.4 (арван тэрбум дөрвөн зуун сая) тэрбум төгрөг болон “Майдар хот төсөл”-ийн эхний ээлжийн инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг барьж байгуулахад шаардагдах зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгав. | Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот (Аэросити)-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн зураг төслийг боловсруулахад шаардлагатай 11.385 тэрбум төгрөгийг, Майдар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, эхний ээлжийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зуран төсөл боловсруулахад шаардлагатай 8.767 тэрбум төгрөгийг тусгаад байна.<br>“Шинэ Зуунмод” хотын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу “Некст степ инженеринг” ХХК 600 саятөг дүнтэй 2020/124 тоот ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн “Олон улсын нисэх онгоцны “Чингис хаан” буудлыг түшиглэн бий болох Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логистикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн судалгаа, эх үүсвэрийг тодорхойлох үнийн тооцоолол болон зураг төсөл боловсруулах”, “Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр логистикийн нэгдсэн төв байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, байр зүйн зураг боловсруулах” ажлыг нийслэлийн “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр ажил гүйцэтгэх 405.7 саятөг, 339.5 саятөг дүнтэй 2021/44, 2021/45 дугаар гэрээнүүдийг тус тус байгуулан ажиллаж байна.<br>Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ хотыг байгуулах, үндэсний хэмжээний томоохон дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт 4,103.5 сая төгрөгийн санхүүжилтээр бүсийн хөгжлийн төсөл, шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, байрзүйн зураг, шинэ суурьшлын бүс, логистикийн төвийн судалгаа, ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийн нийт 11 ажил хийгдэж байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 82 | 145 | 2020 оны 6 дугаар сарын 1-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2020-06-01 Дугаар 2020_34 | XI.1. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2020 оны 5 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд Хэнтий аймгийн Галшар, Баянхутаг, Баян-Овоо, Цэнхэрмандал, Хэрлэн сумдад ажиллаж нутгийн удирдлагын байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаг үеийн ажилтай танилцан, төрийн албан хаагчидтай уулзалт хийж, санал бодлыг нь сонссон талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан орон нутгийн удирдлага, иргэдийн зүгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан дараахь санал, хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээ авч, дүнг тайлагнахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:<br><br>1. Хэнтий аймгийн Галшар сумыг Монгол Улсын жишиг сум болгон хөгжүүлэх талаар судлан, санал боловсруулж, хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нарт; | Хэнтий аймгийн Галшар суманд хэрэгжих "Шинэ сум" төслийн ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2021.05.31-нд зарласан. Сонгон шалгаруулалтад “Цагаан зуун” ХХК шалгарсан, зураг төслийн гүйцэтгэгчээр “Урбан девелопмнент консалтинг групп” ХХК ажиллаж байна. Төслөөр дулаан хангамжийн 0.6 км шугам, ундны усны гүний эх үүсвэрийн худаг 2 , өндрийн усан сан 50м3х2, цэвэр ус хангамжийн шугам 2.3 км, бохир ус зайлуулах шугам 1.6 км, цэвэрлэх байгууламж 50м3/хоног хүчин чадалтай байхаар төлөвлөгдсөн.<br>Төслийн ажил 2021.07.27-ны өдрөөс эхэлсэн ба гэрээний хугацаа 2022.07.31-ний өдөр хүртэл байгуулагдсан. Ажлын гүйцэтгэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 1680м бохир усны шугам, дулааны 600м шугамын угсралтын ажлууд бүрэн хийгдэж дууссан. Мөн 400 кВа-ын цахилгаан хангамжийн ажил ажлын тоо хэмжээний дагуу хийгдэж дууссан. Цэвэрлэх байгууламжийн 12 бетон худгийн ажлууд хийгдээд технологийн түр зогсолт хийгээд байна. Төслийн ажил 40%-ийн гүйцэтгэлтэй байна.<br>2021 онд төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн. | 100% |
| | 146 | | XI.2. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх шаардлагатай байгаа зарим арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг дараахь Засгийн газрын гишүүн, байгууллага, албан тушаалтанд даалгав:<br><br>1. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийг боловсруулах, үнэргүйжүүлэх арга хэмжээний дараагийн үе шат болох лаг хатаах байгууламжийг барихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга хот байгуулалтын сайд Х.Баделхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан нарт; | БНХАУ-ын зээлээр УБ хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байгаатай холбогдуулан лаг хатаах, шатаах байгууламжийн стандартыг боловсруулах шаардлагатай болсон.<br>Лаг хатаах, шатаах байгууламжийн “Техникийн ерөнхий шаардлага” стандартыг Улаанбаатар хотын "Үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавх бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдөр гэрээг байгуулаад байна. | 70% |
| 83 | 147 | 2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр 48 дугаар тэмдэглэл 2020-09-09 Дугаар 2020_48 | XI.1. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Дорноговь, Өмнөговь аймгуудад ажилласан талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад даалгав.<br>Тавантолгойн нүүрсний ордын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд үйлдвэр, дэд бүтэц, бүхий хот байгуулалтын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Өмнөговь аймгийн Засаг дарга нарт; | БХБ-ын яамнаас "Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийн барилга байгууламжийг барьж байгуулах ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан хянан баталгаажуулах" ажлын даалгаврын төсөлд санал өгсөн. Ажлын даалгаврыг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга баталсан. Тус арга хэмжээг УУХҮ-ийн яам хариуцан хэрэгжүүлэх ба БХБ-ын яамнаас холбогдох арга хэмжээг авч ажилласан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 84 | 148 | 2020 оны 9 дүгээр сарын 23-ний өдөр 51 дүгээр тэмдэглэл 2020-09-23 Дугаар 2020_51 | XII.6. Тавантолгойн нүүрсний ордын уул уурхайн үйлдвэрлэл болон авто зам, төмөр зам, цахилгаан станц зэрэг дэд бүтцийн төслүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөлтийн зургийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав:<br><br>1. Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн баригдах уул уурхайн үйлдвэрлэл болон авто зам, төмөр зам, цахилгаан станц зэрэг дэд бүтцийн төслүүдийн уялдааг хангасан Тавантолгойн нүүрсний ордын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийг зохих журмын дагуу хийж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт; | БХБ-ын яамнаас "Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийн барилга байгууламжийг барьж байгуулах ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан хянан баталгаажуулах" ажлын даалгаврын төсөлд санал өгсөн. Ажлын даалгаврыг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга баталсан. Тус арга хэмжээг УУХҮ-ийн яам хариуцан хэрэгжүүлэх ба БХБ-ын яамнаас холбогдох арга хэмжээг авч ажилласан. | 100% |
| 85 | 149 | 2020 оны 10 дугаар сарын 7-ны өдөр 53 дугаар тэмдэглэл 2020-10-07 Дугаар 2020_53 | YIII.4. 2. Багшийн ур чадварын үнэлэмжийг нэмэгдүүлж, нийгмийн асуудлыг нь үе шаттай шийдвэрлэх зорилгоор орон сууцны “Багш хотхон” байгуулах асуудлыг судлан үзэж, саналаа танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020.09.22-ны өдрийн 1а/1584 тоот албан бичгээр “Монголын багш нарын шинэ зуун зөвлөлдөх зөвлөл” ТББ-аас “Ногоон хөгжлийн үндэсний нэгдэл” ХК-тай хамтран “Хувьцаат орон сууц” төслийг хэрэгжүүлэн багш нарын орон сууцаар хангаж байгаа талаар мэдэгдсэн бөгөөд энэ арга хэмжээ нь боломжтой эсэх талаар судалгаа хийж, зөвлөгөө өгөх хүсэлтийг ирүүлсний дагуу тус яамнаас 2020.10.13-ний өдөр тус “Ногоон хөгжлийн үндэсний нэгдэл” ХК-ийн гүйцэтгэх удирдлагуудтай уулзаж, төслийг хэрэгжүүлж буй арга аргачлалын талаар тайлбар авсан.<br>Уг “Хувьцаат орон сууц төсөл” нь олон улсад хэрэглэгддэг нийгмийн тодорхой бүлгийн иргэдийн өөрсдийн хүсэл, сааначлага дор нэгдэн, хамтын ажиллагааны хүрээнд асуудлаа ил, тод байдлаар шийдвэрлэх зарчмаар хэрэгждэг арга хэмжээ бөгөөд хувийн хэвшлийн зүгээс хэрэгжүүлж буй уг санаалчлагыг тус яамнаас орон сууцжуулах боломжит нэг хувилбар бөгөөд 2020 оны 10 дугаар сарын байдлаар 275 багш нартай тэдний хүсэл сонирхолд тулгуурлан гэрээ байгуулсанаас 56 багш нь орон сууцанд хамрагдсан, үлдсэн багш нарын хувьд өөрсдийн орон сууцанд хамрагдах хуваарийг хүлээж байгаа болон гэрээнд заасны дагуу 3 жилийн дотор багтаан орон сууцанд хамруулах талаар Боловсрол, шинжлэх ухааны яаманд 2020.11.03-ны өдрийн 01/3517 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>"Монголын багш нарын шинэ зуун зөвлөлдөх зөвлөл" ТББ-аас 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 09 дугаар албан бичгээр "Хувьцаа орон сууц багш - 5000" төслийн явцын мэдээллийг ирүүлсэн бөгөөд Барилга, хот байгуулалтын яамны зүгээс төслийг хэрэгжүүлэгч "Бүргэд Констракшн" ХХК болон "Батхэрэйд" ХХК-иудад барилга угсралтын ажлын хөнгөлөлттэй зээл олгох хүрээнд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг Монгол Улсын Хөгжлийн банкинд 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 3/1281 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100% |
| | 150 | | YIII.4. 5. 2022 онд багтаан модон жорлон бүхий сургууль, цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах ажлыг үе шаттайгаар хийх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт. | МУ-ын 16 аймгийн 104 сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар шинэчлэхээр 2021.05.10-нд 54 сумын, 2021.06.10-нд 50 сумын ажлын даалгаврыг аймгийн Засаг дарга нараар батлуулж, БШУЯ-д хүргүүлсэн. БШУЯ-наас барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж ажлыг эхлүүлээд байна. БХБЯ-наас холбогдох арга хэмжээг авч ажилласан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 86 | 151 | 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2020-10-14 Дугаар 2020_54 | XXII.1. Зорилтот бүлгийн иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан орон нутгийн хөгжлийн сангийн тодорхой хэсгийг тухайн орон нутгийн зорилтот бүлгийн иргэдийг орон сууцжуулахад зарцуулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран судалж, тодорхой санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт даалгав. | Орон нутгийн хөгжлийн сангийн тодорхой хэсгийг тухайн орон нутгийн зорилтот бүлгийн иргэдийг орон сууцжуулахад зарцуулах саналаа УИХ дахь МАН-ын бүлэгт 2020.10.19-ний өдөр танилцуулсан.<br>Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд тусган хэрэгжилтийг хангуулж ажиллахаар шийдвэрлэсэн. Аймгуудын орон нутгийн хөгжлийн санд жилд 7.3-12.8 тэрбум төгрөгийн эх үүсвэр хуваарилдаг ба тус эх үүсвэр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг ашиглан дэд бүтэц нь шийдэгдсэн бэлэн газар дээр 120 айлын түрээслээд өмчлөх орон сууцыг барих хүрээнд холбогдох судалгааг хийж байна. Дэд бүтцийн судалгаагаар түрээсийн орон сууц барихад инженерийн дэд бүтцийн хангамж шийдвэрлэгдсэн 12 аймаг, тодорхой хэмжээнд шийдвэрлэгдсэн 6 аймаг, хангалтгүй байгаа 3 аймаг байна.<br>Цаашид Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд аймгуудад түрээсийн орон сууц байгуулах тогтвортой санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх хүрээнд хамтран ажиллана. | 100% |
| 87 | 152 | 2021 оны 2 дугаар сарын 3-ны өдөр 8 дугаар тэмдэглэл 2021-02-08 Дугаар 2021_8 | I.4. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 оны 2 дугаар сарын 2-ны өдөр барилгын салбарын зарим төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын дүнгийн талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэдийг орон сууцжуулах замаар хүн амын хөгжлийг хангах, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэхэд чиглэгдсэн зорилтыг хуримтлалын нэгдсэн сан байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан нэгдсэн цогц, уялдаатай байдлаар хэрэгжүүлэх чиглэлээр дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:<br>1. иргэдийг орон сууцжуулах асуудлаар санал солилцох, уулзалт зохион байгуулах болон орон сууцны хороолол барих байршлыг газар дээр нь судалж, нэг маягийн зураг төслөөр барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт; | Монгол Улсын Алсын хараа 2050, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөр болон Монгол Улсын Ерөнхий сайдаас 2021 оны 02 дугаар 02-ны өдрийн барилгын салбарын төлөөллүүдтэй хийсэн уулзалтын үеэр өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 43 дугаар захирамжаар “Залуус” орон сууцны цогцолбор байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.<br><br>Төслийн концепц, техникийн шийдлийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Морингийн даваа орчмын “ТОСК” ТӨХХК-ийн 57 га талбайд төслийг хэрэгжүүлэхээр тогтож, Барилга, хот байгуулалтын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч хамтран 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр 2021/03 дугаартай "Залуус цогцолбор орон сууцны хороолол барих ажлын даалгавар"-ыг баталсан.<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу “Залуус 1” орон сууцны хорооллын техник эдийн засгийн урьдчилсан судалгаа, эх загвар зураг /эскиз/ боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулсан. Техник эдийн засгийн урьдчилсан судалгааг 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдөр дуусгаж хүлээлгэн өгсөн бөгөөд Архитектор төлөвлөлтийн даалгавар 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдөр, Эх загвар зураг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр тус тус батлагдсан.<br>Хорооллын цахилгаан хангамж болон инженерийн бэлтгэл арга хэмжээний зураг төсөл боловсруулах ажил, авто зам, замын байгууламжийн доогуурх хонгилын системийн зураг төсөл боловсруулах ажил, гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах ажил болон орон сууцны барилгын ажлын зураг төсөл боловсруулах ажил тус тус гэрээ байгуулагдан хийгдэж эхлээд байгаа ба 2021 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар дунджаар 80 хувьд хүрээд байна. | 100% |
| 88 | 153 | 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2021-02-17 Дугаар 2021_11 | XII.12. 9. Улаанбаатар хот доторх болон хот орчмын ачааны төвлөрсөн терминалуудын байршлын дахин төлөвлөлтийг хийж танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар нарт. | “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулах ажлыг БХБЯ болон НЗДТГ хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд зөвлөх “Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 21 чиглэлээр судалгаа, үнэлгээний ажил болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дуусган, ИД- 2025/2021 тоот экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулан, БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2021.12.10-ны өдрийн хурлаар, БХБ-ын сайдын зөвлөлийн 2021.12.15-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлээд байна.<br>Төлөвлөлтийн хүрээнд Улаанбаатар хот доторх болон хот орчмын ачааны төвлөрсөн терминалууд буюу Нийслэлийн логистикийн төвүүдийг 3 бүсийн хэмжээнд байгуулахаар төлөвлөсөн. Үүнд:<br>1. Улаанбаатар хот доторх логистикийн бүс;<br>2. Хот ормын нутаг дэвсгэрийн логистикийн бүс;<br>3.Улаанбатаарын бүсийн логистик гэж тус тус төлөвлөж байна.<br>Байршлын хувьд Улаанбаатар хотод хотын хүнс бараа, бүтээгдэхүүний хэрэгцээг хангах нийт 46 865 га бүхий 9 ширхэг дамжуулан түгээх төвүүдийг төлөвлөж тусгасан, Улаанбаатар хот орчмын логистикийн төвүүдийг дагуул хотууд болон Шинэ Зуунмод, Майдар хотуудыг хамруулан төлөвлөсөн, Улаанбаатар бүсийн логистикийн төвүүдийг хотын баруун талд: Аргалант-Эмээлт, баруун урд талд: Шинэ Зуунмод, зүүн талд: Налайх, Багануур, Багахангайд 471 444 га газарт төлөвлөж байгаа болно.<br>"Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай" УИХ-ын тогтоолын төслийг боловсруулаад байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 154 | 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 13 дугаар тэмдэглэл 2021-02-24 Дугаар 2021_13 | XI.3. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан гадаадын зээл, тусламжийн санхүүжилттэй томоохон төслүүдийн явц, бүтээн байгуулалтын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг дор дурдсан Засгийн газрын гишүүдэд даалгав:<br>1. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор ерөнхий гүйцэтгэгч компанийн гадаадын ажиллах хүчнийг халдвар, хамгааллын горим, дэглэмийг баримтлан хугацаа алдалгүй оруулах, төслийн барилга, байгууламжийн нарийвчилсан зураг төсөл боловсруулж, Монгол Улсын стандартад нийцүүлэх, магадлан баталгаажуулах ажлыг яаралтай дуусгах арга хэмжээг авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; | “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн барилга байгууламжийн зураг төслийг Шанхай хотын зураг төслийн хүрээлэн боловсруулсан. Нийт 38 объектийн зураг төсөл хийгдэхээс 11 барилга нь магадлалаар хянагдсан. Бусад нь хянагдаж байна. 98%-ийн гүйцэтгэлтэй.<br>Цахилгааны 35/10кВ-ын дэд станц, ЦДАШ, дулаан хангамж, цэвэр, бохир усны шугамын зураг төслийг боловсруулж, батлуулсан. БУА: 25%-ийн гүйцэтгэлтэй. Элс баригч, 1-р 2-р тунгаагуур, хойд биореактор, захиргааны барилга, лаг өтгөрүүлэгч, лаг өтгөрүүлэгч, метантенк зэрэг 12 барилгын БУА хийгдэж байна.<br>Тоног төхөөрөмж татан авалт: Нийт 17 гэрээг үйлдвэрлэгч нартай байгуулсан.<br>Ажиллах хүчин: 2021.06.19-ний өдөр 35 ИТА-г оруулж ирсэн. Дотоодын туслан гүйцэтгэгч 13 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажиллуулсан. Сургалтууд зохиогдсон. КОВИД –ын үед ажиллах түр журам, төлөвлөгөөг батлуулж, ажилласан. Цар тахлаас шалтгаалан Хятадын талын ажиллах хүчин, зарим бараа материал орж ирээгүй.<br>Төслийн хэрэгжилт 2020 онд 15% байсан бол 2021 онд 35%-д хүрсэн нь төслийн нэгжийн төлөвлөлт, менежментээс шалтгаалсан гэж дүгнэж байна. Мөн туслан гүйцэтгэгчдийг дотоодоосоо /Монгол Улс/ авч ажиллуулсан нь төслийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлсэн. | 100% |
| | 155 | | XI.3.4. БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Солонго 1 орон сууцны хороолол барих төсөл”, “Солонго 2 орон сууцны хороолол барих төсөл”-ийн зураг төслийг боловсруулах, барилга угсралтын ажлын явцад хяналт тавих, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт; | “Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төсөл”-ийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, захиалагч, зохиогчийн хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээг БНСУ-ын Экспорт-Импортын банкны холбогдох журмын дагуу 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр байгуулж, төслийн хэрэгжилтийг эхлүүлэв.<br>Төслийн хэрэгжилт, хяналт, удирдлагын тогтолцоог хангах хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 116 дугаар тушаалаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-г төсөл хэрэгжүүлэх нэгжээр томилсон. Мөн төсөлтэй холбоотой бүхий л түвшний зураг төслийн ажлуудад дүгнэлт өгөх, тухай бүр мэргэжлийн түвшинд хянуулах, хэлэлцүүлэх, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 153 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.<br>Төслийн Эскиз зураг боловсруулагдаж 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраар батлагдсан. Цаашид гэрээний дагуу 2022 оны 1 дүгээр улиралд багтаан зураг төслийн ажлыг дуусгаж, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг эхлүүлэх ба 2022 оны 2 дугаар улиралд багтаан төслийн барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.<br>2021 онд төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. | 100% |
| | 156 | | XI.3.6. Эрхлэх асуудлын хүрээнд хугацаа хоцорч, хэрэгжилт нь удаашралтай байгаа төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож ажиллахыг холбогдох сайд нарт.” | БХБ-ын сайдын 2021 оны 134 дүгээр тушаалаар барилга, нийтийн аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 9 төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмжөө Төслийн удирдах хороонд 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр танилцуулж хэлэлцүүлсэн. Төслийн удирдах хорооноос төсөл бүрийг үнэлж дүгнэн зөвлөмж өгсөн.<br>БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Ногоон нуур орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих 1008 айлын орон сууцны хотхон” төслийн хэрэгжилт удаашралтай байна. БНХАУ-ын ерөнхий гүйцэтгэгч “Хятадын хоёр дахь металлурги групп корпораци” ХХК-иас нийт 260 хүн ирэхээр тооцож мэдээллээ ирүүлсэн болов ч “Ковид-19” цар тахлаас шалтгаалж хил хаасантай холбоотой Монгол улсад орж ирээгүй байна. Үүнээс шалтгаалж барилга угсралтын ажил эхлээгүй тул төслийн хэрэгжилт удааширсан байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 89 | 157 | | XI.2.1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Нийслэлийн орон сууцны корпораци” хувьцаат компанийг нийлүүлж, өөрчлөн зохион байгуулах замаар төрийн өмч давамгайлсан (жаран зургаан хувиас доошгүй) “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав:<br>1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Нийслэлийн орон сууцны корпораци” хувьцаат компанийг нийлүүлж, өөрчлөн зохион байгуулах асуудлыг нарийвчлан судалж, санал солилцож нэгдсэн байр сууринд хүрэх талаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалантай хамтран зохих арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт; | - НОСК ХК, ТОСК ТӨХХК-тай нэгдэх асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар хэлэлцсэн. Хуралдаанаас нийслэл өөрийн өмчийн компанийг татан буулгах сонирхолгүй байгаагаа илэрхийлсэн. Иймд ТОСК ТӨХХК болон НОСК ХК нэгдэж, Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах асуудал Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээс шалтгаалан түр хойшилсон тул уг чиг үүргийг “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 2022-2026 оны стратеги, төлөвлөгөөний төсөлд тусган боловсруулж, 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 3/3831 тоот албан бичгээр хүргүүлсэн. Уг стратегийг "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн батлуулах шийдвэрийг гаргуулсан. Үүний дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хорооны хурлаар стратегийг шинэчлэн баталсан. | 100% |
| | 158 | | XI.2.3. “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани шинээр байгуулахтай холбогдуулан “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Нийслэлийн орон сууцны корпораци” хувьцаат компанийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, шилжүүлэх, өр төлбөрийг хэрхэн барагдуулах талаар судалж, шийдвэрлүүлэх талаар тодорхой саналаа холбогдох шийдвэрийн төслийн хамт боловсруулан хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (С.Наранцогт)-д; | “Үндэсний Орон сууцны корпораци” ТӨХХК-ийн бүтэц, орон тоо, дүрмийн төслийг боловсруулж Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Үүнтэй холбогдуулан “Нийслэлийн Орон сууцны корпораци” ХК-ийн ТУЗ-өөс Компанийн тухай хуулийн дагуу “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-тай нэгдэх асуудлыг НИТХ-ын 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар хэлэлцэж, нэгтгэх асуудал дэмжигдээгүй тул “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 2022-2026 оны стратеги бүтцийн өөрчлөлтийг хийж, "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор баталсанаар Үндэсний орон сууцны корпорацийн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК ийн чиг үүрэг нэмэгдэж байгаатай холбогдуулан БХБЯ-аас Дэлхийн банкны зөвлөх үйлчилгээгээр чадавх бэхжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. | 100% |
| | 159 | | XI.2.4. “Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулахтай холбогдуулан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан иргэдийг орон сууцжуулахтай холбогдсон зорилт, арга хэмжээг компанийн дүрэмд хэрхэн тусгаж, уялдуулах саналаа танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт.” | -“Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци” ТӨХХК-ийг шинээр байгуулахтай холбогдуулан компанийн дүрэм, чиг үүрэг, бүтэц, орон тоог холбогдох хууль, эрх зүйн хүрээнд боловсруулсан ба хуулийн этгээдийн нэрийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас авч баталгаажуулсан.<br>- НОСК ХК, ТОСК ТӨХХК-тай нэгдэх асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар хэлэлцсэн. Хуралдаанаас нийслэл өөрийн өмчийн компанийг татан буулгах сонирхолгүй байгаагаа илэрхийлсэн. Иймд ТОСК ТӨХХК болон НОСК ХК нэгдэж, Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах асуудал Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээс шалтгаалан түр хойшилсон тул уг чиг үүргийг “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 2022-2026 оны стратеги, төлөвлөгөөний төсөлд тусган боловсруулж, 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 3/3831 тоот албан бичгээр хүргүүлсэн. Уг стратегийг "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн батлуулах шийдвэрийг гаргуулсан. Үүний дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хорооны хурлаар стратегийг шинэчлэн баталсан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 90 | 160 | 2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14 | XII.2.2. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлын төлөвлөгөөг баталж, үндсэн чиглэлд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | 1. Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх хуулийн үзэл баримтлалыг боловсруулж 2021 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр батлуулсан. Хуулийн төсөл тус бүр дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд тусгагдсан судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн хуулийн төсөл тус бүрийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 1/1416 тоот албан бичгээр санал авч, гишүүдийн саналыг хуулиудын төсөлд тусгасан.<br>2. Хуулийн төсөл тус бүрийг хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, энэ хүрээнд 2021 оны 04 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд яамдуудтай, 29-ний өдөр 21 аймгийн ГХБХБГ, нийслэл, 9 дүүргийн ГЗБА, Газрын албатай, 30-ны өдөр мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудтай тус тус хэлэлцүүлэг хийсэн.<br>3. Хуулийн төсөл, үзэл баримтлал холбогдох материалыг хууль тус бүрээр БХБЯ-ны цахим хуудсанд 2021 оны 04 дүгээр сарын 16-аас 05 дугаар сарын 16-ны хооронд байршуулж, олон нийтийн саналыг авч нэгтгэсэн.<br>4. Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, ХХААХҮЯ, УУЯ, БХЯ, БОАЖЯ, ЗТХЯ, ЭХЯ-тай хамтарсан уулзалтыг 2021 оны 08 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд уулзалт хийж хуулийн төслүүдэд эцсийн саналыг авч нэгтгээд байна. Хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>5. Газрын багц хуулийн төслийг Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөлийн 2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Мөн Газрын шинэтгэлийн үндэсний хорооны хурлаар 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хэлэлцүүлж хуулийн төслүүдийг дэмжсэн. | 100% |
| | 161 | | XII.6. Хуримтлалын нэгдсэн сан байгуулах зорилтыг хэрэгжүүлэхээр зохион байгуулсан ажил, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан хуримтлалын нэгдсэн сан байгуулах асуудлаар нэгдсэн ойлголтод хүрч, шаардлагатай эрх зүйн орчин, санхүүжилтийн эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлэх, цаашид хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулан иргэдийг орон сууцжуулах, тэтгэвэр, тэтгэмж, сургалтын тэтгэлэг олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг иргэдийн нийгэм, эдийн засгийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хамтран судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав.” | Хуримтлалын нэгдсэн сан байгуулах хүрээнд Ерөнхий сайдын 2021 оны 79 дугаар захирамжаар судалж, санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/55 дугаар тушаалаар дэд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Олон улсын туршлагыг судлах хүрээнд 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (Singapore Cooperation Enterprise)-тай цахим уулзалт зохион байгуулсан. Үүнтэй холбогдуулан “Монгол Улсад шаардлагатай хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үүднээс Монголын талаас Тимасек олон улсын санд хүргүүлэх хүсэлтийн төслийг Сингапурын хамтын ажиллагааны байгууллагаас боловсруулан 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэнд орон сууцны салбарт тус улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх хүрээнд холбогдох саналыг боловсруулан хүргүүлэв. Сингапур Улсын Темасек сангаас тус саналыг хүлээн авч зөвшөөрсөн бөгөөд нийт 232,400 сингапур долларын өртөг бүхий чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг 2022 онд хамтран хэрэгжүүлэх болсныг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр мэдэгдсэн. Цаашид хөтөлбөрийн агуулга, хамрах хүрээнд холбогдох саналыг тусган зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>МУ-ын Ерөнхий сайдын 2021 оны 249 дүгээр захирамжаар "Иргэдийн орон сууцжуулалтыг нэмэгдүүлэх, хуримтлалын нэгдсэн сан, Үндэсний баялгийн санг бүрдүүлэх, дундаж давхаргыг тэлэх үндсний хорооны бүрэлдэхүүн"-ийг баталсан. Тус үндэсний хороо нь иргэдийг орон сууцжуулах тухай хууль болон Хуримтлалын нэгдсэн сан байгуулах асуудлыг шийдвэрлэх юм. | 100% |
| 91 | 162 | 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2021-03-10 Дугаар 2021_17 | XII.3. Сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох төсөл, арга хэмжээний талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9.4-т заасан нүхэн жорлонтой цэцэрлэг, сурууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд оновчтой шийдлийн хувилбар, тооцоо судалгааг хамтран гаргаж, ажлын даалгавар, зураг төслийг батлуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан нарт даалгав.” | МУ-ын 16 аймгийн 104 сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар шинэчлэхээр 2021.05.10-нд 54 сумын, 2021.06.10-нд 50 сумын ажлын даалгаврыг аймгийн Засаг дарга нараар батлуулж, БШУЯ-д хүргүүлсэн. БШУЯ-наас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан байна. БХБЯ-наас холбогдох арга хэмжээг авч ажилласан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 92 | 163 | 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2021-03-17 Дугаар 2021_18 | XҮ.7. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын явцын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан: 1. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” болон “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” боловсруулах асуудлыг харилцан уялдаатай хэрэгжүүлэх талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Үндэсний хөгжлийн газар (Х.Батжаргал) нарт даалгав. | “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”, МУ-ын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, УБ хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг хот байгуулалтын баримт бичгүүдийг боловсруулах ажлын хоорондын уялдааг хангах, нэгдсэн удирдлагаар зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг БХБ-ын сайд, НЗД бөгөөд УБ хотын Захирагч, Үндэсний хөгжлийн газрын даргын хамтарсан 2021 оны 171/А/65/А625 дугаар тушаалаар байгуулсан. | 100% |
| | 164 | | XҮ.6.1. Эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой 100 төсөл, арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав:<br><br>1. Эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжийг харгалзан 100 төсөл, арга хэмжээг сонгож улсын төсөв, Засгийн газарт өрийн дарамтгүйгээр, хувийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн арга хэлбэрүүдийг ашиглан 2021 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх, хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд; | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээний талаар БХБ-ын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Мөн төсөл арга хэмжээний жагсаалтыг ирүүлсэн маягтын дагуу боловсруулж, яамны 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 1/643 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхээр барилга, хот байгуулалтын салбарын хэмжээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явцыг долоо хоног бүрийн Баасан гаригт Сангийн яаманд хүргүүлж байна. | 100% |
| 93 | 165 | 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24 Дугаар 2021_19 | XҮI.6.1. Төв аймгийн нутаг дэвсгэрт үндэсний хэмжээний хот байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлын явцын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан: 1.Төв аймгийн нутаг дэвсгэрт шинээр байгуулах “Шинэ Зуунмод” болон “Майдар” хот, “Богдхан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН-3 чиглэлийн хурдны авто зам болон инженерийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг цогцоор хэрэгжүүлэх орон зайн нэгдсэн төлөвлөлтийн концепцийг боловсруулан, биет загвар (макет)-ыг бүтээж 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдөр танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав. | • “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 166 | | II. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов.<br><br>2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнг хэлэлцэн дэмжээд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, хууль, тогтоолд заасны дагуу эрх шилжүүлэн зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгав. | Засгийн газрын тогтоолын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргад 44 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжүүлсэн ба нийслэлд шилжүүлсэн 1 төсөл, арга хэмжээнээс бусад 43 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа хуулийн хугацаанд зохион байгуулагдаж дууссан. Гэрээ байгуулсанаас 24 төсөл, арга хэмжээ бүрэн дууссан ба 14 төсөл, арга хэмжээ 2022 онд дамжин санхүүжих, 5 төсөл, арга хэмжээ дуусах шатанд байна. | 100% |
| 94 | 167 | 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр 22 дугаар тэмдэглэл 2021-04-07 Дугаар 2021_22 | IX.7.1. “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамжийн төсөл, арга хэмжээ”-ний талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан: 1. “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамжийн төсөл, арга хэмжээ”-г эх үүсвэр, холбогдох тооцоо, судалгааны хамт цогцоор нь судалж, төлөвлөн, боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт даалгав. | ”Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг иж бүрнээр боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 161 дүгээр тогтоолоор батлуулсан. | 100% |
| | 168 | | IX.7.2. Хүн амын төвлөрлийг бууруулах асуудлын хүрээнд орон нутагт шилжин ажиллах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын сонирхлыг дэмжсэн бодлогын шинж чанартай хөнгөлөлт, дэмжлэгийн асуудлыг судалж, танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт даалгав. | •“Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 95 | 169 | 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2021-04-21 Дугаар 2021_25 | XY.2. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар тус бүрийн арга хэмжээний хэрэгжилтийн явцыг Сангийн яамны “нэгдсэн мэдээллийг хянах цахим самбар”-т мэдээлж, танилцуулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Тус төлөвлөгөөнд барилга, хот байгуулалтын салбарын чиглэлээр 9 төсөл,арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн мэдээг 7 хоног бүр гаргаж, СЯ-нд хүргүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 96 | 170 | 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр 27 дугаар тэмдэглэл 2021-04-28 Дугаар 2021_27 | XI.5.4. Томоохон зах, логистикийн төвийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт даалгав. | “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулах ажлыг БХБЯ болон НЗДТГ хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд зөвлөх “Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 21 чиглэлээр судалгаа, үнэлгээний ажил болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дуусган, ИД- 2025/2021 тоот экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулан, БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2021.12.10-ны өдрийн хурлаар, БХБ-ын сайдын зөвлөлийн 2021.12.15-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлээд байна.<br>Төлөвлөлтийн хүрээнд Улаанбаатар хот доторх болон хот орчмын ачааны төвлөрсөн терминалууд буюу Нийслэлийн логистикийн төвүүдийг 3 бүсийн хэмжээнд байгуулахаар төлөвлөсөн. Үүнд:<br>1. Улаанбаатар хот доторх логистикийн бүс;<br>2. Хот ормын нутаг дэвсгэрийн логистикийн бүс;<br>3.Улаанбатаарын бүсийн логистик гэж тус тус төлөвлөж байна.<br>Байршлын хувьд Улаанбаатар хотод хотын хүнс бараа, бүтээгдэхүүний хэрэгцээг хангах нийт 46 865 га бүхий 9 ширхэг дамжуулан түгээх төвүүдийг төлөвлөж тусгасан, Улаанбаатар хот орчмын логистикийн төвүүдийг дагуул хотууд болон Шинэ Зуунмод, Майдар хотуудыг хамруулан төлөвлөсөн, Улаанбаатар бүсийн логистикийн төвүүдийг хотын баруун талд: Аргалант-Эмээлт, баруун урд талд: Шинэ Зуунмод, зүүн талд: Налайх, Багануур, Багахангайд 471 444 га газарт төлөвлөж байгаа болно.<br>"Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай" УИХ-ын тогтоолын төслийг боловсруулаад байна. | 100% |
| 97 | 171 | 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдөр 28 дугаар тэмдэглэл 2021-05-05 Дугаар 2021_28 | XXIII.2.2. Нийслэлийн Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барих асуудлын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Эмнэлгийн төлөвлөлтийг олон улсын жишигт нийцүүлэн цогцоор нь иж бүрэн төлөвлөх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт; | Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/426 дугаар захирамжаар Баянзүрх дүүргийн 24-р хороонд шинээр 300 ортой олон улсын жишиг бүхий эмнэлэг барих 7000м2 газрын асуудал шийдвэрлэгдсэн байна.<br>Барилгын зураг төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж "Татах хүч" ХХК шалгарч гэрээ байгуулсан.<br>БХБ-ын яамнаас 2021 онд төлөвлөсөн холбогдох арга хэмжээг авч ажилласан. | 100% |
| 98 | 172 | 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр 31 дүгээр тэмдэглэл 2021-05-19 Дугаар 2021_31 | XYII.3. Нийслэл Улаанбаатар хотын хот байгуулалтын талаар (орон сууц, цэвэрлэх байгууламж, усан хангамж, дагуул хот) Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1. Орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ипотекийн зээлийн урьдчилгаа 30 хувийг үе шаттай бууруулах, орон нутагт илүү хөнгөлөлттэй байх боломжийг судалж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав; | Сангийн яам болон Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллаж, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах замаар урьдчилгаа төлбөрийн хэмжээг бууруулж, хувилбарт ипотекийн зээлийн бүтээгдэхүүнийг гаргаж, тэнцвэртэй хөгжлийн зорилтыг хангах боломжийг бүрдүүлэв. Цаашид Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулж, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн хэмжээг харилцан адилгүй тогтоох бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. | 100% |
| | 173 | | XYII.3.2. Үндэсний орон сууцны корпораци байгуулах тухай асуудлыг судалж, санал боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт даалгав. | “Үндэсний Орон сууцны корпораци” ТӨХХК-ийн бүтэц, орон тоо, дүрмийн төслийг боловсруулж Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Үүнтэй холбогдуулан “Нийслэлийн Орон сууцны корпораци” ХК-ийн ТУЗ-өөс Компанийн тухай хуулийн дагуу “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-тай нэгдэх асуудлыг НИТХ-ын 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар хэлэлцэж, нэгтгэх асуудал дэмжигдээгүй тул “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 2022-2026 оны стратеги бүтцийн өөрчлөлтийг хийж, "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор баталсанаар Үндэсний орон сууцны корпорацийн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Мөн "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК ийн чиг үүрэг нэмэгдэж байгаатай холбогдуулан БХБЯ-аас Дэлхийн банкны зөвлөх үйлчилгээгээр чадавх бэхжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 99 | 174 | 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 32 дугаар тэмдэглэл 2021-05-27 Дугаар 2021_32 | XY.5.3 . Гадаад, дотоод зах зээл дээрх барилгын материалын үнийн хэтийн төлвийн судалгаа хийх, орон сууцны эрэлт, нийлүүлэлтийг хангах, иргэдийг орон сууцжуулах асуудлаар бодлого болон тусгайлсан хууль боловсруулах асуудлаар санал боловсруулж, танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав. | - Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 210 дугаар тушаалаар барилга байгууламжийн 2021 оны үнийн индекс болон түүний хэрэглэх хүрээ, авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Барилга байгууламжийн үнийн индексийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар дахин тооцож, холбогдох судалгааны хамт Сангийн яаманд 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 1/3865 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-нд Монголбанк, Засгийн газар хамтран 2013 оны 6 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн "Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр"-ийг тогтвортой хэрэгжүүлэх хүрээнд төр, хувийн хэвшлийн зохистой түншлэлийн хүрээнд орон сууцжуулах, ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийн эх үүсвэрийг тогтвортой үргэлжлүүлэх арга хэмжээний талаарх танилцуулгыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.<br>2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар арилжааны банкуудад нийт 2.1 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн хүсэлт ирснээс 964.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 12,709 зээлдэгчид олгоод байна. Үүнээс 81.9 хувь буюу 789.4 тэрбум төгрөгийн 9,550 зээлийг Улаанбаатар хотод олгосон бол 18.1 хувь буюу 174.6 тэрбум төгрөгийн 3,159 зээлийг орон нутагт олгосон байна.<br>- МУЗГ-ын 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар байгуулагдсан "Иргэдийн орон сууцжуулалтыг нэмэгдүүлэх, хуримтлалтын нэгдсэн сан, үндэсний баялгийн сан бүрдүүлэх, дундаж давхаргыг тэлэх" үндэсний хороонo Иргэдийг орон сууцжуулах тухай хуулийн үзэл баримтлалын төслийг урьдчилсан байдлааар боловсруулсан. | 100% |
| 100 | 175 | 2021 оны 6 дугаар сарын 1-ний өдөр 33 дугаар тэмдэглэл 2021-06-01 Дугаар 2021_33 | YI.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>YI.2. "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1. Төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Төлөвлөгөөнд барилга, хот байгуулалтын салбарын чиглэлээр 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн мэдээг 7 хоног бүр гаргаж, СЯ-нд хүргүүлэн ажиллаж байна. | 100% |
| | 176 | 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2021-06-23 Дугаар 2021_36 | XII.2. "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1. Шаардлагатай тохиолдолд цар тахлын үед эдийн засгийг сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үеийн эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хуулийн төсөлд тусгах саналыг боловсруулж, 2021.10.05-ны өдрийн 1/3891 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>"ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ШИНЭ СЭРГЭЛТ"-ийн бодлогод тусгах, салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг ЗГХЭГ-т 2021.10.29-ний өдрийн 1/4270 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн Ерөнхий сайдын 160 дугаар захирамжаар байгуулагдсан дэд ажлын хэсэгт 2021.11.01-ний өдөр цахим шуудангаар хүргүүлсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 101 | 177 | | XII.4. Нийслэлийн Баянгол дүүргийн 16 дугаар хороо, “Гандантэгчэнлин хийд” орчмыг соёл, аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1. “Гандантэгчэнлин хийд” орчмыг соёл, аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх саналыг дэмжиж, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Соёлын сайд Ч.Номин, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт; | - "Гандантэгчилэн хийд" орчмыг соёл, аялал жуучлалын бүс болгон хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулах, инженерийн дэд бүтцийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох асуудлыг судалж төлөвлөх ажлыг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг БХБ-ын сайдын 2021.08.17-ны өдрийн 175 дугаар тушаалаар байгуулсан.<br>Ажлын хэсгээс дараах дүгнэлтийг гаргасан Үүнд:<br>1. “Гандантэгчэнлин хийд” орчмыг цаашид аялал жуулчлалын цогц цогцолбор болгон хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байгаа техник эдийн засгийн үндэслэл боловсруулах 160.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх;<br>2. “Гандантэгчэнлин хийд” орчмын бүтээн байгуулалтын ажлыг уялдуулах, иргэд олон нийттэй харилцаж хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор ашиглалтын өмнөх захиргааны бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх;<br>3. “Гандантэгчэнлин хийд” орчмын барилга байгууламжийг Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу ЮНЕСКО-д бүртгүүлэх асуудлыг дээд шатны байгууллагад уламжлах.<br>Мөн "Улаанбаатар хотын төлөвлөлтийн төвийн бүсийн 30-р нэгж хороолол “Гандантэгчэнлин хийд” орчмыг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгавар"-ын төслийг боловсруулаад байна.<br>"Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөө"-ний төсөлд “Гандантэгчэнлин хийд” орчмыг Улаанбаатар хотын Төвийн бүсэд хамруулж хотын түүхэн хэсэг, засаг захиргаа, аялал жуулалчлал, Улаанбаатар хотын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын нэг болгож хамгаалалтын болон хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлах бүс болгон тусгаж байгаа болно. | 70% |
| | 178 | | XII.4.2. Инженерийн дэд бүтцийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох асуудлыг судалж танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх нарт; | БХБ-ын сайдын 2021.08.17-ны өдрийн 175 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгээс Гандан хийд орчмын гэр хороолол, олон нийтийн барилгуудыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох асуудлыг газар дээр нь холбогдох инженерийн шугам сүлжээний хангагч байгууллагуудын төлөөллийг байлцуулан 2021.09.30-ны өдөр танилцаж, урьд нь хийгдсэн шугам сүлжээ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслүүдийг судалж НЗДТГ-т 2021.11.15-нд танилцуулсан. Уг арга хэмжээг Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар, НХОГ чиг үүргийн дагуу хариуцана. | 100% |
| | 179 | | XII.4.4. Бүтээн байгуулалтын дээрх арга хэмжээг хариуцан хэрэгжүүлж, хяналт тавих асуудлыг судалж, саналаа танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Соёлын сайд Ч.Номин, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт; | - "Гандантэгчилэн хийд" орчмыг соёл, аялал жуучлалын бүс болгон хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулах, инженерийн дэд бүтцийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох асуудлыг судалж төлөвлөх ажлыг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг БХБ-ын сайдын 2021.08.17-ны өдрийн 175 дугаар тушаалаар байгуулсан.<br>Ажлын хэсгээс дараах дүгнэлтийг гаргасан Үүнд:<br>1. “Гандантэгчэнлин хийд” орчмыг цаашид аялал жуулчлалын цогц цогцолбор болгон хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байгаа техник эдийн засгийн үндэслэл боловсруулах 160.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх;<br>2. “Гандантэгчэнлин хийд” орчмын бүтээн байгуулалтын ажлыг уялдуулах, иргэд олон нийттэй харилцаж хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор ашиглалтын өмнөх захиргааны бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх;<br>3. “Гандантэгчэнлин хийд” орчмын барилга байгууламжийг Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу ЮНЕСКО-д бүртгүүлэх асуудлыг дээд шатны байгууллагад уламжлах.<br>Мөн "Улаанбаатар хотын төлөвлөлтийн төвийн бүсийн 30-р нэгж хороолол “Гандантэгчэнлин хийд” орчмыг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгавар"-ын төслийг боловсруулаад байна.<br>"Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөө"-ний төсөлд “Гандантэгчэнлин хийд” орчмыг Улаанбаатар хотын Төвийн бүсэд хамруулж хотын түүхэн хэсэг, засаг захиргаа, аялал жуулалчлал, Улаанбаатар хотын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын нэг болгож хамгаалалтын болон хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлах бүс болгон тусгаж байгаа болно. | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 102 | 180 | 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр 38 дугаар тэмдэглэл 2021-06-30 Дугаар 2021_38 | XYIII.3.4. Нийслэл Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрлийг бууруулах зорилгоор Төв аймгийн Хөшигийн хөндий дэх шинэ хотуудын эхний ээлжийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд иргэдийг орон сууцжуулах төсөл хэрэгжүүлэх талаар санал боловсруулж танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт; | “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хотын болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Иргэний нисэхийн ерөнхий газрын 600 айлын орон сууц барих хүсэлтийн дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд уялдуулж газрын асуудлыг шийдвэрлэсэн.<br>Нийслэл Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрлийг бууруулах, хот, орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах хүрээнд иргэдийг орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх, санхүүгийн хөшүүргийг бий болгох зорилгоор Сангийн яам болон Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллаж, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах замаар урьдчилгаа төлбөрийн хэмжээг бууруулж, хувилбарт ипотекийн зээлийн бүтээгдэхүүнийг гаргаж, тэнцвэртэй хөгжлийн зорилтыг хангах боломжийг бүрдүүлэв. Цаашид Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулж, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн хэмжээг харилцан адилгүй тогтоох бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| | 181 | | XYIII.3.5. Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 111 дүгээр захирамжаар байгуулсан Төв аймгийн Хөшигийн хөндийн шинэ дагуул хотуудын нэгдсэн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, эрхэлсэн салбарын бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрүүдийг уялдуулан тусгуулах, шаардлагатай судалгаа, мэдээллээр хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | •“Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| | 182 | | XYIII.3.6. Төв аймгийн Хөшигийн хөндий дэх шинэ хотуудыг бүсийн хөгжлийн төслийн дагуу эрчимтэй хөгжүүлэх, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх болон эдийн засаг, нийгэм, бизнесийн таатай орчныг бий болгох, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах зэрэг тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор тусгай хууль батлан хэрэгжүүлэх асуудлыг судалж, саналаа боловсруулан Засгийн газарт оруулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт. | •“Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг шинээр байгуулах тухай УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоол гарсан.<br>• “Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг Төв аймгийн Зуунмод хот болон Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тус бүс нутгийн хувьд нэгдсэн байршилтай, хоорондын зохистой үйлчлэх хүрээ нь 10-20 хүртэл км бүхий “Шинэ Зуунмод”, “Зуунмод”, “Майдар”, Сэргэлэн сумын төв гэсэн суурьшлын 4 төвийг байгуулна. “Богд хан” төмөр зам, босоо тэнхлэгийн олон улсын АН3 авто зам, эдийн засгийн чөлөөт бүс, гадаад, дотоодын хуурай зам, агаарын болон төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бүхий логистикийн болон худалдаа, үйлдвэрлэлийн төв зэрэг тухайн нутаг дэвсгэрт байгуулагдах олон улсын түвшний мега төслүүдтэй цогц байдлаар уялдуулан хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлттэйгээр хөгжүүлж, Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд 2040 он гэхэд Зүүн хойд Азийн зам тээврийн (агаарын, төмөр зам, авто замын) томоохон зангилаа төв бүхий 150 мянга хүртэл хүн амтай эдийн засгийн өндөр өсөлттэй бүс нутаг, түүнийг даган бий болсон аэротрополис хот бий болгох нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулж байна.<br>Тайланг файлаар хавсаргав.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 103 | 183 | 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2021-07-07 Дугаар 2021_41 | XXYII.4. “Залуус 1” орон сууцны хорооллын төслийн бүтээн байгуулалтын ажлын явц, шаардлагатай хөрөнгө оруулалтын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан: 1. “Залуус 1” орон сууцны хорооллын инженерийн дэд бүтэц, нийгмийн барилга байгууламж, авто замын бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг улсын төсвийн төсөлд үе шаттайгаар тусгах санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт даалгав. | Тус төслийн инженерийн дэд бүтцийн ажилд шаардагдах нийт 29.9 тэрбум төгрөгийн саналыг Сангийн яаманд хүргүүлж, 2022 онд 9.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэхээр тусгасан байна. | 100% |
| | 184 | | XXYII.4.2. “Залуус 1” орон сууцны хорооллын бүтээн байгуулалтыг Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилт, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжийг судалж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт даалгав. | “Залуус 1” орон сууцны хорооллын бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг хөрөнгө оруулалтын үр ашигтай харьцуулсан судалгааг боловсруулж, түүний үндсэн дээр боломжит төр-хувийн хэвшлийн түншлэлийн схемийг гаргаж, ЗГХЭГ, Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банк зэрэг холбогдох байгууллагуудад танилцуулсан.<br>Монгол Улсын 2022 оны төсөв батлагдсантай холбогдуулан төслийн хүрээнд улсын төсөвт туссан 9.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулсан. | 100% |
| 104 | 185 | 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2021-08-25 Дугаар 2021_48 | XYI.5. Улсын Их Хурлын 2021 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал болон Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын тогтоолд заасан хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, 2021 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Газрын багц хуулийн төслийг өргөн мэдүүлэх зөвшөөрөл авахаар Хууль зүй, дотоор хэргийн сайд, Сангийн сайдад 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1/5096 тоот бичгээр хүргүүлсэн. Үүнд:<br>1. Газрын ерөнхий хуулийн төсөл;<br>2. Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн төсөл;<br>3. Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>4. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>5. Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх хуулийн төсөл тус тус байна.<br>Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулсан. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл болон холбогдох материалыг боловсруулсан, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл хүлээж байна.<br>БХБ-ын яамнаас холбогдох арга хэмжээг авч ажилласан. | 100% |
| 105 | 186 | 2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр 50 дугаар тэмдэглэл 2021-09-08 Дугаар 2021_50 | XI.3. Нийслэл Улаанбаатар хотын дэд төвүүдэд хөрөнгө оруулж, бүтээн байгуулалт хийх сонирхолтой хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн уулзалтын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1. Нийслэлд шинээр байгуулах дэд төвүүд байгуулах ажлыг гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл болон сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга, байгууламжийн барилгын ажилтай нэгдсэн цогц байдлаар төлөвлөн хэрэгжүүлэх, холбогдох санхүүжилтийг улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хүрээнд шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; | “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулах ажлыг БХБЯ болон НЗДТГ хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд зөвлөх “Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 21 чиглэлээр судалгаа, үнэлгээний ажил болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дуусган, ИД- 2025/2021 тоот экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулан, БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2021.12.10-ны өдрийн хурлаар, БХБ-ын сайдын зөвлөлийн 2021.12.15-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлээд байна.<br>Тус баримт бичигт Улаанбаатар хотын хүн ам, барилгажилтын хэт төвлөрлийг задалж соёл боловсрол, банк, санхүү, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий “Яармаг” шинэ хотын төв, “Баянхошуу”, “Сэлбэ”, “Шинэ төв”, “Сонсголон”, “Амгалан” дэд төв болон гэр хорооллын бүсэд 26 олон нийтийн дэд төвийг шинээр байгуулахаар тусгасан. Дэд төвүүдэд тус бүр 850 хүний суудалтай 7 соёлын ордон, 33000 м2 талбай бүхий 6 музей, 3200 ортой 10 эрүүл мэндийн байгууллага байхаар төлөвлөсөн.одоогийн байдлаар 57.9% хангамжтай байгаа цэцэрлэг, 84.4% хангамжтай байгаа сургуулийг 2040 он гэхэд бүрэн хангамжтай болгож 451 байршилд цэцэрлэг, 126 байршилд сургуулийг шинээр төлөвлөсөн.<br><br>Хавсралт : 2 файл | 70% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 106 | 187 | 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл 2021-09-15 Дугаар 2021_51 | IX.4.11. Хилийн Гашуунсухайт боомтыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулж, газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналын хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт даалгав. | Засгийн газрын 2020 оны 92 дугаар “Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын чигийг батлах тухай” тогтоолоор батлагдсан 207-000 дахь километрээс Монгол улсын урд хил болох төгсгөлийн цэг 30+895 километр хүртэлх төмөр замын зурвас газрыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж, тухайн зурвас газарт иргэн, хуулийн этгээдэд шинээр газар олгох боломжгүй байдлаар мэдээллийн санд хаалт хийсэн. | 100% |
| | 188 | | X.2.2. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын албаны мэдээллийн сан болон төрийн тусгай хэрэгцээнд авсан газрын талаарх мэдээллийг “Орон зайн мэдээллийн сан”-д оруулах, мэдээллийг нийтэд нээлттэй болгох ажлыг эрчимжүүлж, ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуучлалын сайд Н.Уртнасан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ нарт даалгав. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын албаны мэдээллийн сан болон төрийн тусгай хэрэгцээнд авсан газрын талаарх мэдээллийг “Орон зайн мэдээллийн сан”-д оруулах, мэдээллийг нийтэд нээлттэй болгох ажлыг эрчимжүүлж, ажлын явц, үр дүнгийн талаар болон “Авилгын төсөөллийг индексийг бууруулах” чиглэлээр газрын харилцааны салбарт хийсэн цахим шилжилтийн ажлын үр дүнгийн талаар Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцуулав. | 100% |
| | 189 | | X.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл болон санхүүжилтийн төрийн сан дахь гүйлгээний явц байдлын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл болон санхүүжилтийн төрийн сан дахь гүйлгээний явц байдлын талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулсантай холбогдуулан тус яамтай холбоотой 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн талаарх мэдээллийг нотлох баримтын хамт яамны 2021.09.28-ны өдрийн 1/3813 тоот албан бичгээр Сангийн яаманд, хувийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | 100% |
| 107 | 190 | 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 52 дугаар тэмдэглэл 2021-09-22 Дугаар 2021_52 | IX.7. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн барилга угсралтын ажлын явцын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн барилга угсралтын ажлыг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, шинэ төв цэвэрлэх байгууламжийн цахилгаан хангамжийн тэжээлийн “Цэвэрлэх” дэд станцыг барих санхүүжилтийн асуудлыг судалж, шийдвэрлэх арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд, бохир усны Туул-1 коллекторыг 2022-2023 онд багтаан байнгын ашиглалтад оруулахаар тооцож ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт тус тус даалгав. | “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн барилга байгууламжийн зураг төслийг Шанхай хотын зураг төслийн хүрээлэн боловсруулсан. Нийт 38 объектийн зураг төсөл хийгдэхээс 11 барилга нь магадлалаар хянагдсан. Бусад нь хянагдаж байна. 98%-ийн гүйцэтгэлтэй.<br>Цахилгааны 35/10кВ-ын дэд станц, ЦДАШ, дулаан хангамж, цэвэр, бохир усны шугамын зураг төслийг боловсруулж, батлуулсан. БУА: 25%-ийн гүйцэтгэлтэй. Элс баригч, 1-р 2-р тунгаагуур, хойд биореактор, захиргааны барилга, лаг өтгөрүүлэгч, лаг өтгөрүүлэгч, метантенк зэрэг 12 барилгын БУА хийгдэж байна.<br>Тоног төхөөрөмж татан авалт: Нийт 17 гэрээг үйлдвэрлэгч нартай байгуулсан.<br>Ажиллах хүчин: 2021.06.19-ний өдөр 35 ИТА-г оруулж ирсэн. Дотоодын туслан гүйцэтгэгч 13 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажиллуулсан. Сургалтууд зохиогдсон. КОВИД –ын үед ажиллах түр журам, төлөвлөгөөг батлуулж, ажилласан. Цар тахлаас шалтгаалан Хятадын талын ажиллах хүчин, зарим бараа материал орж ирээгүй.<br>Төслийн хэрэгжилт 2020 онд 15% байсан бол 2021 онд 35%-д хүрсэн нь төслийн нэгжийн төлөвлөлт, менежментээс шалтгаалсан гэж дүгнэж байна. Мөн туслан гүйцэтгэгчдийг дотоодоосоо /Монгол Улс/ авч ажиллуулсан нь төслийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлсэн. | 100% |
| | 191 | 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55 | II. Энэ тогтоолоор хүчингүй болсонд тооцсон болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан дараах бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр, салбарын бусад баримт бичигт уялдуулан тусгах замаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээг 2022 оны 3 дугаар сард багтаан авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов. | ЗГ-ын 2021 оны 314 дүгээр тогтоолоор тус салбарт мөрдөгдөж байсан Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан "Түрээсийн орон сууц" хөтөлбөр болон Засгийн газрын 2020 оны 94 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого" тус тус хүчингүй болсон.<br>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан дунд хугацааны зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах хүрээнд салбарын нөхцөл, байдлын шинжилгээг холбогдох аргачлалын дагуу хийж, яамны 2021.10.25-ны 1/4207 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>БХБ-ын сайдын 2021 оны 236 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгээс хүчингүй болсон бодлогын баримт бичгүүдэд туссан арга хэмжээг хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусгах чиглэл баримтлан ажиллаж байна. | Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 108 | 192 | | ХҮ.9.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах асуудлыг ирэх оны төсөв батлагдсан даруйд шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зарлаж 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулж дууссан байхаар тооцож, бэлтгэл хангахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгав; | БХБСайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 267 дугаар тушаал гарч аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн, Мөн Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны төлөвлөгөө 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр батлагдан 2021.12 сарын 14-ний өдөр tender.gov.mn системд нийтэлж, цахимаар эрх шилжүүлж тендер зарлах нөхцлийг бүрдүүлсэн байна.<br>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдах 20 төсөл, арга хэмжээнээс бэлэн зураг төсөвтэй 6 ажлын зураг төсвийг хүргүүлж тендер зарлах бэлтгэл хангаж байна. Мөн яаманд зохион байгуулагдах 22 ажлын үнэлгээний хороо байгуулах, зураг төсөв, ажлын даалгавар, бэлтгэх ажил хийгдэж байна. | 100% |
| | 193 | | ХҮ.10. Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгт олгосон газрыг баталгаажуулах чиглэлээр хийгдсэн ажлын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн хэрэгцээнд ашиглаж байгаа, тус нийгэмлэгийн барилга, байгууламж бүхий нийслэлийн нутаг дэвсгэр дэх 49 нэгж талбарын гэрчилгээг 2021 оны 10 дугаар сард багтаан олгох арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар нарт даалгав. | Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгээс нийт газар ашиглах эрх баталгаажуулах тухай 55 нэгж талбарын хүсэлт ирүүлсэн болно.<br>Үүнээс 46 нэгж талбарын асуудлыг шийдвэрлэн гэрээ байгуулж, гэрчилгээ олгогдсон болно. Үлдсэн 9 нэгж талбарын 3 нь төмөр замын зурвас газар, 4 нэгж талбар нь талбайн хэмжээ зөрүүтэй тул ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр болсон. 2 нэгж талбар нь бусдын эзэмшилд олгогдсон нэгж талбар байсан тул шийдвэрлэх боломжгүй байна. | 100% |
| | 194 | | ХҮ.13.6. "Худалдан авах ажиллагааны цахим систем"-д худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагын удирдлагад; | 2021 оны худалдан авах авах ажиллагааны үр дүнг тухай бүр нийтэлж ажилласан. 2022 оны худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаар үр дүн, гэрээний биелэлтийг үр дүн гарсан тухай бүр байршуулж ажиллахаар бэлтгэл ханган ажиллаж байна. | 100% |
| | 195 | | ХҮ.13.3. Байгалийн хий нийлүүлэх хоолой, түүнийг дагалдах барилга байгууламжууд баригдах газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын тусгай хэрэгцээнд авах талаар шийдвэрийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Хаянхярваа нарт; | ОХУ-аас Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин БНХАУ руу татах хийн хоолойн чиг, хамгаалалтын зурвасыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлын хүрээнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу Засгийн газрын тогтоолын төсөл, тогтоолын хавсралт солбицол, зураг, тусгай хэрэгцээнд авах ажлын дарааллыг боловсруулж төслийн нэгжид хүлээлгэж өгсөн. | 70% |
| | 196 | | ХҮ.13.4. Төслийн барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг Тусгай зориулалтын "Газопровод Союз Восток" ХХК-д олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт. | Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 244 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар "Газопровод союз восток" ХХК-д төслийн барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгосон. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 109 | 197 | 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2021-11-03 Дугаар 2021_58 | XII.6. Газар хөдлөлтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох сайд, дарга нарт даалгав:<br>1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 17/12 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2018 оны н/206 дугаар тогтоолын хавсралтад заасан газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгыг тэргүүн ээлжид буулгах, шинээр барих ажлыг судлан танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | -Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинэчлэн боловсруулахаар аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авч журмын төслийг боловсруулан, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн хурлаар төслийг хэлэлцүүлж, Шадар сайдын 2021 оны 2 дугаар тушаалаар Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинэчлэн баталсан. -Монгол Улсын 2021 оны төсөвт паспортжуулалтын ажлын 70 сая төгрөг тусгагдсаны дагуу нийслэлийн хэмжээнд нийт 89 барилга байгууламжийн суурь судалгаа, байгууламжид биет үзлэгийн судалгааг үе шаттайгаар хийж паспортжуулаад байна.<br>-Нийслэлд 2021 оны байдлаар орон сууцны 617, төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт олон нийтийн 163, нийт-780 барилгад буюу 42.5 хувьд нь хэмжилт, судалгаа хийж, дүгнэлт гаргаж, паспортжуулсан. Барилга байгууламжид хэмжилт, судалгаа хийх, паспортжуулах ажил болон багаж, тоног төхөөрөмжөөр хангах ажилд нийт 2.3 тэрбум төгрөг зарцуулсан. Уг тулгамдаад буй асуудлыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Барилга байгууламжийг паспортжуулах ажилд шаардлагатай санхүүжилтийг 2021 оны Улсын төсөвт тусгах саналаа 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2671 тоот албан бичиг, 2022 оны Улсын төсөвт тусгах саналаа 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 тоот албан бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй. 2022 оны Нийслэлийн төсөвт барилга байгууламжийг паспортжуулах ажилд 560 сая төгрөг туссан байна. | 70% |
| | 198 | | XII.6. 2002 оноос өмнө баригдсан нийтийн зориулалттай барилга байгууламжийг паспортжуулах, гэрчилгээжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга) нарт; | - Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинэчлэн боловсруулахаар аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авч журмын төслийг боловсруулан 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт цахимаар хүргүүлсэн. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн хурлаар төслийг хэлэлцэж, Шадар сайдын 2021 оны 2 дугаар тушаалаар "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг шинэчлэн баталсан.<br>- Монгол Улсын 2021 оны төсөвт паспортжуулалтын ажлын 70 сая төгрөг тусгагдсаны дагуу нийслэлийн хэмжээнд нийт 89 барилга байгууламжийн суурь судалгаа, байгууламжид биет үзлэгийн судалгааг үе шаттайгаар хийж паспортжуулаад байна.<br>- Нийслэлд 2011-2021 онд олон нийтийн зориулалттай 1844 барилгаас 725 барилгад буюу 39.3 хувьд нь хэмжилт, судалгаа хийж, дүгнэлт гаргаж, паспортжуулсан. Барилга байгууламжид хэмжилт, судалгаа хийх, паспортжуулах ажил болон багаж, тоног төхөөрөмжөөр хангах ажилд нийт 2.3 тэрбум төгрөг зарцуулсан. Дээрх 725 барилгаас газар хөдлөлтөд тэсвэртэй 186, хүчитгэх шаардлагатай 120, газар хөдлөлтөд тэсвэргүй 439 барилга байна.<br>- 2022 оны Нийслэлийн төсөвт паспортжуулахаар ажлаар 560 сая төгрөг тусгагдсаны дагуу 116 барилга байгууламжид паспортжуулалт хийхээр ажиллаж байна. | 100% |
| | 199 | | XII.6. Барилгын норм, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, үндсэн хийц, бүтээцийн бэхэлгээ, хүчитгэлийн техникийн шийдэл, дотоод зарлан мэдээллийн системийн техникийн ерөнхий шаардлага, стандартыг боловсруулж батлуулах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт; | “Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай хамтран Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төслийг хэрэгжүүлсэн бөгөөд уг төслийн хүрээнд барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр дараах дүрэм журмыг боловсруулж Барилга, хот байгуулалтын сайд болон Соёлын сайдаар хамтарсан тушаалаар батлуулах тухай 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 1/5105 тоот албан бичгийг Соёлын сайдад хүргүүлсэн. Үүнд:<br>- Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журам;<br>- Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ;<br>- Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар, үйл ажиллагааны журам.<br>“Барилга, байгууламжийн хийц бүтээц, даацын чанар бат бэх, тогтворын байдал, найдвартай үйл ажиллагаанд үнэлгээ өгч паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах ажлын жишиг үнэ”-ийг шинэчлэн боловсруулж, Барилгын бүтээцийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Яамны дэргэдэх ШУТТЗ-ын 2021.12.25-ны хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. | 100% |
| | 200 | | XII.6.8. Дээр дурдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, улс, орон нутгийн жил бүрийн төсвийн төсөлд тусгах, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Монгол Улсын 2021 оны төсөвт паспортжуулалтын ажлын 70 сая төгрөг тусгагдсаны дагуу нийслэлийн хэмжээнд нийт 89 барилга байгууламжийн суурь судалгаа, байгууламжид биет үзлэгийн судалгааг үе шаттайгаар хийсэн.<br>Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, ашиглагдаж байгаа барилга байгууламжийг паспортжуулах үйл ажиллагааны шаардлагатай байгаа санхүүжилтийн асуудлыг 2022 оны Улсын төсөвт тусгуулах саналаа Сангийн яаманд хүргүүлсэн. Түүнчлэн Нийслэлийн хэмжээнд 117 барилга байгууламжийг паспортжуулах 560 сая төгрөгийг тусгасан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 110 | 201 | 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 59 дүгээр тэмдэглэл 2021-11-10 Дугаар 2021_59 | XIII.4.4. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн ашиглаж буй нийслэлийн нутаг дэвсгэр дэх төмөр замын зурвас газар, барилга байгууламжийн доорх газрын асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэж дуусгахыг Барилга, хот байгуулалтын дэд сайд, уг асуудлаарх Ажлын хэсгийн дарга Э.Золбоо, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгээс нийт газар ашиглах эрх баталгаажуулах тухай 55 нэгж талбарын хүсэлт ирүүлсэн болно.<br>Үүнээс 46 нэгж талбарын асуудлыг шийдвэрлэн гэрээ байгуулж, гэрчилгээ олгогдсон болно. Үлдсэн 9 нэгж талбарын 3 нь төмөр замын зурвас газар, 4 нэгж талбар нь талбайн хэмжээ зөрүүтэй тул ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр болсон. 2 нэгж талбар нь бусдын эзэмшилд олгогдсон нэгж талбар байсан тул шийдвэрлэх боломжгүй байна. | 100% |
| | 202 | | XIII.5. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн явцын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>1. Үүнтэй холбогдуулан уг төслийн талаар дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд нарт даалгав:<br>1.1. Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн хэрэгжилтийг улам эрчимжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт;<br>1.2. Байгалийн хий нийлүүлэх магистраль шугамнаас Монгол Улс өөрийн дотоодын хийн хэргэлгээгээ авах эсэх асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх нарт;<br>1.3. Уг төслийг хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ авах асуудлыг судлахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт. | ОХУ-аас Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин БНХАУ руу татах хийн хоолойн чиг, хамгаалалтын зурвасыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлын хүрээнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу Засгийн газрын тогтоолын төсөл, тогтоолын хавсралт солбицол, зураг, тусгай хэрэгцээнд авах ажлын дараалллыг боловсруулж төслийн нэгжид хүлээлгэж өгсөн. | 70% |
| 111 | 203 | 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 60 дугаар тэмдэглэл 2021-11-17 Дугаар 2021_60 | XIII.5.1. Барилгын гол нэр төрлийн материал болох хар төмөрлөг, цементийн үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг эрчим хүчний хөнгөлөлтөд хамруулах боломжийг судлан, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Сангийн сайд Б.Жавхлан нарт; | Цементийн үйлдвэрүүдийг хөнгөлөлтөд хамруулах санал боловсруулан Эрчим хүчний сайдад 2021 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 1/829 тоот албан бичгээр хүргүүлсний дагуу ЭХЯ уг асуудлаар ЗГ-ын тогтоолын төслийг бэлтгэн бусад яамдаас санал авч ЗГ-т хүргүүлсэн боловч шийдэгдээгүй.<br>Иймээс 2022 онд цемент, арматурын үйлдвэрүүдийг эрчим хүчний хөнгөлөлтөд хамруулахаар Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцүүлэн 60 дугаар хуралдааны тэмдэглэлд “Барилгын гол нэр төрлийн материал болох хар төмөрлөг, цементийн үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг эрчим хүчний хөнгөлөлтөд хамруулах боломжийг судлан, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай гэсэн шийдвэр гаргуулсан. Уг шийдвэрийг үндэслэн тэдгээр үйлдвэрийн цахилгаан, дулааны хэрэглээний мэдээлэл авах тухай хүсэлтийг ЭХЯ, ЭХЗХ-нд 2021 оны 12 дугаар сарын 2-ны 3/4824 тоотоор хүргүүлж, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулаад байна. | 100% |
| 112 | 204 | 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл 2021-12-08 Дугаар 2021_63 | XY.3.1.2. Бусад салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний инфляцид үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд; | Барилгын хийц, бүтээцээс хамааруулан барилга байгууламжийн өртгийг тооцож, жил бүр индексжүүлэх замаар барилга байгууламжийн үнийг шинэчлэн тооцох арга хэмжээний хүрээнд БХБ-ын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр ээлжит хурлаар “Барилга байгууламжийн 2020 оны үнийн индекс”-ийг хэлэлцүүлэн дэмжигдэж, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 93 дугаар тушаалаар батлуулж, ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын 5230 дугаарт бүртгэгдсэнийг БХТ-д хүргүүлсэн.<br>“Барилга байгууламжийн 2021 оны үнийн индекс”-ийг боловсруулах техникийн даалгаврыг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Барилга байгууламжийн 2021 оны хагас жилийн үнийн индексийг боловсруулж, 2021.07.02-ны өдрийн ШУТТЗ-ын хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Барилгын тухай хуулийн 33.1.10-т заасны дагуу Сангийн яамтай зөвшилцөхөөр 2021.07.02-ны 1/2758, 2021.10.01-ний 1/3855 тоот албан бичгийг хүргүүлсэн.<br>Барилга байгууламжийн жил бүрийн үнийн индексийн Сангийн яамтай зөвшилцөн баталдаг ба 2021 оны үнийн индексийг боловсруулан, яамны дэргэдэх ШУТТЗ-ын 2021 оны 12 дугаар сарын 28-ны хурлаар хэлэлцэж дэмжсэн. БХБ-ын яамнаас Сангийн яаманд албан бичиг хүргүүлсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 113 | 205 | 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 64 дүгээр тэмдэглэл 2021-12-14 Дугаар 2021_64 | XIY.5.3. Бүх шатны төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдэд хийх хяналт шалгалтыг хэвээр үргэлжлүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгав. | 1. Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 242 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралтаар баталсан Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийн дүгнэлт гаргах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг Төрийн нарийн бичгийн даргын 2021.10.21-ний өдрийн А/131 дүгээр тушаалаар байгуулагдсан.<br>Ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд ажиллаж, хэсэгчилсэн хяналт, шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, 2021.11.16-ны өдөр БХБСайдын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, 07 тоот тэмдэглэл гарган, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл болон яамны холбогдох газруудад үүрэг чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>2. Барилга, нийтийн аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах зорилго бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2021.11.18-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар байгуулан, ажлын удирдамж, төлөвлөгөөг батлуулан ажилласан.<br>Ажлын хэсэг хяналт шалгалтад хамрагдсан төслүүдийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар мэдээлэл авах зорилгоор төслийн нэгж дээр очиж ажиллан, холбогдох баримт бичигтэй танилцан, Дархан хотын цэвэрлэх байгууламжийн төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, хяналт шалгалтын тайлан бэлтгэж, дүгнэлт зөвлөмж гарган, 2021.12.23-ны өдөр Төслийн удирдах хороогоор хэлэлцүүлсэн.<br>3. Барилга, хот байгуулалтын яамны дотоод аудитын хорооны 2022 оны ажлын төлөвлөгөөг Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцэж баталсан. Тус төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу харьяа газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хийнэ. | 100% |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | |
| 114 | 206 | Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03 | 1.1. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр тооцоонд "Цахим төлбөрийн баримтын систем" /ebarimt/ нэвтрүүлэх ажлыг 2019 онд багтаан иргэдэд чиргэдэл үүсгэлгүйгээр шуурхай зохион байгуулах. | Төсвийн тухай хууль, Татварын тухай хууль, Газрын тухайн хууль, Газрын төлбөрийн тухай хуулиудад өөрчлөлт орсонтой холбогдуулан БХБ-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 173/178 тоот тушаалаар "Мэдээлэл харилцан солилцох тухай журам"-г баталж, Татварын ерөнхий газартай хамтран дундын мэдээллийн сангаар дамжуулан газрын төлбөр, татварын ноогдуулалтыг илгээх, нэхэмжлэх үүсгэх, төлөлт хүлээн авах ажлыг зохион байгуулсан. egazar, ebarimt, e-mongolia-аар дамжуулан газрын төлбөр, татварын мэдээллээ харах, төлөх боломжтой болсон.<br>“Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх /улсын хэмжээнд/”, Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн цахим сан, “Салбарын тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрхийн үйл ажиллагааг цахимд шилжүүлэх” зэрэг ажлын хүрээнд цахим төлбөр тооцоог холбох хөгжүүлэлтийг хийж Монголбанкны Төрийн үйлчилгээний төлбөр тооцооны цахим систем болон КТТ ХХК-ийн “Кю-Пэй” цахим төлбөр тооцооны системд холбогдсон. | 100% |
| | 207 | | 1.2. Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургаж бэлтгэх, төлбөр тооцооны системийн талаар иргэдэд сурталчилан таниулах. | Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам”-ыг боловсруулж, Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын Сайдын хамтарсан тушаалаар баталсан. Мөн газрын төлбөр, татварын ногдуулалтыг "Газрын төлбөр, татварын систем"-ээр ногдуулж, "Татварын удирлагын нэгдсэн систем"-д илгээдэг. Мөн энэхүү системээс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нэхэмжлэл илгээх, нэхэмжлэлийн дагуу төлөгдсөн төлбөр буцаад дээрх системд бүртгэгддэг байхаар системийн хөгжүүлэлтийг хийсэн бөгөөд энэ талаар иргэд олон нийтэд сурталчлан ажилласан. | 100% |
| | 208 | | 1.5. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бол эрхлэх асуудлын хүрээнд болон нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж байгаа эрх зүйн актуудад зохих өөрчлөлт оруулах. | Төсвийн тухай хууль, Татварын тухай хууль, Газрын тухайн хууль, Газрын төлбөрийн тухай хуулиудад өөрчлөлт орсонтой холбогдуулан БХБ-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 173/178 тоот тушаалаар "Мэдээлэл харилцан солилцох тухай журам"-г баталж, газрын төлбөр, татварын ногдуулалтыг "Газрын төлбөр, татварын систем"-ээр дамжуулан ногдуулах боломжийг бүрдүүлсэн. | 100% |
| | 209 | | 3. Албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэж, тайланг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд. | Тус албан даалгаврын хэрэгжилтийг улирал бүр дүгнэж, хагас бүтэн жилээр Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцэн тайланг ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 115 | 210 | Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2 | 1. Дор дурьдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:<br><br>1.1. Салбар болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төслийг хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх; | Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор барилгын салбарын цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайдаар 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр батлуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 3/4103 тоот албан бичгээр хүргүүлсэн. Цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 80.8 хувь.<br>“Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн сан”-ын хөгжүүлэх төслийн хүрээнд дараах үйл ажиллагаа, мэдээллийн сан цахимжуулсан. Үүнд:<br>-Тусгай зөвшөөрлийн систем -100 хувь;<br>-Норм, нормативын мэдээллийн систем 100 хувь;<br>-Сургалт, судалгааны мэдээллийн систем 100 хувь;<br>-Хууль, эрх зүйн модуль 100 хувь;<br>-Лабораторийн бүртгэл 100 хувь;<br>-Нийтийн аж ахуйн систем 100 хувь;<br>-Магадлал, зураг төслийн систем 100 хувийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжсэн байна.<br>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд дараах 5 үйлчилгээ холбогдоод байна. Үүнд:<br>1.Газрын кадастрын нэгж талбарын тодорхойлолт;<br>2.Газар эзэмших эрхийн лавлагаа;<br>3.Үнэгүй газар өмчилсөн эсэх лавлагаа;<br>4.Газрын төлбөрийн тооцоо нийлсэн лавлагаа;<br>5.Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа; | 100% |
| 116 | 211 | Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2 | 1.2. Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлэх; | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд дараах 5 үйлчилгээ холбогдоод байна. Үүнд:<br>1.Газрын кадастрын нэгж талбарын тодорхойлолт;<br>2.Газар эзэмших эрхийн лавлагаа;<br>3.Үнэгүй газар өмчилсөн эсэх лавлагаа;<br>4.Газрын төлбөрийн тооцоо нийлсэн лавлагаа;<br>5.Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа; | 100% |